



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2023 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 10 ДУГААР САРЫН 26-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
НЭГДСЭН ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2023 оны 10 дугаар сарын 26-ны өдөр, Пүрэв гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2-5
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	6-53
<i>1.Тусгай хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай</i>	6-9
<i>2.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Засгийн газар 2023.10.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	9-48
<i>3.Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.09.29-ний өдөр Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжилнэ/</i>	48-53

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы
10 дугаар сарын 26-ны өдөр /Пүрэв гараг/-ийн нэгдсэн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 72 гишүүнээс 38 гишүүн хүрэлцэн ирж, 52.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 08 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Ц.Анандбазар, Х.Болорчулуун, С.Бямбацогт, Ж.Ганбаатар, Б.Дэлгэрсайхан, Г.Мөнхцэцэг, Л.Оюун-Эрдэнэ;

Чөлөөтэй: Н.Алтанхуяг, Ё.Баатарбилэг;

Эмнэлгийн чөлөөтэй: Г.Дамдинням;

Хоцорсон: Ш.Адъяаа-01 минут, А.Адъяасүрэн-09 минут, С.Амарсайхан-38 минут, С.Батболд-2 цаг 08 минут, Ж.Бат-Эрдэнэ-11 минут, Б.Баярсайхан-14 минут, Х.Булгантуяа-27 минут, С.Ганбаатар-2 цаг 29 минут, Д.Ганбат-19 минут, Ц.Даваасүрэн-14 минут, Л.Мөнхбаатар-12 минут, С.Одонтуяа-18 минут, Д.Өнөрболор-52 минут, Ж.Сүхбаатар-1 цаг 29 минут, Ц.Сэргэлэн-01 минут, Н.Учрал-27 минут, Д.Цогтбаатар-07 минут, Б.Чойжилсүрэн-06 минут, Б.Энх-Амгалан-08 минут, Т.Энхтүвшин-2 цаг 02 минут, Ж.Эрдэнэбат-28 минут.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржоос албан бичиг ирүүлснийг танилцуулж, Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж үг хэлэв.

Нэг.Тусгай хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ж.Чимгээ, референт Б.Гандиймаа нар байлцав.

Тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Г.Занданшатар: “Тусгай хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 32
Татгалзсан: 14
Бүгд: 46
69.6 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар “Тусгай хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./10.19/

Уг асуудлыг 10 цаг 19 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Засгийн газар 2023.10.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын шүүгч Б.Батцэрэн, Ч.Хосбаяр, Улсын ерөнхий прокурорын орлогч, төрийн хууль цаазын шадар зөвлөх М.Чинбат, Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Шүүхэд төрийг төлөөлөх хэлтсийн дарга О.Мөнхбаатар, Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Л.Галбадрах, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал Х.Эрдэм-Ундрах, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Тэргүүн дэд дарга бөгөөд Хорих ял эдлүүлэх албаны дарга Б.Нандинболор, мөн газрын Дэд дарга Ч.Нэргүй, Цагдаагийн ерөнхий газрын Захиргаа удирдлагын газрын дарга Л.Нямдаваа, мөн газрын Экологийн цагдаагийн албаны Дэд дарга Б.Батсуурь, Тагнуулын ерөнхий газрын Мөрдөн шалгах газрын дарга Д.Энхтөр, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын мэргэжилтэн Ц.Лхагвацэнд, Монголын хуульчдын холбооны гишүүн, хуульч Б.Батзориг, Монголын өмгөөлөгчдийн холбооны ерөнхийлөгч Л.Данзанноров, Хууль зүй, дотоод хэргийн сайдын зөвлөх Д.Мөнх-Эрдэнэ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Төгсцэнгэл, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөхийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Золжаргал, референт П.Хулан нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж нар танилцуулав.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн, Ц.Мөнх-Оргил, Ц.Сандаг-Очир, Ц.Сэргэлэн, Ш.Раднаасэд, Л.Мөнхбаатар, С.Одонтуяа, Н.Энхболд, Н.Ганибал, Д.Сарангэрэл, О.Цогтгэрэл, Ш.Адьяа, Б.Бат-Эрдэнэ, Г.Ганболд, Д.Ганбат нарын тавьсан асуултад Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын шүүгч Б.Батцэрэн, Ч.Хосбаяр, Улсын ерөнхий прокурорын орлогч, төрийн хууль цаазын шадар зөвлөх М.Чинбат нар хариулж, тайлбар хийв.

Үдээс өмнөх хуралдаан 2 цаг 51 минут үргэлжилж, 12 цаг 59 минутад завсарлав.

Үдээс хойших хуралдаан 13 цаг 58 минутад Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлаар үргэлжлэв.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг, Н.Энхболд, Г.Амартүвшин нар дэмжиж үг хэлэв.

Г.Занданшатар: Байнгын хорооны саналаар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 18
Бүгд: 42
57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 14 цаг 22 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.09.29-ний өдөр Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжилнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Баярбат, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Дэд дарга Б.Баасандорж, мөн газрын Хууль, эрх зүйн газрын референт О.Дөлгөөнтуул, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын дарга А.Энхманлай, Хууль, хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга Д.Энхтуяа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Н.Мөнхзэсэм, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул нар байлцав.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлаар Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс авсан завсарлага дууссаныг мэдэгдэв./14:25/

Г.Занданшатар: Байнгын хорооны саналаар Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 18
Бүгд: 42
57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 14 цаг 25 минутад хэлэлцэж дуусав.

Бусад. Улсын Их Хурлын гишүүн П.Анужингийн урилгаар Нийслэлийн ерөнхий боловсролын 12 дугаар сургууль, 277 дугаар цэцэрлэгийн багш, ажилчид, Монгол Улс дахь Олон улсын эмэгтэйчүүдийн нийгэмлэгийн гишүүд, төлөөлөгчид, Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ, Ц.Анандбазар нарын урилгаар Булган аймгийн Цаг уур, орчны шинжилгээний төвийн албан хаагчид, Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам, Ж.Эрдэнэбат, Д.Өнөрболор нарын урилгаар Сэлэнгэ аймгийн Сайхан сумын ахмадын төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаагийн урилгаар Ховд аймгийн музейн албан хаагчид, Улсын Их Хурлын гишүүн С.Амарсайхан, Ц.Сандаг-Очир нарын урилгаар Багахангай дүүргийн иргэдийн төлөөлөл Төрийн ордон, Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаатай танилцав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч С.Энхзаяа, шинжээчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Мөнхцоож нар хариуцан ажиллав.

Хуралдаан 3 цаг 19 минут үргэлжилж, 72 гишүүнээс 62 гишүүн хүрэлцэн ирж, 86.1 хувийн ирцтэйгээр 14 цаг 26 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 10 дугаар сарын 26-ны өдөр,
Пүрэв гараг Төрийн ордон “Их
хуралдай” танхим 10 цаг 08 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Занданшатар: Гишүүдийн
өдрийн амгаланг айлтгая.

Хурлын ирц бүрдсэн тул Улсын Их
Хурлын 2023 оны намрын ээлжит
чуулганы 10 дугаар сарын 26-ны өдрийн
нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье ээ.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар
хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Тусгай хяналтын дэд хорооны
бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай
асуудал.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх
тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах
тухай хуулийн төсөл болон хамт өргөн
мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх
эсэх асуудлыг хэлэлцэнэ.

Иргэний хэрэг шүүхэд хянан
шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах
тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх
асуудлыг шийднэ.

Газрын тухай хуульд нэмэлт
өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл
хэлэлцэх эсэхийг үргэлжлүүлэн хэлэлцэнэ
ээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы
хуралдааны дэгийн тухай хуулийн 13.4-д
гишүүн энэ хуулийн 9.5-д заасан нэгдсэн
хуралдаанаар хэлэлцэхээр тогтсон
асуудлыг хойшлуулах дараалал өөрчлөх,
асуудал нэмэх горимын санал гаргах бол
чуулган эхлэхээс өмнөх өдрийн 17 цагаас

өмнө үндэслэл бүхий саналаа бичгээр
ирүүлнэ гэж заасны дагуу Улсын Их
Хурлын гишүүн Бөхчулууны Пүрэвдорж
ирүүлсэн албан бичиг ирүүлсэн байна.

Уншиж танилцъя.

Миний бие ард 2023 оны 10 дугаар
сарын 26-ны өдрийн чуулганы хуралдаанд
хэлэлцэх асуудлын дараалалтай
холбоотойгоор үг хэлэх зөвшөөрөл олгоно
уу? Улсын Их Хурлын гишүүн багш нарын
Пүрэвдорж гэсэн байна. Пүрэвдорж
гишүүн үг хэлнэ.

Б.Пүрэвдорж: Сая амралтын өдөр
өдрөөр Ховд аймгийн хэдэн сум, багаар
явж ажиллаад ирлээ. Ховд аймгийн
Мянгад сумын Цагаанбулан багийн Нямаа
ах Монгол эр хүнийг морьд чимдэг ээ,
цустай адуу уралдсанаас болоод
хөдөөгийн бид морь уяхаа болилоо.

2021 оны баруун бүсийн даншиг
наадамд нийтдээ 340 их нас мордож
байсан юм. Гэтэл Баяр наадмын хууль
батлагдаад морьдын хэмжээг өсгөөд их
нас метр 41-тэй болсноос хойш тэр 2022
онд болсон Чандмань суманд болсон
баруун бүсийн даншиг наадамд дөчин
хоёрхон их нас уралдлаа. Хуулиас чинь
болоод хөдөөгийн хөх уяачид бид нар алга
болж эхэлж байна шүү энэ хуулиа
анхаараарай гэж байна. Үенч сумын
ахмад багш Алтай тэтгэвэрт анхаарч
өгөөч ээ. Ирэх онд инфляцын дагуу 10
хувиар тэтгэвэр нэмэх юм байна. Дахиад
л 50 мянган төгрөгөөр нэмэгдүүлэх үү?
Тэтгэврийн доод хэмжээг сая төгрөг
болгож өг өө. Тэгээд энэ зөрүүгээ идэж
ууж байгаа нөхдүүдийг хөрөнгийг нь
хурааж аваад тэрийгээ борлуулаад бид
нарын тэтгэврийг нэм гэж шаардлага
тавьж байна.

Булган сумын Байтаг багийн ахмад
Данзай гуай Байтаг баг 383 өрхтэй. Олон
булаг, Байтаг, Уушиги, Харганат хавиар
дал гаруй өрх 70 мянган малтайгаар

өвөлжиж хаваржиж намарждаг. Гэтэл энэ хавийн нутгийг тусгай хамгаалалттай газар болгоод тэгээд бид нарыг хаа байсан Говь-Алтай аймгийн албан тушаалтнууд ирж нутгаас минь хөөж байна. Бид хэдэн зууны турш тэр Хулан гэдэг амьтантай чинь амьдраад болоод ирсэн. Зах нутгийг бид нар ер нь малчид бид нар хамгаалж байгаа. Зах нутгаас биднийг хөөдөг нь аль улсын бодлого юм бэ? Ер нь малчин бид нар тэр хил орчим нутаглаж энэ Монголын нутаг юм гэдгийг дархалж яваа ийм ард түмэн шүү гэдгийг хэлж байна. Энэ талаар би Бат-Эрдэнэ сайдтай бас уулзаж шаардлага тавина.

Мянгад сумын Баянбулаг Чацарганат билүү багийн иргэн малчин Бямбажав гуай Мал махны үнэ муу байна. 2009 онд бодын шир 45 мянга, хонины нэхий 12 мянга байсан. Гэвч Засгийн газар малын түүхий эд боловсруулж байж экспортлоно гэж шийдвэр гаргаад тэрнээс хойш Хятадууд энэ бизнесээс гарч явсаар өрсөлдөөн байхгүй үнэ унасаар шир 5 мянга, нэхий 500 төгрөг боллоо. Үйлдвэрлэлийн хүчин чадал хангалттай биш байхад энэ шийдвэр буруу байсан. 15 жил болоход арьс ширний үйлдвэр нэг ширхэг ч нэмж байгуулагдсангүй ээ.

Тийм учраас Засгийн газар энэ тогтоолоо боловсруулж гаргах тогтоолоо 2 сард хүчингүй болгосон юм байна. Гэвч энэ тогтоолоо дэлхийд ялангуяа Хятадад сурталчлах талаар ажиллахгүй байна.

Дээрээс нь хил гаалиар түүхий эд гаргах талаар ажиллахгүй байна. Хэрвээ дурын хилээр гаргах юм бол би Чацарганат багийнхаа малын арьс ширийг цуглуулаад дээр үеийнх шиг Хятадын хил дээр очоод гурил, будаагаар солиод аваад ирнэ ээ. Хэрвээ ингэж хүн болгон энэ бизнесийг хийх юм бол өрсөлдөөний үндсэн дээр малын түүхий эд өснө шүү гэж ярьж байна. Үгүй ээ энэ

Засгийн газраас илүү ухаантай малчин хүн байх. Та нар юу л хийгээд байдаг юм? Ингээд эцэст нь Занданшатар даргад хандаж үг хэлмээр байна. Ардчилсан намын бүлэг НӨАТ-ын татварыг 5 хувь болгох буцаан олголт нь 2 хувь ер нь бол төлөх нь 3 хувь болгохоор энэ хуулийн төслийг өргөн бариад явж байсан. Гэтэл ингээд манай Ардын нам дандаа ингэж нэг тийм бид нарын хийж байгаа сайн хуулийг нэг баллуурдах замаар. Ингээд бас хууль оруулж ирдэг ээ.

Занданшатар дарга НӨАТ-ын буцаалтыг 5 хувь болгох ийм хуулийн төслийг олон нийтийн анхааралд оруулаад хэлэлцүүлээд 100 мянга гараад явчихлаа. Одоо наадах хэлсэн үгэндээ ороод тэр хуулиа хурдан батлуулах талаар, өргөн барих талаар ажилла. Тэгээд одоо энэ сайд нар бас янз янзын юм яриад байх юм. Энэ парламентын засаглалтай орон шүү. Тийм учраас бас янз янзын юм яриад хэрэггүй. Тэгэхээр би та нарт нэг ухаан зааж өгье. 2024 оны төсөв орж ирчихсэн тэр төсөв дээр одоо НӨАТ-ын татварыг нааш цааш болгох нь асуудал байгаад байгаа юм бол энэ НӨАТ-ын тухай хуулиа оруулж ирээд Занданшатар дарга оруулж ирдгээрээ оруулж ирээд хуулиа 2025 оны 1 сарын 1-нээр хэрэгжихээр тэгээд батлаад яв даа. Тэгэх юм бол энэ ард түмэн чинь бас энэ татварын дарамтаас илүү гайгүй болох ийм л боломжийг бий болгох юм.

Ер нь бол эр хүн зорьсондоо эмээлт морь харайсандаа гэдэг үг байдаг байдаг. Замын дундаас буцчихав Занданшатар дарга аа.

Г.Занданшатар: Хэлэлцэх асуудалдаа орно.

Тусгай хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай асуудлыг хэлэлцэнэ.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг

Улсын Их Хурлын гишүүн Нанзадын Наранбаатар танилцуулна.

Н.Наранбаатар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6 дахь заалт 28 дугаар зүйлийн 28.5 дахь хэсэг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3 дахь хэсэгт заасны дагуу Тусгай хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2023 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаараа дахин авч хэлэлцлээ.

Тус Байнгын хорооны 2023 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанаар Улсын Их Хурлын дарга Занданшатарт Улсын Их Хурал дахь дахь МАН-ын бүлгийн дарга Тогтохсүрэн, Улсын Их Хурал дахь АН-ын бүлгийн дарга Цогтгэрэлээс Улсын Их Хурлын гишүүн Баагаагийн Баттөмөр, Их Хурлын гишүүн Одонтуяа нарыг Тусгай хяналтын дэд хорооны гишүүнээр томилуулах тухай ирүүлсэн саналыг хэлэлцэж дэмжсэн бөгөөд Тусгай хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн юм.

Дээрх Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурлын 2023 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх үед Улсын Их Хурал дахь АН-ын бүлгийн дарга Цогтгэрэлээс Тусгай хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай асуудлыг бүлгээрээ дахин зөвшилцөх шаардлагатай байгаа тул завсарлага авах санал гаргасан тул хэлэлцүүлэг хойшлогдсон.

Улсын Их Хурал дахь АН-ын бүлгийн дарга Цогтгэрэл 2023 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанд завсарлагааны хугацаа дуусгавар болсноо мэдэгдэж Улсын Их Хурлын дарга Занданшатарт тус намын бүлгээс Улсын Их Хурлын гишүүн Дашидондогийн Ганбатыг Тусгай хяналтын дэд хорооны гишүүнээр томилуулах тухай саналаа ирүүлсэн тул энэ асуудлыг дахин хэлэлцүүлэхээр Байнгын хороонд шилжүүлсэн.

Байнгын хорооны хуралдаанаар дээрх асуудлыг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Одонтуяа Дэд хорооны гишүүнд дэвшүүлсэн өөрийн нэрээ татан авснаа мэдэгдээд Тусгай хяналтын дэд хорооны гишүүнээс мансууруулах эм сэтгэцэд нөлөөлөл бодисын хууль бус эргэлт, хар тамхитай тэмцэх талаар гаргаж байгаа саналыг дэмжиж хэлэлцэж өгөхийг хүссэн болно оо.

Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх Улсын Их Хурлын гишүүн Баагаагийн Баттөмөр, Дашидондогийн Ганбат нарыг Тусгай хяналтын дэд хорооны гишүүнээр томилохыг дэмжсэн бөгөөд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.5 дахь хэсэгт заасны дагуу Байнгын хорооноос боловсруулсан Тусгай хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Тусгай хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэж, уг тогтоолын төслийг баталж өгөхийг та бүхнээс хүсье ээ.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: *Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүн байна уу? Алга байна.*

Тусгай хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна.

Чөлөө авсан энэ үүдэнд байгаа.

Санал хураалт явуулъя.

69.6 хувийн саналаар санал дэмжигдэж тогтоолын төсөл батлагдлаа.

Тогтоолыг уншиж танилцуулъя.

Тусгай хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6 дахь заалт 28 дугаар зүйлийн 28.5 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3, 26.5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:

1. Монгол Улсын Их Хурлын гишүүн Баагаагийн Баттөмөр, Дашидондогийн Ганбат нарыг Улсын Их Хурлын Тусгай хяналтын дэд хорооны гишүүнээр баталсугай.

Энэ тогтоолыг 2023 оны 10 дугаар сарын 26-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг.

Эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна.

Эцсийн найруулгыг сонсонд тооцлоо.

10.19 цагт

Дараагийн асуудалд оръё.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ ээ.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Баттөмөрийн Энхбаяр танилцуулна. Индэрт урьж байна.

Б.Энхбаяр: *Улсын Их Хурлын эрхэм дарга, гишүүд ээ,*

Монгол Улсын Засгийн газраас Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний халдашгүй чөлөөтэй байх үндсэн эрхийг шүүхийн хяналтад оруулж баталгаажуулах чиглэлд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүллээ. Өнгөрсөн онд НҮБ-ын дур зоргоор саатуулах асуудал эрхэлсэн Ажлын хэсгийн дүгнэлт болон энэ оны хавар Улсын Их Хурлаас баталсан Хүний эрхийн Үндэсний Комиссын 22 дахь тайлан илтгэлийн мөрөөр авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолыг хэрэгжүүлэх хүрээнд дээрх хуулийн төслийг боловсруулсан болно оо.

Шүүх сүүлийн 3 жилд шүүхийн зөвшөөрөлтэй болон зөвшөөрөлгүй баривчлах ажиллагаа явуулсан судалгааг 3 жилийн байдлаар авч үзэхэд нийт сээжигтнийг шүүхийн зөвшөөрөлгүй баривчилсан баривчилгааны 60-аас дээш хувийг хойшлуулишгүй тохиолдол гэдэг үндэслэлээр баривчилсан байна.

Шүүхийн зөвшөөрөлгүй баривчлаад үргэлжлүүлэн цагдан хорьсон

тохиолдол 2020 онд 56.4 хувь, 2021 онд 61.3 хувь, 2022 онд 55.5 хувийг тус тус эзэлж байна. Сэжигтнийг шүүхийн зөвшөөрөлгүй баривчлах ажиллагаа 2020 онд 798 хийгдсэнээс 22.3 хувь нь 2021 онд 821 хийгдсэнээс 19.6 хувь нь шүүхээр хянагдсан байна.

Дээрх судалгаа болон дүгнэлтээ үзэхэд НҮБ-ын дур зоргоор саатуулах асуудал эрхэлсэн ажлын хэсгийн урьдчилсан дүгнэлтэд гарсан Монгол Улсад сэжигтнийг баривчлах ажиллагааны 98-аас 99 хувийг шүүхийн зөвшөөрөлгүй хийгдэж байна гэдэг дүгнэлтэд үндэслэл байна.

Бид дутагдлаа нуухыг хүссэнгүй ээ. Асуудалд бодитой хандаж үнэхээр энэ дүгнэлтийн иш үндэс нь хууль тогтоомжид байгаа эсэх асуудлыг судалж үзэж хуулийн зөрчил хийдлийг арилгах чиглэлд анхаарал хандуулж ажиллалаа.

Сүүлийн 8 жилд нийтдээ 238 мянган гэмт хэрэг бүртгэгдэж энэхүү нийт бүртгэгдсэн гэмт хэрэгт 150 мянган хүн сэжиглэгдэж шалгагдсан байна. Эндээс 9261 буюу 6.15 хувийг нь баривчилсан байна. Баривчлах ажиллагаа сэжигтнийг 24 болон 48 цагийн хугацаагаар хэрэгжиж байгаагаас дийлэнх хувь нь 48 цагийн хугацаатай хойшлуулшгүй баривчилж байна.

Нийт баривчлах үйл ажиллагааны хувьд авч үзэхэд дийлэнх хэрэг нь цагдаагийн байгууллагын харьяаллын гэмт хэрэгт холбогдож байна. Цагдан хоригдсон нийт хугацааг авч үзэх юм бол 65 орчим хувь нь 1-6 сарын хугацаагаар цагдан хоригдсон байна. 1-3 сарын хугацаагаар 3 хүн тутмын нэг нь цагдан хоригджээ гэдэг судалгаа сүүлийн 8 жилийн гарч ирж байна.

Энэ дотроос хамгийн гол асуудал нь үнэхээр гэмт хэрэгт холбогдсон сэжигтэй этгээдийг цагдан хорьж

байгаа эсэх асуудлыг бид цагдан хоригдсон этгээдийг цаашид шүүх рүү шилжүүлж байгаа эсэх тэр судалгаанаас авч үзлээ.

2017 оны 7 сарын 1-ээс үйлчилж эхэлсэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн үр нөлөө нэн их байна. Энэхүү хууль тогтоомж үйлчилж эхлэхээс өмнө цагдан хоригдсон 5 хүний нэг нь цаашаа шүүх рүү шилждэг байсан байна. Шүүхээр гэм буруутай эсэх нь нотлогдоогүй 5 хүний 4-ийг цагдан хорьж байсан байна. Харин 2017 оноос эхлээд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай шинэ хуулийн үйлчлэлийн үр нөлөөгөөр сүүлийн 6 жилийн хугацаанд цагдан хоригдсон 5 хүний 4 шүүх рүү шилжиж байгаа нь цагдан хорих үндэслэл, хязгаарлалт журмуудыг шинэ хууль тогтоомжоор тодорхой болгосонтой холбоотой байна.

Тэгэхдээ бид сэтгэл ханах болоогүй байна. Цаашид цагдан хорионы асуудал дээр хэд хэдэн зарчмын өөрчлөлтийг хийх саналыг Засгийн газраас дэвшүүлж байна.

Нэгдүгээрт, манай улс хөнгөн гэн хөнгөн болон хүндэвтэр төрлийн гэмт хэрэгт цагдан хорьж байгаа дээд хугацаанд дэлхийн дунджаас 2-оос 6 дахин урт хугацаатай байна.

Бидний хойд хөрш ОХУ, Франц улс, Япон улс хөнгөн гэмт хэрэгт цагдан хорих дээд хугацаа 2 сарын хугацаатай байна. Герман улс 6 сарын хугацаатай байна. Бид хөнгөн гэмт хэрэгт цагдан хорих хугацаа 12 сар буюу нэг жилийн хугацаатай байна.

Хүндэвтэр гэмт хэрэгт цагдан хорих дээд хугацаа 18 сар буюу жил 6 сарын хугацаатай байна. Тийм учраас Эрүүгийн хуульд заасан хөнгөн төрлийн гэмт хэрэгт цагдан хорих хугацааг 2 дахин багасгаж 6 сарын хугацаатай болох, хүндэвтэр төрлийн хэргүүд дээр

цагдан хорих хугацааг нэг жилийн хугацаатай болгох замаар 2 дахин цагдан хорих хугацааны хугацааг багасгах саналыг дэвшүүлж байна.

Түүнчлэн цагдан хорих байранд гүйцэтгэх ажил хийх буюу хорьж мөрдөх арга барилыг хууль сахиулах байгууллагын хүрээнд таслан зогсоох зорилгоор цагдан хорих байранд гүйцэтгэх ажиллагаа хийх асуудлыг хязгаарлахаар санал дэвшүүлж байна. Зөвхөн хүнийг санаатай алах, бага насны хүүхдийг хүчиндэх, хүн төрөлхтний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, авлига албан тушаалын гэмт хэрэг, хар тамхи, мансууруулах бодисыг зохион байгуулалттайгаар худалдаалах гэмт хэргүүдэд цагдан хорих байранд гүйцэтгэх ажил хийж болох юм гэж үзэж байна.

Дээрх 6 төрлийн гэмт хэргээс бусад тохиолдолд цагдан хорих байранд гүйцэтгэх ажил хийхийг шууд хязгаарлахаар оруулж ирлээ.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуульд орж байгаа дараагийн нэг өөрчлөлт бол сонгуулийн хууль, тогтоомжийн зөрчилтэй холбоотой хэргийг 2020 онд Улсын Их Хурлын сонгуульд өөрчлөх замаар харьяаллыг тагнуулын байгууллагад шилжүүлсэн.

Энэ асуудлыг өмнөх хууль тогтоомжийн адил цагдаагийн байгууллага үргэлжлүүлж хэвээр хийх нь зүйтэй гэж үзэж байгаа. Дэд бүтцийн хувьд, хүн хүчний хувьд, зохион байгуулалтын хувьд тагнуулын байгууллага улсын хэмжээний ийм өргөн хүрээтэй олон мянган нэр дэвшигчтэй ийм хэргийг хянан шийдвэрлэх бас боломж, практик алга байна.

Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлсэн Эрүүгийн хэрэг хянан

шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэж өгөхийг хүсье ээ.

Баярлалаа.

Г.Занданшатар: Төслийн талаар Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Бөхчулууны Пүрэвдорж Төсвийн зарлагын хяналтын дэд хороон дарга танилцуулна. Индэрт урьж байна.

Б.Пүрэвдорж: Сайн байцаана уу? Тэгэхээр би эрх баригчдын өргөн барьсан хуулийн төслийг сөрөг хүчний гишүүний хувьд уншдаггүй, танилцуулгыг. Энэ төслийг уншиж байгаа шалтгаан бол энэ хуулийн төсөл бол хүний эрхийг дээдэлсэн дээрээс нь ялангуяа хүний эрхийн комисс Монголын хүний эрхийн талаарх тайланг сонсдог 2023 онд энэ хуулийн төсөл бол Монголын талаар маш их эерэг үр дүнг авчрах нэлээн хэдэн оноо цуглуулах мөн түүнчлэн Монгол Улс хүний эрхийн талаар нэлээн хэдэн байр урагшлуулах ийм хуулийн төсөл болсон учраас би энэ танилцуулгыг уншиж байгаа юм.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 10 дугаар сарын 20-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Хууль зүйн байнгын хороо 2023 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ. Хууль санаачлагч сэжигтнийг баривчлах, ялагдагчийг цагдан хорих асуудлыг хянан шийдвэрлэх. Шүүхийн харьяалал, сэжигтнийг баривчлах, ялагдагчид цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээ авах ажиллагаанд тавих шүүхийн хяналтыг тасралтгүй хэрэгжүүлэх, ялагдагчийг цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээний хугацаа сунгах,

сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг өмгөөлөгчөөр хангах хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагааг боловсронгуй болгох, ард нийтийн санал асуулга хууль бусаар явуулах улсын онц чухал объект онц чухал мэдээллийн дэд бүтцийн байгууллага байгууламжийн үйл ажиллагаанд саад учруулах, гэмт хэрэгт тооцох өөрчлөлттэй уялдуулан хэргийн харьяаллыг тогтоох, хүндрүүлэх нөхцөл байдалтай залилах гэмт хэргийн цагдан хорих хугацааг шаардлагатай бол сунгах, сэжигтнийг хойшлуулалгүйгээр баривчлах, яллагдагчийг цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээний үндэслэлийг тодорхой болгох, гомдол гаргахтай холбоотой зохицуулалтыг боловсронгуй болгох, сонгуулийн хэргийг хянан шийдвэрлэх харьяаллыг цагдаагийн байгууллагад хамааруулах, цагдан хорих байранд мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулахыг зөвшөөрсөн зэргээс зарим хэргийг хасах зэрэг зохицуулалтыг тусган хуулийн төслийг боловсруулсан байна.

Хуулийн төсөл болон батлагдсанаар шинээр зардал гаргахгүй. Харин хязгаарлалт тогтоох, таслан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбоотой зардал гаргах бөгөөд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд дээрх арга хэмжээг 2025 оноос хэрэгжүүлэхээр тусгасан гэж хууль санаачлагч үзсэн бөгөөд хуулийн төслийг www.D-parliamentdot.mn сайтад байршуулж иргэд олон нийтийн саналыг авч байгаа болно оо.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг хуулийн төслийг үзэл баримтлалын хувьд дэмжиж байгаагаар илэрхийлээд өргөн мэдүүлсэн уулийн төсөлд үндэслэлгүй цагдан хоригдсон шүүхийн зөвшөөрөлгүй хоригдсон этгээдийн хэдэн хувийг прокурор хяналт тавьж сулласан талаар тоо баримт бий эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж хуулийн

төсөлд тодорхой ажил хийхгүйгээр мөрдөн шалгах хугацааг сунгаж хүний эрх зөрчиж байгаа асуудлыг зохицуулсан эсэх мөн давж заалдах, хяналтын шатын шүүхээс прокурорт хэргийг буцаах заалт хүчингүй болсноос хойш буцаасан хэрэг байгаа эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьяаа хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж байгаагаар илэрхийлж цагдан хорих байранд мөрдөн шалгах ажиллагаа явуулахгүйгээр малын хулгайн асуудлыг шийдвэрлэх боломж байгаа эсэх, мөрдөх байгууллага, амралт, баярын өдөр, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг хойшлуулалгүйгээр баривчлах саатуулах шаардлага гарвал шүүх прокурорын асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар хуулийн төсөлд мөрдөн шалгах ажиллагааг явуулах, хийх, хориглох болон зөвшөөрөх талаар тодотгож өгснөөр алинд нь ч хамаарахгүй гэмт хэрэг үйлдэх эрсдэл байгаа эсэх талаар асуулт асууж хариулт авсан болно оо.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 60 хувь нь үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Эрүүгийн хянан хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаар Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье ээ.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Дэмбэрэлцэрэнгийн Мөнх-Эрдэнэ Хууль зүй, дотоод хэргийн сайдын зөвлөх, Батаагийн Батцэрэн Улсын Дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын шүүгч, Максимын Чинбат УЕП-ын орлогч, Отгонбаярын Мөнхбаатар УЕП-ын туслах прокурор Шүүхэд төрийг төлөөлөх хэлтсийн дарга, Лхагвасүрэнгийн Галбадрах ЧД-ийн Эрүүгийн хэргийн анхан шатын шүүхийн шүүгч, Хүрэлбаатарын Эрдэм-Ундрах Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал, Бямбажавын Нандинболор Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Тэргүүн дэд дарга бөгөөд Хорих ял эдлүүлэх албаны дарга, Чимэдоржийн Нэргүй Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын тэргүүн дэд дарга бөгөөд хорих ял эдлүүлэх албаны дэд дарга, Лхамдоржийн Нямдаваа Цагдаагийн ерөнхий газрын Захиргаа удирдлагын газрын дарга, Баттөмөрийн Батсуурь Цагдаагийн ерөнхий газрын Экологийн цагдаагийн албаны дэд дарга цагдаагийн хурандаа, Дашийн Энхтөр Тагнуулын ерөнхий газрын Мөрдөн шалгах газрын дарга, Цэрэнсүрэнгийн Лхагвацэнд Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын мэргэжилтэн, Бадамын Батзориг Монголын хуульчдын холбооны гишүүн хуульч, доктор, дэд профессор, Лхагвын Данзанноров Монголын өмгөөлөгчдийн холбооны ерөнхийлөгч.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд нэрээ бүртгүүлнэ ээ.

Өөр хүн байвал сайн бүртгүүлж аваарай. Дашдондогийн Ганбат гишүүнээр тасаллаа. Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн асуулт асууна.

Ц.Даваасүрэн: Энэ бол бас маш чухал хууль. Хуулийн төслийг дэмжиж байгаа.

Зүгээр би энэ хуулийн төсөлтэй холбогдуулаад бас нэг иргэдээс хэлээч гэсэн ганц 2 зүйлийг бас хэлье гэж ингэж бодож байгаа юм.

Сүүлийн үед энэ хүний эрх зөрчигдөж байгаа асуудал бол нэлээн яригддаг боллоо. Ер нь баривчилгаа энэ асуудал дээр тухайлах юм бол нэг ийм зүйлийг надад ярьж байна л даа. Одоо ингээд гэрт нь нэгжлэг хийлээ гээд л ингээд л зурагтаар баахан мэдээлэл явдаг шүү дээ. Тэдний гэрийг яаж гэнэ гээд л. Тэгэхдээ бас хүний эрх зөрчдөг юм байна. Тэнд чинь ингээд л хүүхдүүд, бага насны хүүхдүүд байдаг бололтой юм шиг байна. Тэр надад ярьсан хүнийхээр бол. Тэгээд одоо яг л энэ нөгөө энэ Газын зурваст болж байгаа юм шиг л ингээд л гэрийг нь тэгээд л хаячихдаг юм байна л даа. Тэгээд хүүхдэд маш том стресс өгдөг. Тэгээд хүүхэд нь тэрнээсээ болоод сэтгэцийн өөрчлөлттэй болоод тэгээд шөнө ингээд орилж сэрдэг болчихсон. Ингээд манай хүүхэд ийм болчихсон гишүүн ээ та энэ тал дээр бас анхаараач гэж байгаа байхгүй юу.

Тэгэхээр ийм зэрлэг балмад бүдүүлэг байж болохгүй ээ. Бүгд хүүхэдтэй. Энэ гүйцэтгэх ажил хийж байгаа хүмүүд ч гэсэн бас жоохон бодох хэрэгтэй. Бид бүгдээрээ хүүхэдтэй шүү.

Тийм учраас тэнд ингээд хүүхэд байгаа бол тусгаарлах арга хэмжээг нь авуулаад тэдэнд цочирдуулахгүй байдал үүсгээд ингэж нэгжлэг хийдэг ийм байдал энэ тэр лүү орохгүй бол наад захын хүний эрх бол ингэж зөрчигддөг юм байна. Тэр аав ээжийн хийсэн гэмт хэрэгт тэр нялх үр нь ямар ч хамаа байхгүй шүү дээ. Ямар ч холбогдолгүй байхгүй юу.

Тийм учраас ялангуяа бага насны хүүхдүүдэд бол тэгж стресс өгнө гэдэг бол насны сэтгэцийн гэмтэл авчрах ийм аюултай. Тэгээд ийм зүйлүүд дээр анхаармаар байна. Тэгээд ялангуяа энэ шүүх, хуулийн байгууллагуудын нэр хүнд

сүүлийн үед маш их унаж байна. Сая тойрогт ажиллаж байхад ерөөсөө ярьж байгаа юм тэр нэг Баярцогтын талаар гаргасан шүүхийн шийдвэр. Шүүхэд ард түмэн итгэхээ больчихсон. Тэгээд баялгаа эх орноо худалдчихсан хүнийг ингээд цайруулж байна гээд л ийм юм яриад. Нэг талаараа тийм шүү дээ. Нэгэнт шүүх нь шийдсэн юм бол тэрийгээ буцаагаад цайруулж байна гэдэг. Шүүх өөрөө өөрийгөө үгүйсгэсэн ийм алхмууд болж байгаа энэ тэр чинь бол нийгэмд энэ хүчний байгууллагуудын нэр хүндийг унагасан ийм зүйл итгэх итгэлгүй болгосон ийм зүйлүүдийг л ярьж байна л даа.

Жишээлбэл малын хашааны мод авах гээд залуу гэр бүл тэгээд 30-аад сая төгрөгөөр торгуулсан юм байна. Тэгээд тэгээд байгаа юм. Үгүй ээ энэ 3 тэрбум төгрөгийн хэрэг хийсэн тэр 40 сая төгрөгийн торгууль аваад байх юм. Тэгээд энэ 2-т ямар ялгаа байна гэх мэтийн. Яах вэ нийгэм нэг талаасаа бол их тийм шүүмжлэх талд юмыг ингээд буруу өнцгөөр харах тал руугаа хазайчихсан байна.

Гэхдээ огт худлаа зүйл бас тэд ярихгүй байна шүү дээ. Яг үнэн зүйлийг л яриад байна шүү дээ. Ингээд ийм цаг үед бол бас энэ энэ хууль орж ирж байгаа нь бас зөв байх. Ер нь хүнийг энэ манай мөрдөн шалгах ажиллагаа энэ явагдаж байгаа зүйлүүд бол яг л нөгөө хуучин социализмын үеийн тэр арга барил нь хэвээрээ байгаад байх шиг байгаа юм. Тэр Орост хэрэглэгдэж байгаа энэ арга зүй энэ техникүүд яг хэвээрээ.

Тэгэхээр ерөөсөө 1 зүйлийг бид нар энэ хуульд хиймээр байгаа юм. Энхбаяр сайд аа. Одоо энэ Европ, энэ Америкийн энэ нэг гүйцэтгэх ажлын юмыг харж байхад хүн амины хэрэгтэй ч байсан гүйцэтгэх ажлаа нотолж чадаагүй барьж чадахгүй байгаа байхгүй юу. Нөгөөдөх нь бараг доромжлоод л байж байна шүү дээ. Та нар хүн амины хэрэгт

сэжиглэгдэж байгаа. Тэгэхдээ барьж чадахгүй нөгөөдөх нь бол та нар нотолчих доо гээд л. Тэгэхэд манайх зүүгээр л одоо аюултай нөхцөл байдлаас тусгаарлаж байна гэдэг ч юм уу.

Г.Занданшатар: Баттөмөрийн Энхбаяр сайд хариулъя.

Б.Энхбаяр: Эрүүгийн хэрэг хянан шийдвэр тухай хууль бол гэмт хэрэг үйлдсэн тэр бодит байдлыг тогтоож, ял завиуулахгүй байх, олж тогтоох, шүүхээр шийдвэрлэх, үнэн мөнийг эцэслэх процесстой холбоотой хууль байгаа. Тэгэхээр бид процессын хууль тогтоомжид бас их анхаарал хандуулалгүй ялангуяа энэ эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны энэ нотлох процесс дээр хүний эрхийг хангах, хүний эрх гэдэг нь бүх талын эрхээр гэж байгаа юм. Сэжигтний эрх, хохирогчийн эрх, гэрчийн эрх, таны хэлж байгаа тэр хөндлөнгийн гэрч тэр хажууд байлцаж байгаа хүний эрх бүх талын хүний эрхийг хангаж байж энэ процесс өөрөө явагдаж байх учиртай. Тэрнээс биш гэмт хэргийг хууль зөрчөөд ч хамаагүй нотлох ёстой гэдэг ийм зарчим бол хэрхэвч байж болохгүй. Хэрхэвч байж болохгүй.

Тэр хүн гэмт хэрэгтэн байсан ч гэсэн түүнийг гэмт хэрэгтэн гэдгийг нотлох процесс хуулийн хүрээнд бүх талын хүний эрхийг хангасан зарчмын хүрээнд явагддаг байх учиртай. Тэгж байж шүүхийн шударга ёсны хэв шинж хадгалагдана.

Тийм учраас бид процессын шударга ёс дээр их ач холбогдол өгч байна. Үнэхээр бас жоохон яарч байгаад ганц нэг юм орхичихсон байгаа. Энэ асуудлыг би бас Байнгын хороон дээрээ хэлсэн. Ганц нэг орхичихсон юмнуудаа хэлэлцүүлгийн шатад бас Байнгын хорооны эрхэм гишүүд ажлын хэсэг маань бас дэмжиж өгөөч ээ гэж хүсэж байгаа.

Тухайлбал цагдан хорих үндэслэл дээр шүүх хурал хийхэд нөгөө цагдан хоригдож байгаа этгээдийг өөрт нь үндэслэлийг нь танилцуулахгүй байгаа. Ямар үндэслэлээр, ямар үндэслэлээр өөрийг чинь цагдан хориод байгаа юм бэ? Өмгөөлөгчийг нь байлцуулахгүй байгаад байна. Тэгэхээр өмгөөлөгч тал тэр хүн буруутгаж байгаа ч гэсэн өөрөө өөрийгөө өмгөөлөх хууль зүйн туслалцаа авах үндсэн эрхтэй байгаа. Үндсэн хуульд заачихсан.

Тийм учраас өмгөөлөгч талд нь тэр цагдан хорих үндэслэлийг нь танилцуулдаг байх Ёстой гэдэг зүйлийг хэлэлцүүлгийн шатад оруулж өгөөч ээ гэж бас би хүсэж байгаа. Тэгэхгүй бол сая хэлсэнчлэн хойшлуулигүй баривчилгаа гэдэг маань 60 хувь, мөн энэнтэй дүйх үндэслэл нь гэмт хэрэг дахин үйлдэж болзошгүй гэдэг барих барьцгүй харанхуй үндэслэл байгаа. Муухай харагдаад байгаа юм уу, царай чинь таалагдахгүй байгаад байгаа юм уу бүү мэд.

Тэгэхээр ийм 2 хүн 2 өөрөөр тайлбарладаг, 3 хүн 3 өөрөөр тайлбарлаж болох боломжтой ийм үндэслэлүүдийг энэ хуулиас авч хаяж байгаа. Зөвхөн объектив барих барьцтай үндэслэлүүдийг л цагдан хорионы үндэслэлд бол.

Г.Занданшатар: Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн тодруулж асууя.

Ц.Даваасүрэн: Хэрхэвч болохгүй гээд л та мэдэгдэл хийгээд байна л даа. Үгүй ээ тэгээд хэрхэвч болохгүй гээд л лав 30 жил яриад байна шүү дээ. Тэгэхдээ энэ чинь байгаад байгааг л яаж зогсоох юм бэ аль эсвэл энэ хууль хяналтынхан хуулиа зөрчиж байгаа дээр тавьдаг хяналт, харцуцлага тооцдог механизмыг нь сайжруулах шаардлага байна уу гэж. Тэр хойшлуулигүй гээд байгааг нь хязгаарла л даа тэрийг болиод. Ерөөсөө гүйцэтгэх ажлаар нотолж байж баривчилгаа хийдэг тийм л хуулийн юуг л хийчхээч дээ. Хүний эрхийг хэрвээ яг дээдэлье л гээд

байгаа бол. Тэгж байж ур чадвар нь дээшилнэ шүү дээ. Ур чадвараа дээшлүүл л дээ.

Тэгэхгүйгээр ингээд л дарамталж байгаад, дарамталж байгаа тэр битгий хэл хүн амины хэрэг хүлээлгэчихсэн түүх зөндөө байдаг юм байна лээ шүү дээ. Ялангуяа Оросын энэ гэмт хэргийн түүхэнд бол. Найз охиныгоо хөөрхий тэгээд л алсан гээд ингээд зөвшөөрчихсөн. Тэгээд 3 жилийн дараа жинхэнэ алуурчин нь гарч ирсэн тохиолдлууд зөндөө байдаг шүү дээ. Тийм учраас энэ дарамтална гэдэг бол ялангуяа энэ баривчилж байж хэрэг хүлээлгэнэ гэдэг бол.

Г.Занданшатар: Баттөмөрийн Энхбаяр сайд хариулна. Хууль зүй, дотоод хэргийн сайд хариулна.

Б.Энхбаяр: Тантай санал нэг байна. Ер нь өөрөөр нь хэргийг нь хүлээлгэдэг зарчим арга барилаас бүхэлдээ татгалзах учиртай. Цаг хугацаа их авдаг юм байна. Хүнээс хамаардаг юм байдаг юм байна. Хүний сурчихсан мэдсэн арга барил чинь өөрчлөгддөггүй юм байна, насаараа ингээд.

Тэгээд энэ чинь хугацаа шаарддаг юм байна. Одоо бидний ярьж байгаа энэ асуудлыг одоо их сургуульд энэ хичээлийг үзэж байгаа оюутнууд 10 жилийн дараа практик дээр гаргаж байж эзэн болгоно. 10 жилийн өмнөх оюутнууд одоо сурч байгаа оюутнуудын хүний эрхийн мэдрэмж лав өөр болчихсон байгаа. Арга барил хандах хандлага өөр болчихсон байгаа. Жишээлбэл энэ цагдан хорионы гүйцэтгэх ажилтай холбоотой асуудал сүүлийн 10 жил парламентад 3 дахь удаагаа орж ирж яригдаж байгаа юм. 2013 онд Гэмт хэргийн тухай хууль Хууль зүйн сайд оруулж ирэхэд энэ цагдан хорих ял хязгаарлах гэж оруулж ирж байсан юм.

Дорлигжав прокурор буцаж татангуутаа цагдан хорио хийдгээр

оруулаад ирсэн юм. 2016 онд Бямбацогт сайд би дэд сайд байхад бид 2 мөн хязгаарлах гэж оруулж ирсэн. Нөгөө байгууллагуудын чинь лобби юм гүйцэгддэггүй байхгүй юу. Тэгээд энэ танхимд лобби нь орж ирээд буцаад цагдан хорион дээр гүйцэтгэх ажил хийдгээр л батлагдчихсан юм. Одоо би бол миний мэдэхийн 3 дахиа оруулж ирж байна. 10 жил шүү сүүлийн 10 жил хугацаа авдаг юм байна лээ.

Г.Занданшатар: Цэндийн Мөнх-Оргил гишүүн.

Ц.Мөнх-Оргил: Баярлалаа. Хуулийн төслүүдийг бүхэлд нь дэмжиж байгаа тэгээд Байнгын хороон дээр ажлын хэсэг гаргах байх гэж бодож байна. Ажлын хэсэгт нь орж ажиллаж гэж бодож байна. Тэгээд Энхбаяр сайдын дутуу үлдээсэн юмнуудыг нь нөхөж оруулаад бид нар боломжийн процессын дэг гарах болов уу гэж бодож байна. Тэгээд энэ дээр манай энэ прокурор шүүхийнхэн ажилласан байх өмгөөлөгч нар ажилласан байх гэж бодож байна. Ер нь энэ эрүүгийн процесстэй холбоотой нэг 2 асуулт л байна Энхбаяр сайд.

Та дөнгөж ажил авангаа хууль хяналтынхан мөрдөн байцаагч нартай уулзаж байхдаа энэ мөрдөн байцаах ажиллагааны нууц задраад байна энийг би таслан зогсооно гэж хэлсэн шүү дээ тийм ээ. Та энийгээ нэг гүйцэж хийж дуусгах хэрэгтэй байна. Тэгээд мэдээж тэр чинь бол нөгөө задлаад байна гээд сэтгүүлчийг буруутгаж бол бид нар болохгүй болчихоод байгаа байхгүй юу. Яагаад гэвэл тэрийг чинь сэтгүүлчид өгч байгаа нэг гол хүн байж байгаа шүү дээ. Тэр хүмүүсээ л олж тогтоомоор байх юм. Тэгээд энэ чинь хэдэн жил үргэлжилж байна. Тэнд ч тийм юм боллоо гээд л. Яг хэргийн материал хавтаст хэргийн материалыг л бараг тэр чигээр нь л нэг юм уу 2 сэтгүүлч л гаргачих юм. Олон хүн гаргахгүй байгаа шүү дээ. Нэг юм уу 2 сэтгүүлч л гаргачих юм. Тэгээд л улс орон даяараа шуугиулж

шуугиулж байгаад л эсвэл тэднийд нэгжлэг үзлэг хийлээ гээд шөнийн 2, 3 цагт сэтгүүлчид оччихсон зогсож байх юм энэ чинь. Хүний эрх цаашаа болчихоод байна шүү дээ тийм ээ. Наадах чинь зүгээр мөрдөн байцаах үйл ажиллагаа нь өчнөөн хүний хөдөлмөрийг үгүйсгээд л, өчнөөн хэрэгтэн ял завишх бололцоо бүрдүүлээд л ингээд яваад байдаг. Энэ дээр та нэг гүйцээж өгөөрэй.

Хийсэн эхэлсэн ажлаа гүйцээгээрэй. Энд тэгээд шаардлагатай бол Энхбаяр сайд Хууль зүйн байнгын хороон дээр яг энэ асуудлаар та тусад нь бүр нэг мэдээлэл хиймээр байна. Би яг ийм ажил авлаа. Ийм ийм тодорхой жишээ гарсан, ийм ийм хүмүүс дээр ийм хариуцлага тооцсон, ингэж ажлаас нь халсан, ингэж шүүхэд шилжүүлсэн гээд тодорхой жишээтэй хэлж, бид нар, олон нийтэд энэ олон мөрдөн байцаагч прокурор, юунууд байдаг юм эд нар т хэлмээр харуулмаар байгаа байхгүй юу энэ чинь болдоггүй юм байна.

Хэзээ нэгэн цагт би хэрэгт ордог юм байна, ял хүлээдэг юм байна. Тийм учраас хуулиа дагаж ажиллах ёстой юм байна гэдгийг нь хүлээлгэмээр байна.

Хоёрдугаарт энэ ажил чинь гацаад байгаа бол бие биеийгээ мөрдөж шалгаж өгөхгүй байгаа бол ерөөсөө тэр Прокурорын дэргэдэх мөрдөн шалгах ажиллагаа явуулдаг байгууллагаа сэргээх асуудлыг та Засгийн газартаа яриад, Ерөнхийлөгчтэй яриад хууль хяналтын байгууллагын удирдлагуудтай яриад энэ асуудлыг оруулж ирэх юм уу яах юм.

Хэрвээ үнэхээр наад асуудал чинь шийдэгдэхгүй байгаа бол.

Гурав дахь асуулт энэ сүүлийн хэдэн жил тэгээд л бид нар янз бүрийн л шүүгч нар прокурор, өмгөөлөгч нарын асуудал яриад л байна л даа. Телевиз радиоогоор яриад л, сошиалаар яриад л, нөгөө лифтэн дотор ороод л оцгоносон

хэдэн шүүгч нарын асуудал яриад л, хүн хэлмэгдүүлээд л, хэрэг үүсгээд л хориод байгаа прокурорын асуудлууд яригдаад л нөгөө хүмүүс нь цагаадаад л гараад байдаг. Үгүй ээ тэр хүн хэлмэгдүүлээд байгаа, хууль зөрчөөд байгаа, өргөсөн тангаргаасаа няцаад байгаа шүүгч прокурорууд чинь хаачсан бэ? Ажлаа хийгээд албан тушаал дэвшээд яваад байна уу эсвэл нэг сахилгын шийтгэл хүртсэн болоод зугтаачхав уу?

Эсвэл манай хууль хяналтынхан тэд нарыгаа бариад шалгаад та ийм хууль зөрчсөн байна таныг ийм Эрүүгийн хуулийн ийм ийм зүйл ангиар яллаж байна гээд ял тулгаж байна уу? Энийг бид нар байна шүү дээ бушуухан нэг тийшээ болгохгүй бол энэ чинь ирээдүйн энэ олон шүүгч прокурор болох гэж байгаа залуучууд одоо ажиллаж байгаа шүүх прокуроруудад ямар дохио өгөөд байна вэ гэвэл болдог юм байна.

Ерөөсөө дарга цэрэг нарын дохио зангаагаар ажиллаад л хэдэн ч хүнийг хэлмэгдүүлж.

Г.Занданшатар: Зочид танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Пүрэв-Очирын Анужингийн урилгаар нийслэлийн ерөнхий боловсролын 12 дугаар сургууль, 27 дугаар цэцэрлэгийн багш ажилчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд ардын хүүхдийг сургаж соён гэгээрүүлэх их хариу үйлсэд нь өндрөөс өндөр амжилтыг Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс хүсэн ерөөе.

Баттөмөрийн Энхбаяр, Хууль зүй, дотоод хэргийн сайд хариулна.

Б.Энхбаяр: Энэ хуулийг өргөн барих хүрээнд бас нэлээн судалгаанууд хийсэн. Энэ дотор ер нь таны хөндсөн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг буруу хийсэн, хууль зөрчсөний

улмаас хэчнээн хүнийг хэлмэгдүүлчхэв ээ гэдэг асуудал байгаа юм. Төр өөрөө төрийн албан хаагч хууль сахиулагч өөрөө 2008-аас 2023 оны байдлаар нийт 425 иргэн дээр Эрүүгийн хууль хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хууль бусаар явуулсны улмаас хохироосон байна гэж үзэж шүүхээс тухайн иргэний зөрчигдсөн эрхийг сэргээх шийдвэр гаргаж нөхөн төлбөрүүдийг гаргасан байна. Одоогоор энэ үлдэгдэл нь шүүхийн шийдвэртэй буюу хүнийг үндэслэлгүйгээр цагдан хорьсон гэм буруутай нь шүүхээр нотлогдоогүй ийм хүмүүсийн хохирлыг эдийн засгийн мөнгөн дүнгээр тооцож үзэж барагдуулж шийдвэр гарчихсан, үлдэгдэл 2.4 тэрбум төгрөг байна. Өнөөдрийн байдлаар.

Миний тухайд Хууль зүй, дотоод хэргийн сайдаар ажиллаж байгаа тохиолдолд 2024 онд багтаад энийг 100 хувь барагдуулна гэсэн бодолтой байгаа. Төр өөрөө хүний эрхийг зөрчсөн байна, төр өөрөө алдаа гаргасан байна, төр өөрөө хүнийг хэлмэгдүүлсэн байна.

Тийм учраас энэ зөрчигдсөн, хүний эрхийг зөрчсөн этгээд буюу төр өөрөө хүний эрхийг сэргээн эдлүүлэх энэ ажлаа хамгийн түрүүнд өөрөөсөө эхлэх ёстой. Шүүхийн шийдвэр гарчхаад байхад чинь улсын төсөв дээр мөнгө байхгүй гээд ингээд хойш нь тавиад байдаг байж болохгүй ээ. 2024 оны төсөв батлагдсан батлагдаагүй ямар ч байсан би Хууль зүй, дотоод хэргийн сайдын багцаас энд эрх нь зөрчигдсөн хүмүүсийн асуудлыг 100 хувь шийднэ гэж үзэж байгаа юм. Дахиж ийм хууль бус ажиллагааг төр нь өөрөө хуулийн байгууллага нь өөрөө гаргадаг байж болохгүй гэж үзэж байгаа юм.

Тийм учраас олон хуулийн шинэтгэлүүд явна. Энэ бол эхнийх нь. Ер нь 3, 4 үе шаттайгаар хуваагдаж Их Хуралд бодлогоо танилцуулна гэж бодож байна. Тэгэхгүй бол нэг амьсгаагаар хөндөх аргагүй хана, хэрэм бас байна.

Таны хөндсөн тэр мөрдөн шалгах ажиллагааны нууцыг задруулж байгаатай холбоотой асуудлыг би зүгээр амандаа орчихсон худлаа ярьдаг сайд байхыг хүсэхгүй. Тодорхой асуудлууд байгаа. Тэгээд энэ дээр үр дүн гаргаж ажиллана. Мөрдөн шалгах үйл ажиллагааны нууц задруулалтыг таслан зогсооно гэж үзэж байгаа.

Г.Занданшатар: Цэндийн Мөнх-Оргил гишүүн тодруулж асууя.

Ц.Мөнх-Оргил: Баярлалаа. Тэгээд Энхбаяр сайд та Хууль зүйн байнгын хороон дээр энэ мөрдөн байцаах ажиллагааны нууц задруулсан асуудлаар материалаа бэлдээд ажлынхаа үр дүнг гарахаар нэг танилцуулсан нь дээр байх тийм ээ. Бид нар танилцах гээд байгаа биш бид нараар дамжуулаад олон нийтэд мэдээлэл хүрч байх нь их чухал учраас. Бас ийм юм байгаа шүү Энхбаяр сайд аа. Бид нар бас нөгөө тийш нь бас хэтэрхий их мушгичих вий дээ. Энэ хууль хяналтын байгууллагууд ажил төрлөө хийж чадах бололцоогүй болтол нь хэдүүлээ. Энэ хууль хяналтынхаа энэ процессынхоо хуулиудыг чангалчих вий дээ. Энэ дээр бас их анхаараарай.

Процессын шударга ёс мэдээж чухал. Агуулгын шударга ёсноосоо илүү процессын шударга ёс илүү чухал. Гэхдээ ямар ч тохиолдолд баривчилгаа хийж болдоггүй, ямар ч тохиолдолд цагдан хорьж чаддаггүй эргээд дараа нь мөнгөн төлбөрт уначих гээд байдаг тийм нөхцөлд бид нар бас бүрдүүлж өгч болохгүй шүү дээ тийм ээ.

Г.Занданшатар: Баттөмөрийн Энхбаяр сайд.

Б.Энхбаяр: Яг тийм байгаа. Энэ чинь нөгөө хэт савж, сэтгэл хөөрлөөр ханддаг, тооцоогүй, ханддаг зүйл биш. Тийм ч учраас ХЗДХЯ-ан дээр байгаа Эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтэд байнгын хяналт

мониторинг хийх ажлын хэсгийн хүрээнд байнга хийгдэж яригдсан Монгол Улсын Дээд шүүх, Ерөнхий прокурор, Өмгөөлөгчдийн холбоо, хууль зүйн судалгааны институт байгууллагуудаас бас энэ ажлын хэсэг дээр их хөндөгдөж яригдсан асуудлууд бас энд хуулийн төсөл болж орж ирж байгаа гэдгийг бас та бүхэндээ хэлье ээ.

Г.Занданшатар: Мөнх-Оргил гишүүн тодруулж асуух уу? Содномын Чинзориг гишүүн. Чинзориг гишүүн алга байна. Цэндийн Сандаг-Очир гишүүн Содномын Чинзориг сайдыг дууд.

Ц.Сандаг-Очир: Энэ хойшлуулишгүй тохиолдол гэдгээ одоо Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийнхаа тэр заалтаас яаж сайжруулж байгаа юм яаж тодорхой болгож байгаа юм. Энэ бүх асуудлуудыг чинь эцсийн үр дүн нь хойшлуулишгүй ажиллагаа нэрийн доор л шүүхийн баривчилгаанууд чинь дийлэнх олон 98, 99 хувь нь явагдсан байна шүү дээ нэгд.

Хоёрт энэ сэтгэл санааны хохирлыг бид нар өнгөрсөн жил тооцдог болсон. Энэ ХЭҮК-ын илтгэл, тайлангаас харахад 382 хүнээс гэмт хэрэг үйлдсэн гэрч хохирогч шууд заасан гэх үндэслэлийг дангаар нь хэрэглэсэн 135 хүнийг баривчилсан боловч 24-48 цагийн дараа сулласан. Зүв зүгээр явж байтал гэв гэнэт нэг өдөр орж ирээд баривчлах нь байна шүү дээ, сэжигтэн болох нь. Тэгээд хорьж цагдчихаад 24-өөс 48 цагийн дараа та ямар ч нотлох баримт байхгүй байна гээд буцаагаад суллагчхна. Энэ тохиолдолд тухайн цагдан хоригдсон улсуудын сэтгэл санааны хохирол тэр нь тэгээд бүх нийт, олон нийт социал сүлжээгээр сэвэгддэг шүү дээ. Манайхан мэдээж байгаа. Энэ тал дээр ер нь бас энэ хуулийн нэмэлт өөрчлөлтөөр ямар өөрчлөлтүүд оруулж байгаа вэ хүний эрхийн зөрчил чинь ерөөсөө гол нь эндээ л байна шүү дээ. Яг үнэнийг хэлэхэд. Энэ дээр нэг тайлбар өгөөч.

Г.Занданишатар: Батаагийн Батцэрэн Дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын шүүгч, ажлын хэсэг 80 дугаар микрофон.

Б.Батцэрэн: Та бүхнийхээ энэ өглөөний амгаланг айлтгая.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд баривчлах ажиллагаа 2 журмаар хэрэгжиж байгаа. Эхнийх нь шүүхийн зөвшөөрлийг урьдчилж аваад баривчилдаг, 2 дахь нь бол хойшлуулиггүй тохиолдолд шүүхийн зөвшөөрөлгүй баривчилж болдог. Энэ хуулийн хэрэгжилтийг сүүлийн 3 жилийн байдлаар судалж үзэхэд нийт баривчилгааны 98, 99 хувь нь шүүхийн зөвшөөрөлгүй явагдсан байна гэж байгаа юм. Энэ ажиллагааны 60 хувь нь хойшлуулиггүй журмаар гэдэг ийм үндэслэлээр хийгдсэн байна.

Тийм учраас энэ хуулийн хүрээнд ер нь бүх баривчлах ажиллагаа шүүхийн хяналтад байх ийм үзэл баримтлалаар нэмэлт, өөрчлөлтүүд орж байна. Тухайлбал баривчлах үндэслэлийг илүү тодорхой объектив шалгууруудыг нарийвчлан хуульчилсан тэр хойшлуулиггүй үндэслэл гэдгийг ерөөсөө бүүр хуулиас нь өөрчилж байгаад яг ямар ямар нөхцөл байдлыг хойшлуулиггүй байдалд хамааруулж авч үзэх вэ гэдгийг маш тодорхой заана. Тэгэхлээр мөрдөгч бол хойшлуулиггүй үндэслэлээр баривчилсан гэж тогтоолдоо бичихгүй. Харин яг тодорхой ямар үндэслэлээр баривчилсан бэ гэдгийг тогтоолд дурдах ёстой байж байгаа юм.

Ингээд энэ баривчлах ажиллагаа шүүхийн болон прокурорын хяналт доор хэрэгжих ёстой. Яаж хэрэгжих вэ гэж. Тэгэхлээр 48 цагийг бол дотор нь 24 цаг, 24 цаг гэж 2 хувааж авч үзэж байгаа. Тэгэхлээр 48 цаг дуусахаас 24 цагийн өмнө прокурорын хяналт хэрэгжинэ. Хэрвээ энэ хүнийг үргэлжлүүлэн баривчлах

шаардлагагүй, баривчлах ажиллагаа үндэслэлгүй явагдсан, хууль заасан журмыг зөрчсөн гэж үзвэл прокурор суллах ийм үүрэгтэй.

Ингээд энэ хүнд даруй тодорхой хэрэг бүртгэлтийн ажиллагаанууд явагдана. Үндэслэл тогтоогдвол эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татна. Ингээд үргэлжлүүлэн цагдан хорих эсэх асуудлыг шийдвэрлүүлэхээр 24 цагийн өмнө шүүхийн хяналтад оруулж ирнэ ээ гэсэн үг. Ингээд шүүх хянахдаа тэр баривчлах ажиллагаа өөрөө үндэслэлтэй явагдсан уу, хуулийн дагуу явагдсан уу гэдгийг хянаж дүгнэлт хийж энэ ажиллагааг үндэслэлтэйд тооцох эсэх асуудлыг шийдвэрлэнэ.

Хоёрдугаарт энэ хүнийг үргэлжлүүлэн цагдан хорих үндэслэл байна уу өөрөөр хэлбэл, эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах хангалттай үндэслэл байсан уу, хуульд заасан цагдан хорих үндэслэлүүд тогтоогдсон уу гэдгийг хэлэлцүүлгээр прокурорын дүгнэлт, өмгөөлөгчийн саналыг харгалзаж шийдвэрээ гаргах юм. Шүүхийн хяналттай холбоотой энэ хяналт тасралтгүй хэрэгжих бас ийм зарчмыг оруулж ирж байгаа.

Өөрөөр хэлбэл хуанлийн өдөр бүр шөнийн 22 цаг хүртэл тасралтгүй шүүх энэ ажлыг хэрэгжүүлнэ.

Г.Занданишатар: Зочид танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Пүрэв-Очирын Анужингийн урилгаар Монгол улс дахь олон улсын эмэгтэйчүүдийн нийгэмлэгийн гишүүд, төлөөлөгчид Нийслэлийн эрхийн боловсролын 12 дугаар сургуулийн багш, ажилчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс сайн сайхныг хүсье ээ.

С.Сандаг-Очир гишүүний асуулт дутуу хариулагдчихсан уу. Товч тодорхой хариулчихмаар байна. Батцэрэн 80. Дээд шүүхийн шүүгч.

Б.Батцэрэн: Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд энэ баривчлах ажиллагаанд шүүхийн хяналтыг тасралтгүй хэрэгжүүлэх ийм зарчим заалтууд орж ирсэн. Өөрөөр хэлбэл хуанлийн өдөр бүр шөнийн 22 цаг хүртэл шүүх энэ баривчлах зөвшөөрөл олгох хойшлуулишгүй журмаар баривчлагдсан ажиллагаанд хяналт тавих энэ журмыг хэрэгжүүлэх юм. Энэ журмыг нь Улсын Дээд шүүх баталж хэрэгжүүлнэ. Энэ баривчлах ажиллагаанд хүний эрхийг хангах үүднээс өмгөөлөгчийг томилж оролцуулах асуудлыг Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн баталж хэрэгжүүлэх ийм заалтууд шинээр орж ирж байна.

Г.Занданшатар: Цэндийн Сандаг-Очир гишүүн тодруулж асууна. Нэг минут

Ц.Сандаг-Очир: Нэг асуултад маань хариулсангүй. Сэтгэл санааны хохирол гэдэг асуудал дээр хариулсангүй.

Хоёрт тэр хэлээд байна шүү дээ. Зөвхөн тэр 135 хүнд л гэхэд л гэмт хэрэг үйлдсэн гэж гэрч хохирогч шууд заасан үндэслэлээр баривчилсан байгаа байхгүй юу. Гэтэл 24-өөс 48 цагийн дараа огт үндэслэл тогтоогдохгүй байна гээд суллагдчихсан. Тэгвэл тэр заасан хүн нь өөрөө ямар ч нотолгоо баримтгүй заагаад тэр заасан хүн нь бас өөрөө хүнийг гүтгэсэн асуудал үүсэх үү үгүй юу? Нотлох баримт нь хангалтгүй байсан байна. Тэрний дагуу мөрдөн байцаагч нь сулласан байна. Гүтгүүлсэн хүн нь яах вэ? Гүтгэсэн хүн нь яах вэ? Тэгвэл энэн дээр ямар тодорхой заалт юмнууд болгохоор юмнууд орж ирж байна вэ?

Г.Занданшатар: 80 Батцэрэн шүүгч.

Б.Батцэрэн: Тэгэхээр хойшлуулишгүй журмаар баривчлах ажиллагааны 60 хувь нь хойшлуулишгүй гэдэг үндэслэл гэж хэлсэн. Мөн нэлээд хувь нь бол гэмт хэрэг үйлдсэн болохыг шууд гэрч хохирогч заасан гэдэг үндэслэл байгаа. Тэгээд эдгээрийн цөөнгүй хувь нь 48 цаг баривчлагдаад баривчлагдсаны дараа суллагдсан ийм судалгааны дүн гарсан байна.

Тэгэхлээр энэ нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд энэ эрх нь зөрчигдсөн гэж үзэж байгаа хүн гомдол гаргавал холбогдох материалыг прокурор шүүхэд шилжүүлж энэ эрх нь зөрчигдсэн эсэх асуудлаар шүүх хэлэлцүүлэг явуулж дүгнэлт гаргах. Хэрвээ хууль бусаар баривчилсан эрх нь зөрчигдсэн гэж үзвэл тэр учирсан хохирлыг нөхөн төлөх ийм асуудал орж ирж байна.

Дээр нь нийт баривчлагдсан хүний 42 хувь нь шүүх рүү шилжихгүйгээр суллагдаж байгаа. Тэгэхээр энэ хүмүүсийн материалыг гомдол гаргаагүй ч гэсэн прокурор 30 хоногийн дотор шүүхэд шилжүүлж хянуулдаг байх. Ийм заалт орж ирж байгаа. Ингэснээрээ ер нь баривчлах ажиллагаа бол бүхэлдээ 100 хувь, шүүхийн хяналтад шилжиж байна гэсэн үг. Сэтгэл санааны хохиролтой холбоотой Иргэний хуулийн 511 дүгээр заалтад өөрчлөлт орсон. Сэтгэц гэмт хэргийн улмаас сэтгэцэд учирсан гэм хорын хохирлыг нөхөн төлүүлэх ийм хэмжээ батлагдсан байгаа.

Тухайлбал хүн нас барсан тохиолдолд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 150 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний хохирлыг нөхөн төлүүлэх. Хэрвээ хохирогч нь насанд хүрээгүй хүүхэд байвал энэ хэмжээг 2 дахин өсгөн нэмэгдүүлж гаргуулах гэх мэтээр. Ингээд энэ хуульд энэ сэтгэцэд

учирсан гэм хорын хохирлыг нөхөн төлөх аргачлалыг Улсын Дээд шүүх баталж.

Г.Занданшатар: Цэдэвийн Сэргэлэн гишүүн асуулт асууна.

Ц.Сэргэлэн: Баярлалаа. Би энэ хуулийн төслийг дэмжиж байгаа. Маш чухал хуулийн төсөл орж ирсэн. Тэгээд хэлэлцэх эсэх дээр нь дэмжиж асуулт асууж байна. Асуухын ялдамд би бас хэд хэдэн зүйлийг тодруулж бас хэлье гэж бодсон юм.

Ялангуяа хуулийн төслийн 2 дугаар зүйлд энэ онц чухал мэдээллийн дэд бүтэц бүхий байгууламжид саад учруулсан, халдсан энэ тохиолдолд эрх зүйн зохицуулалтыг нь нэлээн сайн боловсронгуй болгож оруулж ирж байна. Харьяаллыг нь тодорхой болгож байна. Тэгээд энэ маш сайн Улсын Их Хурлаар киберийн цахимын 3 хууль буюу кибер аюулгүй байдлын тухай хууль энэ дээр батлагдаж орж ирсэн. Энэ хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой энэ заалтууд энэ хуульд тусгагдаж орж ирж байна гэж би бодож байна. Ийм учраас энэ батлагдан гарсан хуулиудаа хэрэгжүүлэх тал дээр анхаарсан ийм сайн хуулийн төсөл гэж би бас нэг талаас нь харж байгаа юм.

Тэгээд энэ хууль батлагдсанаар хэд хэдэн ач холбогдол байна гэж харж байна? Мэдээллийн аюулгүй байдлыг хамгаалах урьдчилан сэргийлэх энэ төрлийн гэмт үйлдэл гарсан тохиолдолд түүнд хүлээлгэх хариуцлага түүнийг шалгах байгууллагуудын үйл ажиллагаа хуулиар тодорхой болж байна гэж харж байна.

Ер нь бол кибер аюулгүй байдлын тухай асуудал сүүлийн үед маш их яригдаж байгаа. Өчигдөр Инновац, цахим бодлогын байнгын хороогоор кибер аюулгүй байдлын асуудал нэлээн хөндөгдөж ярьсан. Кибер аюулгүй байдлын тухай хуулиар байгуулагдсан

Кибер аюулгүй байдлын төвийн төсвийг энэ онд суулгаагүй, 2024 онд суулгаагүй. Тэгээд энэ яаж үйл ажиллагаа явуулах юм. Одоогоор тодорхойгүй байж байгаа. Ер нь цаашидаа бол энэ кибер аюулгүй байдлын асуудал дээрээ төр онцгой анхаарах зайлиггүй шаардлага үүссэн байгаа. Тэгээд би энэтэй холбогдуулж тагнуулын байгууллагаас бас ганц нэг асуулт асууя гэж бодсон юм. Сая энд мөрдөх байгууллагынх нь дарга байх шиг байна лээ.

Энэ кибер аюулгүй байдалтай холбоотой төсөв хөрөнгө танай байгууллагын төсөв дээр ер нь байнга сууж явдаг юм уу? Энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэхэд та бүхний үйл ажиллагаанд бас бэрхшээлтэй юмнууд юу байна вэ? Ялангуяа энэ эрх зүйн талаасаа бол ингээд зохицуулагдаад харьяалал нь тодорхой болоод гараад ирж байна. Зүгээр төсөв мөнгөний холбогдолтой нэлээн хүндрэлүүд байдаг гэж би ойлгоод байгаа юм. Ер нь энэ онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагууд гэдэг чинь ерөөсөө л Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангахад тусгайлсан чиг үүрэг бүхий хэдэн байгууллага л байгаа шүү дээ. Эдгээрийн энэ мэдээллийн сан мэдээллийнх нь бүтэц нь өөрөө онц чухал мэдээлэл агуулсан ийм л байдаг. Энд халдах халдлагууд маш их байна гэдгийг статистикийг өчигдөр Цахим байнгын хороон дээр маш тодорхой танилцуулсан.

Тэгээд энэний эрсдэл нь янз бүр байж байгаа. Ер нь эрсдэлийн түвшинээр нь аваад үзэх юм бол цаашидаа энэ нийгэм төрийн аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй эрсдэлийн түвшинтэй ийм кибер халдлагууд ихсэж байгаа, ийм статистикууд яригдаад байгаа юм. Тэгэхлээр энэтэй голчлон ажиллаж байгаа энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг бүхий тагнуулын байгууллагын маань үйл ажиллагаа энэ дээр бас ямар нэгэн дэмжлэг ялангуяа төсвийн дэмжлэг би зайлиггүй хэрэгтэй гэж хараад байгаа юм. Тэгээд энэ талаар

тодорхой хариултыг өгнө үү? Ер нь 2 дахь асуулт нь кибер аюулгүй байдлын гэмт хэрэг хэр их байна.

Г.Занданишатар: Баттөмөрийн Энхбаяр сайд, Цагдаагийн газар хариулах уу? Кибер аюулгүй байдлын гэмт хэрэг тагнуулын мөрдөн шалгах хэлтсийнхэн. 88.

Ч.Хосбаяр: Та бүгдийн энэ өдрийн амрыг эрье.

Д.Энхтөр: Манай дээр кибер аюулгүй байдал кибер киберийн эсрэг гэмт хэрэг үйлдэгдсэн талаар гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл бүртгэгдээгүй одоогоор.

Г.Занданишатар: Баттөмөрийн Энхбаяр дарга хариулъя.

Б.Энхбаяр: Сэргэлэн гишүүний санаа чилээж байгаа энэ цахим гэмт хэрэг харьяаллын дагуу цагдаагийн байгууллага дээр байдаг. Сүүлийн үед энэ цахим гэмт хэргийн гаралт эрс нэмэгдсэн. 3 төрлийн хэргийн нэг нь байгаа. Огцом нэмэгдэж байна. Энэтэй холбоотойгоор 2 чиглэлийн ажил ойрын үед хийгдэнэ.

Нэгдүгээрт, цахим гэмт хэрэгт, ялангуяа энэ залилан, цахим мөрийтэй тоглоом маш их хэмжээний хүмүүс мөнгөө алдаж байна. Энд хувийн мэдээллийн хууль сая Улсын Их Хурал баталсан. Яг энэ зарим хэргийг нь илрүүлэхэд бас энэ хуулийн нэг жоохон бартаа гүвээ бас гарчхаад байгаа. Тэр нь энэ ялангуяа энэ арилжааны банкнууд дээр иргэд нөгөө залилан авч байгаа этгээдүүд маань данс нээгээд яваад байна.

Энийг нь урьдчилан сэргийлэх бодлогын хүрээнд урьдчилж тухайн нэгэнт мэдэж байгаа тухайн гэмт этгээдүүдийн тухайтад данс нээх боломжийг хязгаарлах хүрээнд Хувь хүний мэдээллийн хуульд бас нэг тодотгол хийх

шаардлага үүсээд байна. Тэгэхдээ би энэ нэгэнт асуусан учраас би урьдчилж ярьж байгаа гэдгийг хэлье. Энэ хүрээнд бол бас хуулийн төсөл боловсруулагдаж байна. Хуулийн төсөл боловсруулахаас гадна ер нь энэ төрлийн залилан гэмт хэрэгт өртөхөөс иргэд маань өөрсдөө их ер нь сонор сэрэмжтэй байх асуудал их гарч байна. Хувийн мэдээллийн аюулгүй байдлаа хангах чиглэл дээр. Энэ дээр урьдчилан сэргийлэх арга хэмжээн дээр ер нь нэлээн анхаарч ажиллана. Хууль зүйн сайдын хувьд. Өнгөрсөн борооны хойноос цув нөмрөхгүй ээ. Урдаас нь нэлээн угтаж урьдчилан сэргийлэх иргэдэд сэрэмжлүүлэг мэдээллүүдийг түгээж ажиллана гэж бодож байгаа. Тэр ч хүрээнд бас урьд би өмнөх 7 хоногийн чуулганд хэлсэн энэ урьдчилан сэргийлэх бүтцийг нэлээн томруулна гэсэн бодолтой байгаа.

Цагдаагийн байгууллагын ер нь гол газар болгоно гэсэн бодолтой байгаа.

Хоёрдугаарт кибер аюулгүй байдлын бүтцийг бас нэлээн анхаарах шаардлага үүсээд байна. Энэ дээр бас анхаарч бүтцийн өөрчлөлт дээр нь анхаарч хүн хүчний хувьд нь анхаарч ажиллана гэсэн бас ийм 2 ажлыг би нэгэнт та асуусан учраас би дахиад л урьдчилаад л бодож байгаа юмаа л яриад байна даа. Уг нь ингэх ёсгүй л юм байгаа юм.

Цэдэвийн Сэргэлэн гишүүн тодруулъя. Нэг минут.

Ц.Сэргэлэн: Баярлалаа. Би харин яг Энхбаяр сайдтай санал нэг байгаа юм. Энэ шинэ төрлийн гэмт хэргүүд өсөн нэмэгдээд байгаа юм. Тэр болгон хүний анхаарал татдаггүй байсан гэмт хэргүүд нийгмийн анхаарлыг маш их татаж байна. Аюул занал, заналхийлэл нь өөрөө өсөн нэмэгдэж байна.

Одоо ер нь буу барьсан дайснаасаа илүү энэ мэдээллийн аюулгүй байдлын

асуудал, цахим гэмт хэрэг үйлдэхээр заналхийлэх аюултай нь бодитой болон болзошгүй энэ аюулууд нь өсөн нэмэгдээд байгаа. Энэ маш тодорхой байгаа. Тэгээд энэний урьдчилан сэргийлэх үүнтэй тэмцэх чиглэлээр эрх зүйн зохицуулалтыг улам боловсронгуй болгоно уу гэдэг дээр би талархалтай хандаж байна.

Тэгээд цаашидаа дээр нь нэмээд хэлэхэд энэ хар тамхины тухай асуудал бас.

Г.Занданшатар: Шатарбалын Раднаасэд гишүүн.

Ш.Раднаасэд: Энэ Сэргэлэн генералын ярьсан дээрээс бас асуухад асуулт ч биш юм даа. Энэ нээрээ энэ онлайн тоглоомын газруудаа учрыг нь олохгүй бол одоо энэ сүйрүүлж байна шүү. Энэ арай хэтэрхий болчихсон байна лээ шүү. Энийг яаж цэгцлэх юм байгаа юм? Анхаарахгүй бол энэ их олон гэр бүл айл амьдралын хүний амьдралыг үгүй болгож байгаа юм аа. Энэ мөрийтэй тоглоомтойгоо холбоотой зохицуулалт юмнуудаа чангатгаж явахгүй бол болохгүй болчихсон байх шиг байна лээ шүү. Санал юм даа.

Надад асуулт гэхэд хаашаа юм би зүгээр шүүхийнхнээс асууя. Яах вэ нөгөө мань мэтийн үеийн сурч байсан юм чинь ерөөсөө таслан сэргийлэх арга хэмжээ гэдгийн нэг дүгээрт хэргийг шуурхай илэрхийлэх, 2 дугаарт нөгөө онц аюултай нөхдүүд дахин давтан гэмт хэрэг хийхээс урьдчилан сэргийлэх, гуравт нь оргон зайлах ч гэдэг юм уу ийм л чиглэлд явсан. Одоо ч тэр концепт дээр явж байгаа байх гэж бодоод байгаа юм.

Тэгэхээр энэ хойшлуулишгүй ажиллагаа ч гэдэг юм уу ингээд заавал шүүхийн хяналт доор байлгана ч гэдэг юм уу шийдэж байх ёстой ч гэдэг юм уу ийм хүний эрх талдаа зөв байх. Нөгөө талдаа энэ хохирогчийн чинь эрх нь яг хангагдах уу? Яг энийгээ юу гэж харж байгаа вэ?

Өөрөөр хэлбэл үндсэн концепт чинь өөрчлөгдөөд энэ энэ төрөл дээр бол цагдан хорьж болно, энэ энэ төрлийн гэмт хэргүүд дээр цагдан хорихыг ерөөсөө бүүр болилоо гэж би ойлгоод байна шүү дээ. Зөв үү?

24 цаг шүүгч сууж байх юм байна. Нийслэл дээр, аймаг дээр тэгээд нөгөө шүүгчээс татгалзъя гэвэл яах вэ? Нөгөө шүүгч нь байлаа гэхэд нөгөө өмгөөлөгч нь байхгүй бол яах вэ? Энэ чинь амралтын өдрөөр ч гэсэн ажиллахаар юм харагдаад байна шүү дээ гэх мэтчилнээр энэ юмнуудаа тооцож харсан уу? Ийм нөхцөл байдал үүсвэл яах бол? Ер нь бол агуулга нь зөв учир зүггүй аваачаад бөөнөөр нь хориод л цагдаад тэгээд л хэрэг тулгадаг.

Ялангуяа энэ цагдаа дээр энэ хар тамхитай холбоотой хэргийн илрүүлэлтийг нэмэгдүүлэхийн тулд 2-оос 3 хүнийг заавал мэдээд л тэгвэл яах вэ? Хөнгөлнө цагдан хорихгүй байна ч гэдэг юм уу нэг ийм юм дам ярианууд маш их болчихсон. Тэгээд хэрэглэгч нарыг зааж өгдөг. Тэгээд тэр нь яг хэрэглэгч мөн үү, биш үү хамаагүй хэн нэгнийг ч хамаагүй зааж өгөөд ингээд явчихдаг гээд би нэг тийм нэвтрүүлэг үзэж байсан хэдхэн сарын өмнө. Тэгээд хэнийг ч хамаагүй зааж өгөөд ингээд хэргээс нэг цагдан хоригдохоос мултрахын тулд. Ийм зорилготой бол нийцэхгүй учраас энэ бол зөв байх. Зөв байх.

Энэ хар тамхи онлайн казино гэдэг энэ тоглоом тоглуулаад байгаа энэ юмнуудтай холбоотой юмнуудаа бол сайжруулах ёстой болов уу? Ялынхаа бодлогыг чангатгадаг юм уу яадаг юм.

Гурав дахь юм энэ зарим төрлийн хэрэг гээд тэгэхээр энийгээ яг яаж сонгож гаргаж аваад байна? Субъект хамаарахгүйгээр гэмт хэргээр нь ангилна гэхээр зөвхөн энэ энэ төрлийн гэмт хэргүүдэд холбогдсон хүмүүс дээр л цагдан хорино гэж ойлголоо. Миний зөв

үү, буруу юу эс үгүй бол би буруу ойлгож байж магадгүй ийм зүйлүүд байна.

Г.Занданшатар: 93, Танхимын тэргүүн Хосбаяр шүүгч хэзээ ирчхэв.

Ч.Хосбаяр: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

Тэгэхээр би саяын асуусан асуултуудад хариулъя. Ер нь баривчлах ажиллагааг шүүхийн зөвшөөрөлгүй гэж өнөөдөр хуульд томъёологдоод явж байгаа энэ тохиолдолд шүүхийн зөвшөөрөлгүй буюу өөрөөр хэлбэл эхэлж баривчлаад дараа нь нөхөж шүүхийн хяналтад орох энэ тохиолдлыг бол ерөөсөө сэжигтнийг баривчлах зөвшөөрлийг шүүхээс эхэлж авахтай холбоотойгоор цаг алдсанаас хүний бусдын амь нас, эд хөрөнгөд хохирол учрах, эсвэл оргон зайлах, эсвэл нотлох баримт үгүй болох, хэргийг халуун мөрөөр илрүүлж байгаа тохиолдолд бий болох энэ нөхцөл байдлуудыг үлдээгээд бусад бүх баривчлах ажиллагааг шүүхээс урьдчилаад зөвшөөрлийг нь аваад, хянуулаад, батлуулсны дараа хэрэгжүүлж байдаг ийм болъёо л гэж байгаа. Ерөөсөө л эрх зүйн агуулга нь ерөөсөө ийм.

Тэгэхээр зарим төрлийн гэмт хэрэг дээр баривчлах цагдан хорих гэж гэмт хэргийн төрлүүд дээр бол ангилж байгаа зүйл байхгүй. Энд ер нь бол хүнийг баривчлах үндэслэл, цагдан хорих үндэслэл гэм буруутайд тооцож хорих ял оногдуулах энэ 3 үндэслэлийг бол 3 нь тусад нь авч үзэж байгаа. Энэ үйлдсэн гэмт хэргийнхээ зүйлчлэлтэй холбоо багатай.

Ерөөсөө баривчлах үндэслэлийг саяын би хэллээ. Шүүхээс зөвшөөрөл авснаас болоод тэр хэрэг илрэх, хохирогчийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах ажил энэ бүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа бүдгэрэх ийм осолтой л тохиолдол энүүгээр нь үндэслэл

болгоно. Цагдан хорих тохиолдол бол хэргийг улмаар шалгаад явж байх энэ явцад эрүүгийн хэрэг үүсгээд шалгаад явж байгаа явцад бий болох эрсдэлээс хамгаалах зорилгоор.

Тэгэхээр энэ үндэслэлүүд бүгд тусдаа. Мэдээж гэм буруутайд тооцсон энэ тухайн тохиолдолд хийж байгаа шалгуурууд нь баримталж байгаа шалгуурууд нь өөр. Гэм буруугийн талаар хэрэг гэмт хэргийн оролцооны талаар хийж байгаа дүгнэлтийнх нь түвшнүүд өөр юм байгаа юм.

Тэгэхээр энэ дээр бол ямар нэгэн хүндрэл бэрхшээл учрахгүй байх гэж бодож байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Раднаасэд гишүүн тодруулж асууя.

Ш.Раднаасэд: Яах вэ зарим зүйл чинь ойлгомжтой. Би 2, 3 юман дээр Хан-Уул дүүргийн шүүгч, бүх шүүгч нар нь нэг хүнийг цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авахад бүр дүүргээрээ татгалзсан юм гээ биз дээ? Шүүгч нар чинь. Тийм тохиолдол ярьдаг юм байна лээ шүү дээ. Нэр бүхий нэг хүний асуудал дээр.

Би энэ 24 цаг ажиллаж байгаа нөгөө шүүгч маань ажиллахгүй байх нөхцөл байдал ашиг сонирхлын зөрчил ихтэй юу гэдэг юм ашиг сонирхол нэгтэй ах дүү, хамаатан садан, анги, төгсөлт гээд л ингээд юм явлаа гэхэд энэ чинь нөгөө амралтын өдрүүдээр хэрэгжих нөхцөл бололцоо юмнууд 24 цагийн түргэний эмч шиг л ажиллах гээд байна шүү дээ. Зөв үү? 103-ын.

Г.Занданшатар: Зочид танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Жадамбын Бат-Эрдэнэ, Цогт-Очирын Анандбазар нарын урилгаар Булган аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний

төвийн ажилчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордондоо танилцаж байна. Та бүхэнд гишүүдийн нэг мөрийн өмнөөс сайн сайхныг хүсье ээ.

Хосбаяр шүүгч хариулах уу? Батцэрэн шүүгч хариулах уу? Батцэрэн шүүгч хариулья.

Б.Батцэрэн: Раднаасэд гишүүний асуултад хариулья.

Тэгэхлээр шүүхийн баривчлах ажиллагаанд шүүхийн хяналт тасралтгүй хэрэгжүүлэх ийм заалт орж ирсэн. Энэ тасралтгүй хэрэгжүүлэхдээ шөнийн 22 цаг хүртэл ажиллана. Ажиллах журмыг нь Улсын дээд шүүх баталж хэрэгжүүлнэ. Энэ бол нөгөө баяр, амралтын өдөр харгалзан ажиллана гэсэн үг.

Шүүгчийг татгалзвал яах вэ гэж. Тэгэхлээр энэ Улсын дээд шүүх энэ жижүүрийн шүүгчийн ажиллах журмыг батлахдаа энэ асуудлыг шийдвэрлэнэ. Хуульд шүүгчийг татгалзах үндэслэлийг маш тодорхой зааж өгсөн байгаа.

ЭХХШТХ-ийн 11 дүгээр зүйлд 4 үндэслэлийг заасан байдаг. Нэмэлт бас 2 нөхцөл бий. Улсын Дээд шүүх 2023 онд энэ шүүгчийг татгалзах үндэслэлийн талаар албан ёсны тайлбар гаргасан. Тэгэхлээр шүүгдэгч яллагдагч түүний өмгөөлөгч нар бас энэ татгалзах эрхээ бас хэтрүүлэн хэрэгжүүлэх тохиолдол гардаг. Бүх шүүгчээс татгалзаж байна эсвэл танай бүх шүүгчээс татгалзаж байна, танай шүүхээр хэргээ шийдүүлэхгүй гэх мэт. Энэ нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг удаашируулах хойшлуулах ийм сөрөг арга дагавар дагуулдаг байсан.

Тэгэхлээр энийг бол Улсын дээд шүүхийн тайлбарт маш тодорхой зааж өгсөн. Тэр шүүхээс татгалзана гэдэг ийм ойлголт байж болохгүй. Энэ Монгол Улсын хуулиар байгуулагдсан шүүхээр би хэргээ шийдүүлэхгүй гэдэг ийм

үндэслэлээр татгалзаж байгаа бол энэ татгалзлыг гаргаагүйд тооцож ажиллагаа үргэлжлэн явагдах ёстой. Харин хуульд заасан маш тодорхой төрөл садны холбоотой гэх мэт ийм үндэслэлүүд тогтоогдвол тэнд шүүгч өөрөө татгалзсан гарах үүрэгтэй. Мэдээгүй байж байгаад ийм нөхцөл байдал илрэх юм бол энэ асуудлыг ерөнхий шүүгч эсвэл шүүгчдийн зөвлөгөөнд шийдвэрлээд өөр шүүгч томилогдон ажиллах ийм байдлаар хэрэгжүүлнэ.

Г.Занданшатар: Энэ завшааныг ашиглаад бас Хосбаяр шүүгч бас харьцангуй академик шүүгч учраас одоо энэ ингээд хэрэг маргаан процессыг аль нэг тал руу нь ингээд туйлширах гээд ч байгаа юм шиг. Эрүү, иргэний хэргийн кодууд нь ингээд кэйс болгоноор яриад байх юм бол энэ эерэг сөрөг талаасаа бас сэтгэлийн хөдөлгөөнөөр ч юм уу шийдэж болохгүй байх л даа. Тэгэхээр Хосбаяр шүүгчээс нэг тодруулж асуух юм бол. Тэгээд Хосбаяр шүүгч ээ энэ дүй процесс гэдэг нэг ойлголт байна шүү дээ. Энийг философийн талаас нь болон онолын талаас нь тэгээд манай практикт энэ процессын шударга ёс аль эсвэл зайлиггүй ажиллагаа гээд л янз янзаар нэг их тогтсон нэр томъёо байхгүй байгаад байгаа юм. Тэгээд энэ процедурын дүй процесс гэж байна. Агуулгын буюу сабстентив дүй процесс гэж байна. Тэгэхээр энэ дүй процесс чинь бас тэр эмининт домэйн буюу тэр нөгөө хувийн өмчийг төр хурааж авах процесс бас яг ийм агуулгатай байх ёстой гэдэг.

Тэгэхээр энэ процессууд эрүү, иргэний хэргийн код өөр боловч яг энийгээ л дагавал хойшлуулиггүй ажиллагаа яг л тэр дүй процессоор явж байвал огт байхгүй хойшлуулиггүй ажиллагаа гэж болохгүй шүү дээ. Хүн хутга бариад байвал барьж болохгүй гэж. Тэгэхээр энэ хойшлуулиггүй ажиллагаа нотлох баримтыг устгах гэж байгаа тэр кодуудыг нь тодорхой заагаад энэ дүй процесс шударгаар явж байх Үндсэн

хуулийн 16.14-д шударга шүүхээр шүүлгэх гэдэг агуулгыг бид нар тэгж л ойлгож байгаа шүү дээ. Мөн шударга бус шүүх байдаг шүүхээс татгалзана энэ тэр гэсэн юм байхгүй нь ойлгомжтой. Батцэрэн гишүүн. Тэр хүмүүс юу ч хүсээд энэ гэхээр шударга шүүхээр шүүлгэх эрхээ нэхээд байна. Тийм ээ шударга шүүхээр шүүлгэх эрх гэдэг маань өөрөө энэ дүй процесс байх шаардлагыг хэлээд байна гэсэн үг болж байна шүү дээ. Үндсэн хууль дээр шударга шүүх гэж байхад шударга бус гэж шүүх байх ёстой юм уу тэгээд энэ татгалзсаныг чинь яг тэрэнтэй уялдаад байгаа байхгүй юу. Шударга шүүх гэдэг бид нар дүй процессыг л Үндсэн хуульд тусгасан юм байна гэж. Процессын шударга ёсыг, агуулгын шударга ёсыг ингэж нэхэж байна гэж ойлгоод байгаа шүү дээ.

Тэгээд энийг та Хосбаяр шүүгч бас энэ дээр ер нь бас гишүүдэд ойлголт өгөөд. Тэгээд энэ дээр бас тэрнийг нэлээн эрүүгийн энэ нэмэлт, өөрчлөлт орж байгаа. Хүний эрхийн асуудал эцсийн эцэстээ явж явж л дүй процессын асуудал шүү дээ. Тийм ээ шударга шүүхээр шүүлгэх чинь. Тийм ээ бас нэг талаасаа энэ процессын хууль дээр энийг та нэг хариулаад тодорхой өгчихвөл энэ Раднаасэд гишүүний энэ бүх асуултууд ер нь явж явж энэтэй уялдаад байна л даа.

Мөнх-Оргил гишүүний асуулт ч гэсэн. Аль нэг тал руу нь ингээд шууд байх байхгүй болгох тухай асуудал биш эцсийн эцэстээ нөгөөдөх нь л шударга тодорхой байгаа л асуудал. 93 Хосбаяр шүүгч. Чагдагийн Хосбаяр.

Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн.

Ч.Хосбаяр: Тэгэхээр тодорхой одоо этгээд сэжигтэн ялагчид тухайн гэмт хэргийг үйлдсэн эсэх асуудлыг хянан шийдвэрлэхэд эцсийн дүндээ тийм материаллаг эрх зүйгээр ч дүгнэлт гаргах, процессын шийдвэрийг гаргахад ч гэсэн

итгэл үнэмшлийн асуудал байгаа юм. Тэгэхээр тэр итгэл үнэмшил бол хэргийн гэрчид л байна уу гэхээс бусад тухайн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлж байгаа эрх бүхий этгээдүүд бол байхгүй тэр хэн нь ч хэргийн газар байгаагүй ийм ийм байгаа. Тийм болохоор энд юуг баримтлах вэ?

Эцсийн дүндээ яг үнэн бодит үнэн гэдэг юу вэ гэдгийг хэн ч мэдэхгүй учраас мэтгэлцээний үнэн байх юм уу бодит үнэн байх юм уу? Юугаар ямар шалгуураар гарч ирсэн нь тогтоогдсон үйл баримтыг үнэн гэж үзэх вэ гэдэг асуудал дээр хүн төрөлхтөн жам ёсны эрх зүйг хөгжүүлэх судлаачид явцдаа ерөөсөө л энэ процессын буюу шударга ёсны эрх зүй чинь явж явж процессын эрх зүй болох юм байна.

Өөрөөр хэлбэл хүний гэм бурууг тогтоохын тулд эсвэл баривчлах үндэслэл байгаа эсэхийг тогтоох юм байна. Эсвэл цагдан хорих шалтгаан байгаа эсэхийг тогтоохын тулд тодорхой шалгууруудыг бий болгоё. Бүүр шалгарсан шалгууруудыг бий болгоё, тодорхой хийх ажиллагаануудын эрэмбэ жагсаалтыг бий болгоё, эрэмбэлье энийгээ процессын хууль гэж нэрлэе эсвэл журам гэж нэрлэе тэгээд энийг заавал хийдэг л байя.

Тэгээд энийг хийсний эцэст бий болж гарах үр дүнг үнэн бодитой шударга үр дүн гэж авч үзье ээ л гэж тохиролцсон ийм зүйлийг л ярьдаг гэдэг философи байдаг.

Тэгэхээр өнөөдөр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хуулиа мөн уг хуулиар тогтоогдож байгаа журмуудыг бүрэн дүүрэн нэг нэгийгээ нөхсөн ямар нэгэн эрх хийдэлгүй, цоорхойгүйгээр бий болгож тэгээд улмаар тэрийг хатуу чанд баримталж гаргасан шийдвэрийг л баримталж явах ийм байгаа юм.

Тэгэхээр баривчлах асуудлын тухайд нэг талаас мэдээж шүүхэд сэжигтэн, ялагч, шүүгдэгчдийн эрх бий.

Үндэслэлгүйгээр баривчлахгүй байх өөрийнх нь эрхэд гүн гүнзгий халдаж байгаа ийм арга хэмжээ учраас, нөгөө талаасаа мэдээж бас саяын гишүүн ярьсан хохирогчийн эрх бий. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилго гэж бий. Шударга ёсыг тогтоох, эрхийг нөхөн сэргээх, хохирсон эрхийг нөхөн төлүүлэх. Тэгэхээр энэ балансыг баримтлахын тулд энэ шалгуур болсон үзүүлэлтүүдийг тогтоож түүнийг хатуу чанга баримталъя гэсэн ийм л концепцыг шүүх барьж байгаа юм.

Өөрөөр хэлбэл баривчлах үндэслэл ерөөсөө баривчлах зөвшөөрлийг шүүхэд хандаж авах хооронд ноцтой сөрөг нөлөө бий болох энэ тохиолдолд шүүхээс зөвшөөрөл авах гээд баривчилчхаад дараа нь нэн даруй 24 цагийн дотор шүүхийн хяналтдаа эргэж ор гэсэн ийм л удирдамжийн дагуу бид хуулиа тайлбарлаж мөн энэ журмуудыг гаргаж байгаа. Ийм байгаа юм товч хэлэхэд ийм байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Зөвхөн баривчлах асуудал дээр биш ерөнхийд нь л процессын шударга ёсыг л яриад байгаа юм л даа. Одонгийн Цогтгэрэл гишүүн алга байна. Лхагвын Мөнхбаатар гишүүн асуулт асууна.

Л.Мөнхбаатар: Сэжигтнийг баривчлах, яллагдагчийг цагдан хорихтой холбоотой энэ асуудал дээр хүний эрхийг хангах, шүүхийн хяналт тасралтгүй байх гэсэн энэ үндсэн зарчмуудыг оруулж ирсэн. Энэ өөрчлөлтийг дэмжиж байгаа. гэхдээ энэ яах вэ 2, 3 зүйлийг бас тодруулж асууя. Ер нь яах вэ энэ сэжигтнийг баривчлах энэ ажиллагаа бол бас 2 талын энэ сонирхол дээр л явагддаг л даа. Нэг талаас тухайн гэмт хэрэгтнийг нэн даруй баривчлах шаардлага, дээр нь дараагийн гэмт хэрэг үйлдэхээс сэргийлэх гэх мэтчилний их олон хууль хууль хяналтын байгууллагуудын нэг сонирхол байна.

Нөгөө талдаа бол хүний эрхийг хангах гол сонирхол нь байх ёстой. Энэ 2-ын сонирхлыг л бас тэнцвэртэйгээр авч үздэг байх ёстой. Энэ дээр уг процессын үйл ажиллагааг шүүхийн хяналтад тасралтгүй байх энэ зарчим оруулж ирж байгаа нь зөв. Ер нь хуучин бол одоо шүүхийн харьяаллыг бол яадаг байсан л даа. Тодорхой хуульчилж өгөөгүй гэмт хэрэг гарсан газар нь аль эсвэл Авлигатай тэмцэх газар, тагнуул Чингэлтэй ч байдаг юм уу дүүрэг гэдэг юм уу ингээд л яваад байдаг. Энийг бол их тодорхой бас заагаад ингээд явж байгаа юм байна. Энэ дээр яах вэ нэг ийм зүйл байгаад байгаа юм. Ер нь удаа дараа ч яригддаг бусад оронд байдаг жишиг л дээ.

Ингээд бүх шүүхүүдээрээ ингээд яах юм уу аль эсвэл дагнасан шүүгчтэй болох асуудлыг ер нь та бүхэн маань юу гэж үзэж байгаа вэ? 24 цагаар суудаг дагнасан мэргэжисэн ийм шүүгчтэй болох асуудал. Одоогийнхоор та бүгдийн оруулж ирснээр 22 цаг хүртэл ажиллах нь байна л даа. Нөгөө шүүх хуралдаан нь тасралтгүй явагдана гэхдээ нөгөө шөнийн цагаар явагдахгүй гэсэн энэ шүүх хуралдааны зарчимтай ингээд холбочихоор чинь энэ уул нь 22 цаг гээд зогсчих юм байна. Гэтэл яг амьдрал дээр уул нь 24 цаг ажиллах шаардлага байгаа. Тийм тохиолдолд шүүгч нь түүнийг үзээд шийдвэрээ гаргаад явдаг. Ийм байвал энэ зохицуулалт руу орвол яасан юм бэ гэж би хэлэх гэж байгаа юм. Тэгэхгүй бол шүүхэд өгдөг 11 шүүгчтэй нэг дүүрэг тэр шүүгчид хуваарилна, шүүгч нь танилцана гээд л, ингээд цаг алдаад л ингээд л энэ процессууд чинь ингээд яваад байх юм биш үү гэж.

Тийм учраас ийм прокурор бол 24 цаг ажиллаж байгаа шүү дээ. 24 цаг эсжүүрийн прокурортой тэгээд 24, 48 гээд ингээд явдаг. Энэ систем рүүгээ ишилжвэл яасан юм бэ? Гэсэн нэг зүйлийг энэ дээр бас хэлье.

Хоёрдугаарт нь энэ та бүгдийн энэ оруулж ирсэн хууль дээр энэ прокурор мөрдөгчийн саналыг үндэслэлтэй гэж үзвэл цагдан хорих хугацааг сунгах саналаа даруй шүүхэд хүргүүлнэ ээ гэсэн байгаа юм. Даруй гэдэг ойлголтыг та бүгд маань юу гэж үзэж байна аа? Хэдэн цаг юм 6 цаг юм уу? 5 цаг юм уу? 8 цагийг хэлж байгаа юм уу? Энийг их тодорхой яг хугацаагаар нь зааж өгвөл яасан юм? Цагаар нь. Тэгэхгүй бол их тодорхойгүй байдал үүснэ шүү дээ. Даруй хүргүүлнэ гэдэг маань энэнтэй холбоотой зүйлүүдээ их тодорхой болгоод заагаад явбал яасан юм. Энийгээ та бүгд нэг авч үзээч гээд. Дараагийн нэг би бас энэ дээр нэг шүүхийнхнээс ялангуяа тайлбар авах нэг зүйл байгаад байгаа нь энэ дээр нэг тайлбар оруулсан байна л даа. Шүүхийн шатад шүүгдэгчийн цагдан хорих хугацаа нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.10 дугаар зүйлд заасан яллагдагчийг цагдан хорих нийт хугацаанд хамаарахгүй гэхээж байгаа юм.

Ингэхээр энэ бас хүний эрхийн нөгөө зөрчил чинь гарах юм биш үү гэж би яах гээд байгаа юм, зөрчигдөх юм биш үү? Хүний эрх тодорхой зөрчигдөх нь ээ энэ нэлээн маргаантай асуудал болох байх гэж бодож байгаа юм. Шүүх дээр нэлээн удаан хоригдоод байдаг. Мэдээж давж заалдсанаас хойш бол мэдээж цагдан хорих хугацаандаа ороод явчихна. Шүүх анхан шатнаас байгаа энэ хугацаа ер нь хэдий хугацаанд шийдэгдэх юм. Ингээд л өмгөөлөгчид нь ирэхгүй 10 удаа, 20 удаа шүүх дээр хойшлоод яваад байдаг. Янз янзын шалтгаан хэлдэг өвчтэй. Шүүх хурал давхацсан гээд тэгээд энэ тоолонд нөгөө хүн чинь хоригдоод л байна. Тэгэхээр энэ хоригдоод байгаа энэ хугацаа бол нөхцөл нь ялгаагүй л 461-д хоригдож байгаа шүү дээ. Тэгээд энэ хугацааг оруулж тооцохгүй гэдэг ч энэ ойлголт чинь ямар ойлголт байна вэ гэдгийг нэг та бүхэн бас тодруулж хэлж өгөх шаардлагатай байна гэж би бодож

байна. Ийм хэдэн асуулт дээр асууж байна.

Г.Занданшатар: Батаагийн Батцэрэн, Дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын шүүгч. 80.

Б.Батцэрэн: Мөнхбаатар гишүүний асуултад хариульъя.

Энэ эрүүгийн процессын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хүрээнд энэ баривчлах ажиллагааны шүүхийн харьяаллыг их тодорхой зааж өгч байгаа. Өөрөөр хэлбэл нэг талаасаа тэр ажиллагааны шуурхай байдлыг хангах, нөгөө талаасаа баривчлагдсан хүн хамгийн ойр байгаа шүүхдээ хандаж эрхээ хамгаалуулах. Энэ 2 нөхцөлийг хангахаар өөрөөр хэлбэл гэмт хэрэг үйлдсэн газрын шүүх мэдээж эхний ээлжид нийтлэг журмынхаа дагуу энэ хяналтыг хэрэгжүүлнэ. Гэтэл гэмт хэрэг үйлдсэн хүн өөр газар оршин байгаа нь тогтоогдох юм бол тэр хамгийн ойр байгаа тэр шүүхэд зөвшөөрөл авах, баривчлах ажиллагааг хянуулах, нөгөө талаас тэр баривчлагдаж байгаа хүн эрхээ хамгаалуулах ийм байдлаар харьяаллын асуудлыг тодорхой болгосон.

Мэдээж Улаанбаатар хотын хувьд бол цагдан хорих төвлөрсөн 461 –р анги байна. Гэтэл энэ нийслэлийн 6 дүүрэг тус бүрдээ энэ баривчлах цагдан хорих зөвшөөрлийг олгож байгаа. Тэгэхлээр энэ шүүх байгуулах тухай хуулийн хүрээнд бас энэ зөвшөөрлийн шүүх байгуулах ийм асуудал яригдаж байгаа. Тэгэхлээр хэрвээ ийм шүүх байгуулагдах юм бол энэ цагдан хорих баривчлах асуудлыг ийм дагнасан шүүх хэрэгжүүлэх хяналт тавих ийм боломжтой болох байх.

Гэхдээ ийм шүүх байгуулагдсан эсэхээс үл хамаараад нийт улсын хэмжээнд бүх шүүхүүд шүүгчдийн зөвлөгөөнөөс тогтоосон журмын дагуу яг тухайлан энэ баривчлах цагдан хорих асуудлыг шүүгч дагнан хариуцаж

шийдвэрлэхээр ингэж энэ шүүхийн тухай хуульд заасны дагуу нийт шүүгчийн чуулганаас ийм нийтлэг журмыг сая баталсан. Тэгэхлээр цаашид таны асууж байгаагаар тухайн шүүхийн бүх шүүгч ингэж тойргийн журмаар авах биш, яг энэ баривчлах цагдан хорих асуудлаа дагнан хэрэгжүүлэх ийм шүүгч томилогдож ажиллах юм.

Дараагийн асуулт бол энэ шүүхийн шатад цагдан хоригдож байгаа хугацаа, яллагчийг хорьж мөрдөх хугацаанд хамаарахгүй гэсэн ийм заалт орж ирсэн. Энэ бол маш олон жил энэ хуулийн салбарт ийм маргааны сэдэв болж явсан. Энэ цагдан хорих хугацаа нь дуусчихдаг тэгээд хэрэг шүүхэд ирдэг нөгөө хүнийг суллах суллахгүй байх. Ийм асуудлууд яригддаг. Тэгэхлээр шүүхийн шатанд явагдаж байгаа ажиллагаа бол энэ хорьж мөрдөх хугацаанаас өөр үндэслэлээр бүүр тусгайлан зохицуулсан ийм журмаар хэрэгждэг ээ. Өөрөөр хэлбэл прокуророос шүүхэд шилжүүлсэн хэргийг 15 хоногийн дотор шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг хийж шүүхэд шилжүүлэх асуудлыг шийдвэрлэнэ. Нэгэнт шүүхэд шилжүүлсэн бол 14 хоногийн дотор шүүх хуралдааныг товлон зарлаж явуулна. Давах хяналтын шатны шүүх бол 30 хоногт хэргийг шийдвэрлэнэ. Тэгэхлээр практикт энэ шүүх хуралдаан олон дахин хойшилдог асуудал үнэхээр байдаг. Энийг дагаад хүн удаан хугацаагаар хоригдох явдал байдаг. Энийг таслан зогсоохын тулд Процессын хуулийн 34, 16 дугаар зүйлд бол шүүх хуралдаан ерөөсөө 2 л удаа хойшлох боломжтой 3 дахь удаа гэж байхгүй.

Г.Занданшатар: Зочид танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Чинбатын Ундрам, Жаргалтулгын Эрдэнэбат, Дамдинсүрэнгийн Өнөрболор нарын урилгаар Сэлэнгэ аймгийн Сайхан сумын ахмадуудын төлөөлөл, Түшиг сумын ЕБС-ийн 12^а ангийн багш зурагчид

Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс сайн сайхныг хүсье ээ.

Мөнхбаатар дарга тодруулж асуух уу? Хариулт дутуу байна уу? Хэн хариулах юм? Батцэрэн 80.

Шүүгч товч тодорхой хариулаарай.

Б.Батцэрэн: Тэгэхлээр төр хүний эрхэнд халдаж ажиллагаа хийж байгаа бол тэр хүний эрх нь зөрчигдөхгүй баталгааг бас хангах ийм үүрэг бий. Тэгэхлээр энэ хүрээнд хэрвээ өмгөөлөгчөөс судалгаагаар бол хуралдаан хойшилж байгаа шалтгааны дийлэнх нь өмгөөлөгчтэй холбоотой байдаг. Тэгэхлээр энэ хуулийн хүрээнд өмгөөлүүлэх эрхийг хангах өмгөөлөгчийг томилон оролцуулах энэ журмыг Өмгөөлөгчдийн холбооны саналыг үндэслэн хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн баталж хэрэгжүүлэхээр ийм заалт орж ирж байгаа.

Тийм учраас энэ одоо хэрэгжсэнээр шүүх хуралдаан хойшлогдох үүнийг дагаад удаан хугацаагаар цагдан хоригдох ийм явдал эрс багасна гэж ингэж үзэж байгаа.

Г.Занданшатар: Салдангийн Одонтуяа гишүүн асуулт асууна.

С.Одонтуяа: Хуулийн үзэл баримтлалыг зарчмын хувьд дэмжиж байгаа. Ер нь би зүгээр энэ би яг өөрөө энэ Хууль зүйн байнгын хороонд байдаггүй болохоор зарим асуудлыг нарийвчилсан зүйлийг нь мэдэхгүй. Гэхдээ бид нэг зүйл дээр нэг шийдэлд хүрмээр байна. Энэ юу вэ гэхээр бид энэ олон улсын гэрээ конвенцод нэгдэж ордог. Тэгээд НҮБ-аас энэ ялангуяа хүний эрхийн асуудал дээр хүний эрхийн зөрчил дээр манай улсад янз бүрийн дүгнэлтүүдийг хийдэг. Та нар

мэдэж байгаа НҮБ-ын энэ дур зоргоор авирлах асуудлын эсрэг ажилладаг шинжээчид ирээд шүүхийн шийдвэргүй баривчилгаа 98 хувьтай байна гээд ярьсан.

Тэгэхээр бид энэ аргачлал нь өөр учраас тэнд буруу мэдээлэл гарчихлаа гэж ярьдгаа болимоор байгаа юм. Нэгэнтээ л НҮБ хэмжэдэг хэмжүүр олон улсын тэр гэрээ конвенцоор хэмжэдэг хэмжүүр бол тэр хэмжүүрээр л явах ёстой. Тэрнээс биш энд нэг монголчлох гэдэг ойлголт байж болмооргүй санагдаж байгаа юм. Яг тэр хэмжүүр дээр олон улсын энэ гэрээ конвенцын асуудал үнэлгээн дээр. Тийм учраас энэ хүний эрхийн асуудал дээр энэ юу нь үнэлгээ нь өөр байсан юм. Тийм учраас тэнд буруу шийдвэр гарсан гэдэг асуудлыг бид нар ярих нь бол цаашидаа зохисгүй ээ гэж үзэж байна.

Яагаад гэхээр Монгол Улсад энэ их хэлмэгдэл гарсан үед яг л Монголчууд өөрсдөө зарим орны нөлөөгөөр ийм өөрсдөө юм бодож олоод ямар ч хүний эрхээс гадуур ийм Онцгой комисс гэж байгуулаад л нийт баривчилсан хүмүүсийнхээ 70 хувийг цаазалсан байдаг байхгүй юу.

Тийм учраас энэ олон улсын хэмжүүрээрээ ажиллаасай гэж сайдад бас би бас анхааруулмаар байна. Тэгээд ямар ч байсан энэ хуульд орж байгаа юм байна би бас өөрөө энэ гишүүнийхээ хувьд хууль санаачлаад тэгээд ингээд өөрөө санаачлаад өргөн барья гэхээр энэ асуудал нэгэнтээ энэ том Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуультайгаа оруулж ирэх боломж байгаа учраас би Засгийн газарт саналаа хүргүүлсэн сан. Нийтдээ би 7 удаа Засгийн газарт энэ бичиг хүргүүлсэн байгаа. Нямбаатар сайд, Оюун-Эрдэнэ яг энэ НҮБ-ын асуудалтай холбоотой 7 удаа би энэ албан бичгийг ингэж явуулсан. Тэгээд энэ асуудал орж шийдэгдэж байгаа гэж сайд хэлсэн учраас баяртай байна.

Ер нь бид нар энэ хойшлуулигүй тохиолдол гэдэг дээр би яагаад энийг буруу хэрэглээд байна гэсэн гэхээр энэ судалгааг харахад ингэж байгаа юм. 2020 онд нийт шүүхийн зөвшөөрөлгүй баривчлах ажиллагааны эргээд 48.4 хувийг нь шүүх, прокурор хүчингүй болгосон байгаа байхгүй юу. Тэгэхээр би юу гэж үзэж байна гэхээр энэ чинь шаардлагагүй баривчилгаа байсан юм биш үү гэж үзээд байгаа юм.

Тийм учраас юу аль болохоор энэ шүүхийн шийдвэртэй аль болохоор энэ прокурорын шийдвэртэй энэ бүх зүйл дээрээ хандвал энэ цөөхөн хэдэн Монголчуудын маань нэг хүний эрх зөрчигдөхгүй байгаасай гэж хүсдэг.

Хоёрт нэг асуудал дээр Энхбаяр сайд болгоомжилж байгаа. Өчигдөр хүүхдийн хамгааллын хуулийн сонсгол болсон. Хүмүүс энэ гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчид дээр энэ асуудал чинь гараад яаралтай баривчлахгүй ингээд хүний амь нас эрсдэх вий гэсэн ийм зүйл ярьсан. Та энэ дээр бас яаж орж байгаа юм бол? Энэ дээр нь хариулт өгвөл бас сайн байна гэсэн ийм 2 зүйлийг асуух гэсэн юм.

Г.Занданиатар: Баттөмөрийн Энхбаяр сайд хариулъя.

Б.Энхбаяр: Энэ шүүхийн аливаа баривчилгаа шүүхийн хяналтаас гадуур байх ёсгүй гэдэг энэ асуудлыг өнгөрсөн хугацаанд Улсын Их Хурал дээр хамгийн их ярьж, анхаарч бас биднийг шаардаж ажилласан гишүүн бол Одонтуяа дарга байгаа.

Үнэхээр энэ асуудал үндэслэлтэй байна уу, үндэслэлгүй байна уу, хуулиас болоод байна уу, хүнээс болоод байна уу гэдэг дээр судалгаа хийж үзсэн. Таны хөндөж тавьсан асуудлууд үндэслэлтэй байсан. Таны шаардлага зөв байсан. Хүний эрх дээр ямарваа нэгэн талцал

хуваагдал гэж байхгүй. Яагаад гэхээр хүний эрх бол хүн төрөлхтний үнэт зүйл байгаа. Энийг хэн нэгэн тэр дотроо төр хуулиар олгодог зүйл биш. Хуульд бичихсэн учраас эрхтэй байдаг зүйл бол биш. Харин эрхтэй байдаг учраас энийг нь хамгаалах гэж хууль гардаг. Манай Цэцийн дарга нөгөө Сувд гуайн хэлсэн үгийг би хэлэх дуртай. Хүн төрөлхтний хөгжлийн түүх бол хүний эрхийн төлөөх тэмцлийн түүх юм гэж. Бүх хуулийн агуулга мөн чанар бол хүний эрхийг хамгаалахад үндэслэгдэх учиртай.

Тийм ч учраас таны хэлсэнчлэн өнөөдөр би нэг яаман дээрээ бас багц ажлын хэсэг гаргаж байгаа. Өөрийнхөө зөвлөхөөр ахлуулаад. Нэлээн том Ажлын хэсэг гаргаж байгаа 40 хүнтэй. Бүх байгууллагуудаас оруулж байна. Энэ НҮБ-аас баталсан хүний эрхийн чиглэлийн олон улсын гэрээ конвенцуудын хэрэгжилтийг нутагшуулах энэнтэй нийцэхгүй байгаа Монгол Улсын хуулиуд юу байна? Иргэний эрхүүд юу байна? Соёлын эрхүүд юу байна? Бид нар хүний эрх гэхээр ганцхан улс төрийн эрх яриад байдаг байхгүй юу. Гадаад жагсах эрхийг л би бид нар нэг хүний эрх гэж ойлгоод байдаг. Үгүй эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийн асуудлууд, мэдэх эрхийн асуудлууд юу вэ? Багц үзэж ер нь энэ хүний эрхэд саад болж байгаа бүх хууль тогтоомжийг нэг шүүрдэх ажил хийе гэж бодож байна.

12 сарын сүүлээр энэ ажлыг дуусгах ийм 3 сарын хугацаатай ажлын хэсэг байгуулж байгаа. Тэгээд энэ хүрээндээ бүхий л чиглэлийн хууль тогтоомжид хүний эрхийг хандсан чиглэлээр өөрчлөлт хийх хууль, тогтоомжийн төслийг бол оруулж ирнэ гэсэн ийм бодолтой байгаа. Тэгээд энэ дээр бас тантай хамтарч ажиллахын төлөө байна.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн тухай.

Г.Занданшатар: Гүйцээж хариулъя. Товч тодорхой.

Б.Энхбаяр: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх асуудал бол гэмт хэрэг ч мөн, зөрчил ч мөн байгаа. Энд цагдаагийн байгууллага ажилладаг. Энэ ер нь яагаад гэр бүлийн хүчирхийлэлтэй эвлэршгүй байх ёстой вэ гэхээр энэ дараа дараагийн том хэргүүд тэр дотроо хүүхдийн эсрэг бусад хүн амьтай холбоотой хэрэг гарахаас урьдчилан сэргийлнэ. Бас энэ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль гарснаар манай улсад хүн амины санаатай гэмт хэргийн тоо багассан байгаа. Зөрчлөөр баривчлагдаж байгаа хүний тоо эрс нэмэгдсэн. Тэгэхдээ санаатай хүн амины тоо багассан. Анх удаа шүү. Энэ бас сонин тохиолдол. Яагаад гэхээр энэ хүчирхийллийн хууль бол урьдчилан сэргийлэх тийм бас эффект өгдөг юм байна лээ.

Тийм учраас би эндээ хүчирхийлэлтэй эвлэрэхгүй байна гэдэг ийм бодлоготой байдаг. Айхтар энэ хүчирхийллийг дэвэргэсэн сурталчилсан мэдээллийг ер нь түгээхээс би одоо ер нь өөрөө лав шууд түдгэлзэнэ. Яагаад гэхээр ерөөсөө энэ төрлийн мэдээллүүд энэ цахим орчноор маш их шуугиад байнгуут энэ хэргийн тоо ихсээд байгаа. Өнгөрсөн 7 хоногт гэр бүлийн хүчирхийлэл өмнөх 7 хоногоос 3.5 дахин нэмэгдчихсэн байгаа юм, огцом.

Тийм учраас ийм хүчирхийллийн сэдэвтэй ер нь ямарваа нэгэн юмыг хэдэн лайкны төлөө мэдээллээ түгээгээд байх тусам энэ төрлийн зөрчил гэмт хэргүүд огцом нэмэгдээд байгаа гэдгийг л би бүүр ард иргэддээ хандаж хэлмээр байна. Хүн болгонд хандаж хэлмээр байна. Тийм учраас энэ урьдчилан сэргийлж үнэхээр энэ хүчирхийлэлтэй эвлэрэхгүй л гэж байгаа бол энийг битгий нэг их тийм асуудлуудыг түгээгээч ээ л гэж би шууд хүсмээр байгаа юм.

Г.Занданшатар: Нямаагийн Энхболд гишүүн асуулт асууя.

Н.Энхболд: Хоёр асуулт байна. Түрүүн нэг тоо хэлсэн тэрийгээ дахиад нэг тодруулаад хэлбэл хүмүүсийн анхааралд хүрэхэд хэрэгтэй юм болов уу гэж бодоод байгаа юм. Шүүхийн түүхэнд энэ мөрдөн шалгах прокурорын хяналтын явцад шүүх шийдвэр гаргах хүртэл хугацаанд явагдсан үйл ажиллагаан дотор яг процессын хуулиудыг зөрччихсөн тийм ээ. Тэгээд энэ процессын хууль зөрчсөн байна гээд ямар ч хамаагүй үнээр, ямар ч хамаагүй аргаар тэр хэргийг батлах гэж оролдож байгаа. Процессынхоо хуулийг зөрчөөд шүүх дээр ирчихсэн. Тэрийг нь шүүх, энэ бол явц дундаа хэргийг батлахын тулд хууль зөрчсөн байна гэж үзээд буцаасан хэрэг хэд байна вэ? Сүүлийн үед тоо нь нэмэгдэж байна уу, багасаж байна уу, эс үгүй шүүх очоод нийгмийн дарамт элдэв янзын юмнаас болоод нэгэнт энэ хүрчихсэн юм нийгмээр нэг шуугиан дэгдчихсэн юм тийм учраас энийг нэг шүүж л дуусгахгүй болохгүй гэдэг ийм хандлага бас байж магадгүй. Шүүгчид нийгмийн дарамтад автаад. Тэгэхээр яг процесс зөрчсөнөөс болоод буцаасан хэрэг хэд байна? Энэнтэй холбоотой та түрүүн 425 гээд нэг тоо хэлчих шиг болно лээ. Тэр хохирлыг нь төлүүлнэ гэж ярьсан тэр зөв дэмжиж байгаа.

Яах вэ тэгээд энэний цаана бас нэг асуулт үлдэж байгаа. Яагаад тэр хууль зөрчөөд хүн шийтгэгдсэн хүмүүсийн бурууг татвар төлөгчид төлж төсвөөс тэр мөнгийг төлж байх ёстой юм. Тэр процессын хууль зөрчөөд шүүх рүү авааччихсан хүмүүст өөрсдөд нь хариуцлага тооцсон тоо байна уу. Нөхөн төлбөр олгох гэж байгаа 400 хэдэн хүнээс чинь гадна яг тэр буруутай хүмүүсээс нь энийг зохицуулах хууль гаргаж болохгүй юу? Тэгэхгүй бол энэ чинь өөрөө ч түрүүн хэлж байх шиг байна лээ. Нэг сахилгын арга хэмжээ авагдсан болоод л улсад өчнөөн тэрбум төгрөгийн хохирол

учруулчихсан. Тэр нөгөө нөхөн төлбөрөө буцаад олгож байгаа шүү дээ. Тэгээд энэ дээр цаашидаа ер нь яах ёстой юм бэ? Бид нар.

Сайдын хувьд юу гэж бодож байгаа юм? Тэр шүүх процессын хуулиуд зөрчиж шүүх рүү авааччихсан улсуудыг шүүх нь цагаатгачихлаа. Нөгөө улсууд яах юм. Энэ их чухал асуудал болоод байна. 1 дүгээрт тийм асуулт.

Хоёрт энэ өөрөөр нь хэрэг хүлээлгэдэг. Эс үгүй бол зөвхөн гэрчийн мэдүүлгээр гэдэг. Дан зөвхөн өөрөөр нь хүлээлгэчихсэн эс үгүй бол өөрөөр нь яаж ч хүлээлгэж болно шүү дээ. Сэтгэл зүйн дарамтад оруулж болно, ар гэр эргэн тойронд нь нөлөөлж болно. Бие махбодын хувьд тарчлаах тамлах ийм юмнууд хэрэглэж байгаад хүлээлгэчихэж болно. Тэгэхээр энэ зүйлүүдийг жишээ нь хүн бол өөрөө өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхтэй. Би юу ч ярихгүй ээ гээд суугаад байвал гэрч тэгж хэлсэн гээд шүүгээд байж ер нь зөв үү? Тэрийг заавал бусад арга хэрэгслээр гүйцэтгэх ажлын байдаг юм уу? Ёстой нөгөө мэргэжил ур чадвар бүх юмаа дээшлүүлж байгаад гэрч мэдүүлсэн ч гэсэн тэр нь баталгаатай би энэ нөхөрт нэг тэдэн төгрөг өгчихсэн гээд хэлдэг нөгөөдөх нь аваагүй гээд байдаг. Энэ гэрч ингэж хэлсэн юм чинь авсан байж таарна гээд шийдэгддэг ийм байдал цаашидаа энэ дээр ямар арга хэмжээ авах вэ юу гэж бодож байна аа?

Энэ 2 дахь асуудал. Энэ дээр энэнтэй уялдсан нэг асуудал тэр шүүхээр ял шийтгэгдсэн хүмүүсийн тэр хэргүүдийн яг хэдэн хувь нь зөвхөн өөрийнх нь мэдээлэлгүйгээр юм уу, зөвхөн гэрчийн мэдүүлгээр бусад ямар нэгэн нотлох баримтгүйгээр шийдэгдсэн байдаг юм бол? Ийм судалгаанууд байна уу? Би нэг нэг мөсөн минутаа аваад нэг санаа хэлчихье. 3 асуулт тавьсан. Хэн хариулах вэ?

Г.Занданшатар: Баттөмөрийн Энхбаяр сайд хариулъя.

Б.Энхбаяр: Гэрчээр асууж байгаад гэрчээр яллагдагч болгодог дадал нэгэнт хэвийн зүйл болсон байна. Гэрчийн эрх бол өөр, яллагдагчийн эрх бол өөр байх. Гэрч бол худлаа мэдүүлэг өгөхгүй байх үүрэгтэй. Яллагдагч бол өөрөө өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх Үндсэн хуулийн эрхтэй байх.

Ингээд 2 өөр эрхийн орчныг хэргийг өөрөөр нь хүлээлгэх зорилгоор гэрч байдлаар асууж байгаад яллагдагч болгодог арга барилд нэвт шингэсэн байна. Энэний шалтгаан үндэслэл бас хуульд бас байна. Одоо би ирэх 7 хоногт Шүүх байгуулах тухай хуулийг дагуулаад Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хууль бас 2 заалт хөндөж оруулж ирэхээр хуулийн төслөө хийчхээд байгаа. Би дахиад л уучлаарай одоо нөгөө ирээдүй цаг ноорог яриад. Таны асуусан учраас хариулж байгаа юм. Энэ гэрчээр асууж байгаад яллагдагч болгодог заалт бол энэ 31.2.8 байгаа эрүүгийн процессын байдал.

Тийм учраас энэ дээр зарим өөрчлөлтүүд тодрох замаар энэ асуудлыг хуулийн хувьд нь бас хаах цэгцлэх шаардлага байгаа гэдэгтэй би санал нэг байна.

Ер нь энэ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хууль зөрчсөний улмаас буюу төрийн албан хаагчийн хууль бус үйл ажиллагааны учирсан хохирлыг төр барагдуулна гээд Үндсэн хуульд бас байгаа. Эхлээд төр барагдуулна. Төр тэр хууль зөрчсөн этгээдтэйгээ яах вэ гэдэг асуудал байгаа юм. Бид бол ганцхан хариуцлагын хэм хэмжээ заахаас гадна яг Эрүүгийн процессын хуулийн хамгийн сүүлийн бүлэг энэ асуудлыг тусдаа бүлгээр бас зохицуулсан юм. Зөрчигдсөн эрхийг сэргээх, хууль зөрчсөн албан тушаалтантайгаа хариуцлага тооцох асуудлыг Эрүүгийн процессын хуульд нь анх удаа бичсэн хуультай. Тэгэхдээ энэ

бүтэн ажиллахгүй байгаа. Бүтэн ажиллахгүйд хэд хэдэн юм нөлөөлж байна.

Нэгдүгээрт мөрдөн шалгах болон прокурорын хяналттай холбоотой чиг үүрэг дээр бид шүүхийн хууль шиг бүтэн болгоогүй байна. Шүүх эрх мэдлийн шинэчлэл гэдэг бүтнээр нь ярьж байж энэ шинэчлэл болно. Бид нар ганцхан шүүхийн хуулийг Их Хурал баталсан. Зөвхөн алх тогшидог хэсгийнх нь л хуулийг баталсан. Алх тогшидог хэсэг рүү материал аваачиж цуглуулдаг хэсэг нь 90 хувь нь. Энэ бол мөрдөх алба болон прокурорын хяналтын хэсэг. Энэ хэсгийг нь үлдээчихсэнээс болоод шүүх рүү асуудлыг бухдаг чихдэг асуудал хавтгайрах шинжтэй болж ирж байна. Нотлогдоогүй, дутуу шалгасан, талуудын эрхийг зөрчсөн асуудлыг дутуу хувааж шүүх рүү шидэж байна. Тэгээд нотлогдохгүй болохоор шүүх тэрийг чинь цагаатгаж байна. Хуулийнхаа дагуу. Тэгэнгүүт шүүх одоо энэ нэг үл бүтэх хүмүүсийн гаргалгаа гэж зориуд бас улс төр явж байгаа асуудлууд байна.

Г.Занданшатар: Баттөмөрийн Энхбаяр гишүүн гүйцээгээд хариулчихъя.

Б.Энхбаяр: Тийм учраас шүүх шүүгч рүү чичилж дайрахаас илүүтэй процессын шударга ёс гэдгийг бид анх хэрэг үүсгэхээс нь эхлээд шалгах, хяналт тавих, шүүн таслах гэсэн бүх л процесст нь авч үзэх шаардлага үүсэж байна. Тэгж байж бид нар шүүх эрх мэдлийн шударга ёсны асуудлыг шинэтгэлийг хийлээ гэж сая хэлэх эрхтэй болж байна. Энэ шинэтгэлийг даруй хийхгүй бол мөрдөх болон прокурорын хяналтын асуудал нь хуучнаараа үлдсэнээс улбаалаад шүүхийнхээ шинэтгэлийг эргэж татаж унагаах эрсдэл үүсгэж байна. Цаг хугацааны хувьд. Тийм учраас энэ бол хугацаа шаардана. Нэг амьсгаагаар хийх боломжгүй. Нэг амьсгаагаар хийхгүй бол тэрийг хийсэн сайд нь бараг өөрөө огцрох байх. Тэр системтэйгээ үзэж байгаа учраас.

Тийм учраас би түрүүн анхны хэлж байсан. Энийг үе шаттай хувааж оруулна. Би бол 3 үе шаттай энэ процессын шинэтгэлүүд явах ёстой болов уу гэж бодож байгаа, 3 үе шаттай.

Г.Занданшатар: Нямаагийн Энхболд гишүүн тодруулж асууя.

Н.Энхболд: Шүүх дээр очоод процессын алдаа гаргасан учраас нотлох материалуудаа буруу арга замаар цуглуулсан учраас эс үгүй бол дутуу цуглуулсан учраас гээд цагаадсан 400 хэдэн хүний тухай ярьсан. Төлбөр нь тэгээд нэг төлөгдөж таарах байх. Тэр олон хэргийг буруу шүүх рүү авчирсан хэдэн хүн хариуцлага хүлээсэн бэ? Энэтэй холбогдоод ер нь би түрүүн Мөнх-Оргил гишүүн хэллүү, хэн хэллээ. Энэ нөгөө энэ байгууллагуудыг хянадаг шалдаг ажлыг нь өөрснөө хийдэг биш прокурорт шилжүүлэх нь зүйтэй гэсэн ийм байр суурьтай байгаад байсан. Өөрчилчихсөн эргээд сэргээхгүй бол болохгүй байна гэдгийн түүх бид нарын практик харуулчихлаа шүү дээ. Энэ дээр нэг хариулт. Тэгээд тэр 40 хүнтэй судалгааны баг гаргаад юм хийнэ гэж байна. Та бид хоёр хоёулаа мэдэж байгаа. Манай нам дээр яг хүний эрхтэй холбоотой хуулиуд дээр дүгнэлт хийсэн тийм ээ. 8 зуугаад заалт хүний эрхийг бүх л салбарт.

Г.Занданшатар: Баттөмөрийн Энхбаяр сайд.

Б.Энхбаяр: Парламент дээр бас манай нам хүний эрхийн лобби том бүлэг байгуулчихсан. Нямаагийн Энхболд дарга ахалж байгаа. Би бас гишүүн нь байгаа юм. Тэгээд бид хамтдаа энэ Монгол Улсын хууль тогтоомжид ер нь хүний эрхийн зөрчилтэй холбоотой 800 гаруй заалт байна гэдэг том судалгааны үр дүн бүтэн жилийн хугацаанд хийгдчихсэн. Тэр судалгааны үндэслэлүүд дотор өнөөдрийн бидний яг хөндөж ярьж байгаа энэ

эрүүгийн процессын асуудал яг тэр дотор байгаа. Одоо тэр судалгааны дүгнэлтүүд амилах ёстой. Зүгээр цаас болоод хэдэн судлаачдын цаг хугацаа шаардсан ажил болоод өнгөрөх ёсгүй ээ гэж үзэж байгаа.

Тийм учраас яг таны хэлсэн, хүний эрхийг зөрчсөн Монгол Улсын энэ хууль тогтоомжийг шүүрдэнэ ээ гэж байгаа маань тэр судалгааны асуудлуудыг ажил хэрэг болгоно одоо. Парламентын гал тогоо руу оруулж ирнэ ээ энийг. Тийм учраас энэ оруулж ирэх ажлын хэсгээ би байгуулчихсан. Сая өнөөдөр байгуулж байна. Энийг үе шаттай оруулж ирнэ. Нэг амьсгаагаар 32 цагаан лонх тоолох боломжгүй юм байна лээ.

Г.Занданшатар: Максимын Чинбат 82.

М.Энхболд: Энхболд гишүүний асуултад хариулъя.

Тэр Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45 дугаар бүлэгт заасан мөрдөгч, прокурор, шүүгчийн үйл ажиллагааны улмаас хохирол учирсан асуудлыг шүүхээр шийдвэрлээд шүүхийн шийдвэр гарчихсан. 425 хүний асуудал яригдаад байна л даа. Тэгэхээр тэр яг энэ дотор нь тэр 425 гэдэг чинь зүгээр төрийн байгууллагын үйл ажиллагаа, төрийн албан хаагчийн үйл ажиллагаанаас учирсан хохирлыг гаргуулах. Тэр гаргуулсан шийдвэрүүд нь хэд байгаа юм? Энэ дотроос эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны улмаас буюу мөрдөгч, прокурор, шүүгчийн хууль бус шийдвэрийн улмаас хохирсон нь хэд юм гэдэг ийм яг тоо нь бол нийтэд нь та энэ бас 425 гээд нийтэд гарчихаар бас нийгэмд буруу ойлголт төрүүлж магадгүй ээ. Яг прокурорын гэдэг юм уу, шүүгчийн мөрдөгчийн үйл ажиллагааны улмаас буруутай нь тогтоогдсон гэдэг энэ нарийн ийм судалгаа бол бас тэрийгээ ил тодорхой болгох ёстой л доо. Ерөнхийд нь шүүхийн шийдвэртэй болгоныг ингэж яг энэ эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх

ажиллагааны явцад бий болсон мэт ингээж ярьж бас болохгүй байх. Энийг бас яам бас бас анхаарч бас ажиллах нь зүйтэй байх гэж бодож байна.

Ер нь бол нотолж чадахгүйгээсээ болж шүүхээс буцсан гэдэг ийм хэрэг бол байхгүй ээ. Зөвхөн өөрийнх нь мэдүүлгээр хэргийг шүүхэд аваачдаг ийм тохиолдол ч байхгүй. Бидний эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үндсэн зарчим зорилго нь бол өөрөөр нь мэдүүлэхээс бусад баримтаар бид нотолж нотлох баримт бүрдүүлж энэнийхээ үр дүнд тухайн хүн гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай байна уу үгүй юу гэдгээ дүгнэж байж шүүхэд шилжүүлдэг ийм тохиолдол байгаа юм. Тэгэхээр үндсэн зарчмаасаа ухарсан ийм үйл ажиллагаа явуулдаг юм байхгүй.

Хоёрдугаарт бас энэ эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх.../минут дуусав/.

Г.Занданшатар: Гэрчээс сэжигтэн болоод сэжигтэн яллагдагч болоод явчихна гэж үү? Тэгж л явж байгаа л даа. 82 Максимийн Чинбат гүйцээгээд хариулчих, тодорхой хариулчих.

М.Чинбат: Мөрдөн шалгах ажиллагааны явцад гэрчээр байцаагдсан хүн энэ ажиллагааны үр дүнд өөрөө бас гэмт хэрэг үйлдсэн ялагчаар татагдах зайлиггүй тохиолдол гардаг. Энэ бол. Энэ бол яг үнэхээр ингээд ялагчаар татагдсан тохиолдол энэ бол бусад нотлох баримтаар хангалттай батлагдаж байж л бид хэргийг шүүхэд шилжүүлдэг. Түүнээс яг зөвхөн өөрийнх нь мэдүүлгээр дан ганц мэдүүлгийг бол үнэлж шилжүүлэх явдал гардаггүй ээ л гэж би дахин хэлэх гээд байна.

Г.Занданшатар: Наянтайн Ганибал гишүүн.

Н.Ганибал: Өнөөдрийн бас Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай

хуульд нэмэлт, өөрчлөлт бас хүний эрхийн ч тал дээр бас үйл ажиллагааг сайжруулах тал дээр ахиц гарч байна гэж ойлгож байгаа. Ер нь сүүлийн үед нийгэмд болоод байгаа процессууд дотор яг энэ өнөөдрийн энэ асуудлууд маш их өндөр хувьтай орж ирээд байгаа юм. Монгол Улсад өнөөдөр Засгийн газар нь ч гэдэг юм уу авлигатай тэмцэнэ ээ гэхээр яг энэ процессуудыг хийгээд эхэлчихсэн. Баахан сошиалаар явуулж явуулж байгаад энэ авлигачин гэж байгаад тэгээд барьж хорьж нийгмийн сэтгэл зүйг тайвшруулдаг ийм арга бүр олон жил явчихлаа.

Хоёрт нь саяын тэр мөрдөн байцаах процессыг задалдаг, нууцыг дэлгэдэг гэдэг асуудал сенсацыг сенсацаар гэдэг. Ийм бүүр технологитой болчихсон. Тэгээд энэ 2 технологи чинь өнөөдөр эргээд харахаар энэ шүүхийн болон прокурорын энэ Эрүүгийн хууль дахь энэ процессуудыг зөрчөөд байгаа. Энийг бараг Монголчууд бараг бүгдээрээ мэддэг болчихлоо доо бараг. Тэгээд энэ дээр бас тодорхой ахиц гаргаж, баривчлах мөрдөн цагдах гээд энэ асуудлуудаа ялгаж салгаж процессуудыг нь бас зөв шийдвэр гаргах тал дээр ингээд ахиц гарч байна гэж ойлгоод байгаа юм.

Ер нь би зүгээр нэг юман дээр маш их хардаад байдаг юм. Одоо ингээд нүүрсний хэрэг гээд л Ганхуяг гэдэг хүнийг бариад хорьчихдог. Магадгүй тэр хүнийг нэг ч удаа байцаалт авахгүй нэг сар энэ тэр байлгана гэдэг асуудал нь өнөөдөр хамтран тэр нүүрсний хулгай хийсэн хүмүүс нь хамтрагч нар нь мань хүнийг нийгмээс тусгаарлаад тэнд цагдан хориод байгаа юм биш үү дээ гэсэн ийм бүүр хардалт гарч ирж байгаа юм. Ер нь шүүх процесс явагдаж байж гэм буруутайг тогтоож байж харилцан мэтгэлцэж байж энэ асуудлын мөн чанар уг нь тогтоогдох ёстой.

Тэгэхдээ магадгүй хамтрагч нь захиалаад тэр хүнийг өнөөдөр цагдан

хориод байлгаад байгаа юм биш үү дээ гэдэг. Тэгэхээр энэ бүх асуудлууд өнөөдөр бид нарын авлигатай тэмцэнэ ээ л гэдэг. Түүнийг хэрхэн тэмцэж байгаа байдал нь энийг шүүн тасалж чадаж байна уу, үгүй юү гээд энэ бүх асуудлууд нийтээрээ өнөөдрийн энэ асуудлуудын, өнөөдрийн энэ хэлэлцэж байгаа хуулийн хамгийн гол хэсэг болоод явж байна уу даа гэж харагдаж байгаа.

Тэгэхээр энэ дээр та бүхэн бас ахиц гаргаж байгаад бас баярлаж байна. Тэгээд ер нь цаг хугацаатай хорьдог баривчлаад баривчилсан нь гэм буруугүй бол богино хугацаанд тэр асуудлыг нь шийдэж тавьдаг гээд энэ ер нь зүгээр хүний эрхтэй холбоотой бүх асуудлуудаа бид нар харахгүй бол өнөөдөр бас НҮБ-ын судалгаагаар бид нарыг бүүр бодитойгоор нь гаргаад тавьчихсан шүү дээ тэ. Тэгэхээр энэ асуудалтай бас илүү нарийвчлах цаашилаад түрүүн Энхбаяр сайдын хэлээд байгаа дутуу орхисон юмнуудаа ч гэсэн яаралтай оруулаад энэ хүний эрх мөн энэ эрүүгийнхээ энэ процессуудыг зөв болгох ёстой гэж бодож байна.

Г.Занданшатар: Санал хэлчихлээ. Энэ Нямаагийн Энхболд гишүүний асуугаад байгаа асуултын агуулга байна шүү дээ. Чинбат прокурор оо. Үгүй энэ яах вэ сэжигтэн гэрч ялагдагч болох энэ тэр яах вэ? Мэдүүлгийн нотлох баримтаас өөр ямар баримтаар ямар нотлох баримтаар шинжээчийн дүгнэлт гаргаж байгаа вэ. Энэнээс өөр ямар нотлох баримтаар энэ нотолж шүүхэд шилжүүлж байгаа юм бэ? Сая Энхбаяр сайд ч гэсэн хэллээ шүү дээ. Нотлох баримт дутуу, хангалтгүй нэг хүнийг нөгөө хүнээр нь гэрчийн мэдүүлгээр эсвэл мэдүүлгийн нотлох баримтаас өөр нэг шинжээчийн дүгнэлт ингээд том ерөнхий гарчхаж байгаа юм. Өөр ямар нотлох баримтаар гүйцэтгэх ажлын ч юм уу ингээд асуугаад байна шүү дээ. Ер нь хэргийн хэдэн хувь нь мэдүүлгээр нь мэдүүлгийн нотлох баримтаар шилжиж

байгаа юм бэ гэсэн. Тэгээд ийм л агуулга нь л энэ чинь л нөгөө процессын дүй процесс гээд байгаа шүү дээ. Процессстой холбоотой зөрчил процессын зөрчлийг л хүний эрхтэй ч холбоотойгоор, ялын бодлоготойгоо ч холбоотойгоор яригдаад байна гэдгийг Энхболд гишүүн агуулга нь тэгж асуугаад байна л даа гэж ойлголоо шүү дээ.

84 Максимын Чинбат. Шүүх рүү шилжүүлж байгаа баримтуудыг чинь хувьчилбал хэдэн хувь, тэгээд мөрдөх ажиллагаа чинь тэгээд яагаад буцчихдаг юм гэж асуугаад байна. 84 Чинбат прокурор, хариулахгүй юу? Төрийн хууль цаазын шадар зөвлөх Максимын Чинбат 82.

М.Чинбат: Тодруулсан асуултад хариулъя. Тэгэхээр эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад мөрдөн шалгах ажиллагаанд бол үр дүн гаргахын тулд олон л арга арга хэрэглэж хэргийг илрүүлж нотолж байна л даа. Тэгээд энэ дотор мэдүүлгийн нотлох баримт бас чухал баримт эзэлж байна. Мөн санхүүгийн шинжилгээ, шинжээчийн дүгнэлт, хэргийн газрын үзлэг, эд мөрийн баримт гээд олон нотлох ажиллагааны үр дүнд энд бий болж байгаа юм. Энэ хэрэг нэг болгон дээр энэ бол онцлог байдлаар хэрэгжиж ингэж үр дүнг бид нар үнэлж байна. Энэ бол зохицсон үйл ажиллагаа, нотолгооны ажил, арга хэмжээ явагдаж байгаа юм.

Түүнээс бол дан ганц хүнийг гэрчийн мэдүүлгээр гэдэг юм уу нотлох ийм нотолгоо бол явагддаггүй онцлогтой юм. Түүнээс яг өөрийнх нь мэдлэгээр нотолж явуулдаг ийм практик хэрэг гэж бол өнөөдөр энэ хуульд ч байхгүй ийм хуулийн зохицуулалтаас ч тийм шаардах боломжгүй ийм нөхцөл байдалд байдаг юм.

Энэ бол хориглосон арга ажиллагааны үндсэн зарчим юм байгаа юм.

Г.Занданшатар: Хэдэн хувь нь гэж байна л даа. Энийг яг хувьчилсан судалгаа шүүхийн судалгааны хүрээнд.

Даваажсанцангийн Сарангэрэл гишүүн.

Д.Сарангэрэл: Баярлалаа. Хуулийн сайд маань томилогдоод удаагүй байгаа ч гэсэн иргэдийн хүлээлттэй байгаа тулгамдаж байгаа асуудлуудаар хуулийн төслүүдийг шуурхай оруулж ирж хэлэлцүүлж байгаад бас талархаж байна. Эдгээрийн нэг нь өнөөдөр оруулж ирсэн 2 хуулийн төсөл байгаа. Би хуулийн төсөлтэй холбоотой гэхээсээ илүүтэй энэ шүүх засаглалтай холбоотойгоор иргэдийн зүгээс энэ тавьж байгаа асуудлуудаар өнөөдөр хууль цаазын томоохон төлөөллүүд энэ танхимд байгаа даширамд бас асуугаад авъя гэж бодож байна л даа. Шүүхийн нэр хүнд их муу байна. Тэгээд одоо шүүхэд итгэхийн арга алга, шударгаар шийдэж чадахгүй гээд ингээд бүүр ийм ойлголт иргэдийн дунд нэлээн тийм гүн бат сууж байна. Хар цагааныг дэнсэлдэг газар нь шүүх. Энэ ганцхан Монголд биш дэлхий даяар байгаа. Тэгээд энийг би бол бас энд мэдлэгтэй боловсролтой, бүхэл бүтэн нэг салбар, бүхэл бүтэн нэг мэргэжил. Бие даасан хараат бус шүүх засаглал маань өөрөө байж байгаа л даа. Тэгээд ийм нөхцөл байдалд ер нь энэ нөхцөл байдлыг засаж залруулахад хууль эрх зүйн хувьд сая бас Энхбаяр сайд ч гэсэн хэллээ дутуу хөтүү юм байгаа гэж. Энэ дотор нь оруулах тийм бас арга зам бодол та бүхэнд байгаа юу? Энэ нэр хүндтэй холбоотой энэ асуудал бол зөвхөн та бүхний мэргэжил гэхээсээ илүүтэй нийгэмд өөрөө их тийм итгэлгүй эмзэг тийм байдлыг үүсгээд байна л даа.

Тэгээд энэ чиглэлд ер нь та нар маань юу бодож явдаг вэ? Энэ чиглэлээр ер нь яаж ажиллах юм? Магадгүй сурталчилгааны ажлын асуудал байна уу? Иргэдийн эргэлзээд байгаа асуудлуудаар

энэ чинь хэлэлцүүлэг хийгээд олон нийтдээ сая би Чинбат Ерөнхий прокурорын орлогчийн үгэнд би маш том мэдэгдэл хийлээ гэж бодож байна. Баримтаар нотлогдоогүй материалыг шүүх хэзээ ч хүлээж авдаггүй. Үгүй ээ энэ маш том мэдэгдэл шүү дээ.

Хэрвээ энэ ойлголт ард иргэдэд очих юм бол бас нөхцөл байдал би нэлээн өөр болно гэж бодож байна. Тэгэхээр шүүх засаглалын асуудал тэндээ тусгай асуудал биш нийгэмтэй нийгмийн нөхцөл байдалтай шууд холбоотой байгаа учраас нийгмийн сэтгэл зүйтэй холбоотой байгаа учраас та бүхнийг би энэ чиглэлд хууль эрх зүйн болон бусад чиглэлээр ажиллах шаардлагатай. Энэ талаар ямар санаа бодол байгаа вэ гэдгийг 1 дүгээрт асуух гэсэн юм.

Хоёрдугаарт шүүхийн процессыг шуурхайлах арга бий юу? Маш удаан байна.

Би нэг бодит жишээ хэлэх гэсэн юм 2017-2018 онд Бүрэн өргөө гэж компани дээр Цагаан хаалга гэж орон сууцын хороолол бариад иргэдээс 100 хувь мөнгийг нь авсан байгаа юм. 2019 онд ашиглалтад орох ёстой байсан үүнээс хойш 5 жилийн хугацаанд 500 айлын 5 мянган өрх өнөөдөр үндсэндээ гудамжинд байж байгаа. Энэ 5 жилийн хугацаанд нэлээн олон хүн хорвоогийн мөнх бусыг үзүүлсэн. Айл өрх гэр бүлд хүндрэл үүссэн гэр бүл салсан гээд үнэхээр хүнд байдал үүсчхээд байгаа юм. 7 сар суулт зарлачхаад байж байгаа юм. Цагдаа шүүхэд процесс явж байгаа. Тэгээд 7 сарын хугацаанд ямар нэгэн шийдэл байхгүй. Тойргоос сонгогдсон гишүүндээ л ханддаг. Нэг ийм зовлонд учирчхаад байгаа юм. Ийм нөхцөл байдалд асуудлыг хууль хяналтын байгууллагууд маань цагдаа, шүүх, прокурор хамтраад 5 мянган хүний асуудал дээр арай шуурхай хандах ийм арга зам байна уу? Үгүй бол юу нь саад болоод байна. Процесс нь тэр нотлогдохгүй байна уу, юундаа байна? Хуулийн хугацаа нь ийм байгаад байгаа юм уу? Энэ дээр би та бүхнийгээ нэг

хариулт өгөөд дараа нь тодруулъя гэж ингэж бодож байна.

Баярлалаа.

Г.Занданиатар: 82, ерөнхий прокурорын орлогч. 93 Хосбаяр Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн.

Ч.Хосбаяр: Сарангэрэл гишүүний асуултад хариулъя.

Тэгэхээр энэ асуултад хариулах зарим хариулт нь Энхболд гишүүний асуусан асуултын хариулттай бас хамт хариулагдах юм байна. Тэгэхээр би энэ дээр нөхөж хариулъя.

Шүүгдэгчийн яллагдагчийн гэм бурууг өөрийнх нь мэдүүлэг болон гэрчийн мэдүүлгүүдээр шийдвэрлэж байгаа талаар асууж байна.

Тэгэхээр энэ дээр зөвхөн өөрийнх нь мэдүүлэгт тулгуурлаж ял шийтгэсэн тохиолдол үнэхээр байхгүй ээ. Харин гэрчийн буюу субъектив хандлагатай ийм нотлох баримтаар нотлогдох хэргийг эцэслэн шийдвэрлэсэн ийм тохиолдлууд бас байж байгаа. Өөрөөр хэлбэл гэрчийн мэдүүлэг өөрөөс нь өөр байгаа. Тэгэхээр энэ дээр бол шүүх шүүмжлэлтэй ханддаг. Гэрч эцсийн эцэстээ хүн тэгэхээр хүнд ашиг сонирхол байдаг. Тэгэхээр гэрчийн найдвартай байдаг гэсэн ийм стандартыг бас тооцож шүүх хэргийг шийдвэрлэх ёстой гэсэн ийм нотолгооны бас стандартыг бид хэрэгжүүлэх ийм журам баталсан байгаа. Тайлбар өөрөөр хэлбэл Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан нотлогдвол зохих баримтыг тэнд нийтдээ 15 зүйл бий. Энийг шат дараалсан ийм тайлбаруудыг хийгээд явж байгаа.

Тэгэхээр энд гэрчийн мэдүүлэг гэдэг тайлбарлагдчихсан. Үүнд гэрчид ямар нэгэн байдлаар хууль сануулснаар шударга үнэний туйл болж хувирахгүй ээ.

Тийм учраас тэр хүний тухайн гэмт хэрэгт байгаа хамаарал эсвэл тухайн хүнтэй хамаарал ямар байна, ашиг сонирхол албаны бөгөөд хувийн ашиг сонирхол ямар байна гэдгийг нь тооцож мэдүүлгийг нь өөр өөр түвшинд үнэлэх талаар энэ тайлбарт өгсөн байгаа. Үүнээс гадна бид нотлох баримтуудын нотолгооны ач холбогдол буюу нотлох хүчин чадлыг тогтоохдоо криминалистик шинжилгээний үр дүнгээр бий болсон тийм илүү объектив нөхцөл байдалд тулгуурласан баримтуудыг илүү авч үзэх талаар ийм тайлбаруудыг гаргаад явж байгаа. Шүүхийн нэр хүндийн тухай асуудалд шүүх өөрийнхөө үйл ажиллагаагаараа нэр хүндээ олж авах байх. Олон нийтээс.

Тэгэхээр хуулийн болон эрх зүйн тал дээр энэ талаар шүүхийн үйл ажиллагаанд илүү хар цагааныг ялгах ийм боломж олгосон ийм процедурыг процессуудыг бол тусгаж хууль зүйн орчноо сайжруулах нь зүйтэй. Энэ дээр бол хуучин хууль зүйн өмнө нь ажиллаж байсан сайд болон шинээр томилогдсон сайд нар ажиллаж байгаа. Энэ бас нөгөө зохих үр дүн авчрах байх л гэж бодож байна. Иргэний процессын тухайд бол арилжааны шүүхийн асуудал буюу ийм иргэдийн болон аж ахуйн нэгжийн хооронд бий болсон ийм иргэний эрх зүйн хэрэг маргааныг.

Г.Занданиатар: Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль дараагийн асуудал л даа даа. Одоо чинь Эрүүгийн хэргийн хянан шийдвэрлэх процесс явуулж байгаа. Тэгэхдээ яах вэ зүгээр ер нь гэмт хэргийн объект, объектив бүрэлдэхүүн, гэмт хэргийн бүрэлдэхүүний талаар, тэр объектив, субъектив бүрэлдэхүүний талаар зарим талаар субъектив бүрэлдэхүүнтэй шийддэг хэргүүд байж болно. Нэн ялангуяа тэгэхдээ албан тушаалын хэрэг ч байдаг юм уу. тодорхой хэргүүдийн гэмт хэргийн бүрэлдэхүүний талаар энэ чинь нотлох баримттайгаа ч холбогдох байх. Хосбаяр Эрүүгийн хэргийн

танхимын тэргүүн сая Сарангэрэл гишүүний асуултын агуулга бас тэрэнтэй уялдаатай. Тодруулаад хариулчих уу? 93.

Одоогийн практик хууль хэрэглээд тэгээд онолын хувьд энэ 2 манай мөрдөж байгаа Ром Германы гэж хэлж болох эрүүгийн эрх зүйт онолын хувьд ер нь объектив, субъектив бүрэлдэхүүнийг юу гэж үздэг юм? 93.

Ч.Хосбаяр: Гэмт хэргийн бүрэлдэхүүн шинжийн талаар хуучин 4 элементтэй онолыг баримталж байсан бол сүүлийн арваад жил 2 элемент буюу хүний сэтгэл санааны байдал буюу өөрөөр хэлбэл сэдэл зорилго дээр нь антисироиз буюу тухайн үйлдлийн шинж чанартай холбогдсон ийм онол бол одоогоор баримтлагдаад явж байна.

Тэгэхээр энэ дээр мэдээж хэрэг болгон өөрийн нотолгооны стандартууд нь өөр байгаа. Тэгэхээр энэ гэмт хэргийн бүрэлдэхүүний бүрэн зөв шинжийг нотлохын тулд дү процесс тусгагдсан бүх ажиллагааг хийхээс өөр бол арга байхгүй. Зүгээр шүүгдэгч өөрийн хялбаршуулсан журмаар хэргээ шийдвэрлэх хүсэлт гаргаснаар энэ ажиллагааг зарим байдлаар хялбарчилж нотолгоог нь хөнгөвчилж байгаа. Энэ тохиолдолд өөрөө энэ эрхээсээ татгалзсан тохиолдолд л процессыг хялбаршуулах боломжтой. Тэгэхээр сая энэ Сарангэрэл гишүүний ярьсан энэ маргаан бол хэрвээ иргэний эрх зүйн хүрээнд шийдвэрлэгдэхээр бол энэ арилжааны шүүх буюу тодорхой шүүхэд маш түргэн шийддэг ийм шүүхүүд байгуулах асуудал яригдаж байгаа. Энэ хүрээнд шийдэж болох юм. Хэрвээ эрүүгийн эрх зүйгээр буюу өмчийн эсрэг гэмт хэргээр зүйлчлэгдэж ирсэн тохиолдолд дү процесс буюу шаардлагатай бүх ажиллагааг эцэст нь 100 хувь хөдөлбөргүй үнэн болтол нотлогдох энэ ажиллагааг хялбаршуулах боломжгүй.

Өөрсдөө хүсэлт гараад гэм буруугаа хүлээгээгүй тохиолдол ийм удаанаар л буюу хуульд заасан бүх ажиллагаа хийгдэж эцэслэн шийдвэрлэгдэх ийм л харагдаж байна.

Г.Занданшатар: Одонгийн Цогтгэрэл гишүүн.

О.Цогтгэрэл: Энэ Эрүүгийн процессын хуулийн тухайд ингээд хэлэлцэж байна л даа. Процесс гээд үзэхлээр иргэнийг сэжигтэн болгохоос эхлээд буруутай эс буруутай болохыг нотлох хүртэлх энэ маш өргөн хэмжээний ойлголт байх. Энэний зөвхөн тэр баривчлах асуудал. Баривчлах асуудлыг сая ёстой сэжиглэх асуудлыг ингээд ярихад л 99 хувийг нь шүүхийн шийдвэргүй баривчилсан, хойшлуулигүй ажиллагаа гээд. Энэ баривчилсан хүмүүсийн 50, 60 хувь нь тодорхой хугацааны дараа хорих шаардлагагүй болоод цаашаагаа процесс үргэлжилсэн гээд зөвхөн эндээс харахад л энэ хүний эрх гэдэг энэ сэжиглэхээс эхлээд шүүхийн алх цохих хүртэл энэ урт замын зөвхөн эхний нэг богинохон зам дээр хүний эрхийг зөрчиж болох хуулийн энэ маш том ангал энэ байдгийг энд ингээд л нотлох баримт тоонууд ингээд харуулж байна л даа.

Тэгэхээр энэ дээр бид нар энэ томоор нь харвал бид нар анхаарах зүйлсүүд асар олон зүйлүүд байгаад байна. Зөвхөн саянаас аваад зөвхөн эхний хэсэгт нь тийм хүний эрхийн зөрчил гарч болох ийм ангал цоорхой байхад энэ үргэлжилсэн бүх хугацаанд тэр шүүхийн процесс хүртлээ юу болдог эсэхийг үнэндээ бас мэдэхгүй. Тэгэхээр уржигдар Туваан гишүүн бид 2 санал тавиад Зүүнхараа дахь бүр шүүхээр шийдэгдчихсэн Зүүнхараа дахь нээлттэй хорих ангид хоригдож байгаа Даваагийн Мөнх-Эрдэнэ гэдэг залууг эргэж очлоо. Бас Шүүхийн шийдвэр гаргах гүйцэтгэх ерөнхий газрын удирдлагууд бас нөхцөл бололцоогоор хангаад бид нар өөр бас тэнд үндсэндээ хүмүүжиж байгаа

иргэдтэй бүр камерт нь орж бас уулзлаа. Үнэхээр бас энэн дээр ингээд ярих хэлэлцэх бид нарын ойлголтын зөрүү бас их олон асуудал байдаг юм байна лээ.

Тэнд байгаа жишээ нь ингээд олон нийт болоод ер нь энэ салбарыг мэдэхгүй хүмүүс юу гэж хэлдэг вэ гэхлээр ер нь л хууль чанга байх ёстой. Тэр магадлангаар гараад байна. Энийг нь болиулах ёстой. Тэр өршөөл энэрэл гэдэг зүйл байхгүй байх ёстой. Улам л чангалаад байх ёстой гэдэг. Яах вэ миний энэ ярьж байгаа хэсэг нь эрүүгийн процесс биш Эрүүгийн хуульд зарим нь хамаарч магадгүй.

Тэгэхдээ тэр 10 иргэн, 10 залуу юу гэж хэлсэн гэхээр бүгдээрээ календарын нь цаас гаргачихсан, тэмдэглэчихсэн. Нэг хоног ч гэсэн хасуулахын тулд тэр иргэд хэчнээн их тэр энэ дээр сахилгын шийтгэл авахгүй байх тухай бас тэр хууль дүрэм журмынхаа хүрээнд байх тухай хэчнээн их хичээдгийг бид нар бас тэнд үнэхээр бас харлаа.

Ангийн удирдлагууд нь ч гэсэн хэлж байна. Яг энэ магадлал нь энэ хуулийн энэрэл өршөөл байдаг учраас энэ хүмүүс бас илүү тийм хүмүүжих мотивац болдог.

Дахиад дээрээс нь энэ хуулиа биелүүлэх бас бид нарын ажлын гол мотивац бас энд байдаг гээд. Тэгэхээр магадлан, өршөөл, уучлал, цагаатгал гээд нэгэнт хүн алдаа гаргаад буруудчихсан байж болно. Гэтэл хуульд хууль бас нөгөө энэрэнгүй байх ёстой. Иргэндээ бас боломжийг олгодог байх ёстой. Тэгэхээр ер нь энэ болоод энэ бусад Эрүүгийн хууль дээр яг энэ зүйл заалтууд дээр ямар хөнгөлөлт, дэмжлэг, чөлөөлөлт ер нь энэ бодлого яаж хаашаагаа явж байгаа вэ?

Олон нийт болохоор ерөөсөө л тэр магадлангаар гарч болохгүй ингэдэг. Бид нар мэдэхгүй хүмүүс ороод яг тэр камерт нь ороод ингээд иргэдтэй ярилцахад нээрээ энэ чинь ямар чухал юм бэ? Энэ

олон мянган иргэдийн цаана аав ээж, ах дүү, амраг садан, үр хүүхэд, магадгүй 10, 20-иор үржүүлээд олон 100 мянган Монгол иргэдийн л асуудал энэний цаана хөндөгдөж байгаа юм байна. Тэгэхээр энэний цаана бид нар ингээд энэ ялын бодлого гэдэг зүйл тэр хатууруулна, эрүүлжүүлнэ, ялжуулна гээд нэг элдэв зүйл бас олон зүйл ингээд сонсогддог бодлогууд орж ирдэг.

Энэний цаана бид нар юуг хийх ёстой вэ? Тэгэхээр энэ яг энэ процессын хуульд энэ талын зүйлүүд хэрхэн яаж шингэж өгч байгаа вэ? Ер нь эрүүгийн дараагийн тэр яг эрүүгийн хуулийнх нь бодлого доор асуудлууд яаж тавигдаж байгаа вэ? Жишээ нь тэр магадлангаар ороход албан тушаалын хэрэгтэй хүмүүс орохгүй л гэж байна л даа. Энэ үнэхээр төрийн өндөр албан тушаалтнууд нь орохгүй байгаад нэг муу сургуулийн нярав, нягтлан байсан нөхөр нэг асуудалд орчихдог тэрийг насаар нь магадланд оруулахгүй гэвэл саяын тэр.

Г.Занданшатар: Хэн хариулах вэ? Хууль зүйн сайд хариулъя. 22 дугаар зүйл ангийг магадлалд оруулахгүй болохоор сургуулийн захирал байдаг юм уу янз бүрийн албан тушаалын хэргээр орчихоор магадлалд хамрагдахгүй байх юм уу гэсэн агуулга байна шүү дээ. Зөвхөн улс төрд нөлөө бүхий этгээдүүд ч юм уу гэсэн агуулгатай л юм байна гэж ойлголоо.

Баттөмөрийн Энхбаяр сайд хариулъя.

Б.Энхбаяр: Хүний эрхийг хангах чиглэлд бол Ардчилсан нам, Монгол Ардын нам бол хамтдаа зогсож явсаар ирсэн. Тухайлбал 2015 оны буюу Ардчилсан нам олонх байх үед батлагдсан хуульд 2017 оны 7 сарын 1-нд өөрчлөлт тодотгол 49 хувьд нь өөрчлөлт орж хүчин төгөлдөр болсон байдаг юм. Өөрөөр хэлбэл одоогийн Эрүүгийн хууль бол бас Ардчилсан нам, Монгол Ардын намын хамтын бүтээл гэж ойлгож бас болно.

Тийм. Тэр ч утгаараа одоо энэ Ганбат дарга байж байна. Бас Хууль зүйн байнгын хорооны дарга байсан. Яг энэ хуулийн ажлын хэсгийн ахлагч нь байсан Улсын Их Хурлын. Энэний үр дүн гарч байгааг би сая эхний танилцуулгадаа хэлчихсэн байгаа юм. Өөрөөр хэлбэл энэ шинэ хууль эрх зүйн орчин үйлчлэхээс өмнө цагдан хоригдсон хүмүүсийн 5 хүний нэг нь л шүүх рүү явдаг байсан бол одоо 5 хүний 4 нь явж байна буюу бид нар ер нь голтой буруутай гэж байгаа хүмүүсээ л цагдан хорьдог болсон байна л гэсэн үг.

Энэ хаа хамаагүй хүмүүсийг хамжж шимж аваад хонгилдоод байдаг нь эрс багасчихсан байна гэдгийн нэг үзүүлэлт. Шинэ хуулийн эффект гарч байна гэсэн үг.

Хоёр дахь үр дүн Цагдан хорьж таслан сэргийлэх арга хэмжээ авч байгаа хүмүүсийн тоо 2000 оноос хойш тасралтгүй буурч байна. Хүмүүс болохоор нэг Мөнх-Эрдэнэ ч гэдэг юм уу энэ 1, 2 хүний асуудлыг ингээд л үндэсний хэмжээнд л нэг ингээд л бүгдийг нь хориод л бариад л, цагдаад л шоронжоод л байгаа юм шигээр л ингэж мэдээлэл нь болохоор түгээгддэг. Бодитой статистикийн мэдээллийг нь харахад жишээлбэл 2020 онд цагдан хорьсон хүний тоо 1751, 1721 онд 1291, одоо 2023 онд 965. 2000 онд цагдан хорьдог байсан хүмүүсээс 2023 он гэхэд 2 дахин буурчхаад байгаа байхгүй юу. Цагдан хорьж шалгадаг юм чинь. Яг энэ тоог харах юм бол хүмүүс ойлгох байх. Үнэхээр одоо энэ хорьж шалгадаг яадаг юмнууд их багасаж байгаа юм байна гэж.

Эрүүгийн хуулийн тухайд бол Мөнх-Эрдэнийг суллахгүй байх гэж Эрүүгийн хууль санаачлаагүй. Хэн нэгэнд ер нь зориулж хууль санаачилж болохгүй. Энэ бол үндсэн зарчим байдаг. Хэн нэгний мууг үзэх хэн нэгэнд давуу байдал олгох зорилгоор хууль баталж болохгүй ээ гэдэг энэ бол суурь зарчим. Тэр утгаараа яах вэ Мөнх-Эрдэнэ авлига албан тушаалын хэргээр ял шийтгэгдэж, ял эдэлж байгаа

юм байна лээ. Яг энэ хуультай бол хамаагүй. Нөгөө түрүүчийн 7 хоногт хэлэлцдэг Эрүүгийн хууль дээр бол авлига албан тушаалын гэмт хэргээр ял шийтгэгдэж байгаа этгээдийг хорих ялын хугацаанаас өмнө суллахгүй ээ гэдэг хууль өргөн баригдсан. Энэ бол одоо гишүүд маань тэгээд өөрсдөө.

Г.Занданшатар: Одонгийн Цогтгэрэл гишүүн тодруулж асууя.

О.Цогтгэрэл: Бид бүгд ингээд хууль ярьж байна. Хуулийн яг эх үндэс язгуур мэдээж бид нар Үндсэн хуулиасаа л эхлэх ёстой. Бид нар үндсэн хуулийн эхний бүлэгт бид нар хүмүүнлэг улс байгуулна, энэрэнгүй улс байгуулна гэдэг, иргэний улс байгуулна гэдэг ийм л заалтыг язгуур үндэс болгож л авч явах ёстой. Тэгэхээр хүмүүнлэг улс гэдэгт иргэндээ боломж олгодог. Иргэндээ байтугай алдсан эндсэн иргэндээ ч боломж олгодог энэ улсыг л бас хүмүүнлэг байна л гэж ойлгож байгаа.

Тийм учраас энэ ялын бодлого олон зүйл энэ процессын хуулиуд дээр бид нар хүний эрх, эрх чөлөө рүүгээ бас олон талын зүйлийг бодох ёстой.

Хоёрдугаарт нь тэр иргэний улс гэдэг бас л Үндсэн хуулийн заалт. Хүмүүнлэг иргэний улс байгуулна, ардчилсан улс байгуулна. Сүүлийн үед бас зарим иргэний аж ахуйн шинжтэй ажлууд дээр Тээврийн газрын удирдлага л гэнэ.

Г.Занданшатар: Максимын Чинбат 82. Үндсэн хуулийн дагуу бол хэрэг мөрдөх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх үйл ажиллагаанд хяналт тавих үүрэгтэй шүү дээ. Эрхтэй бас, тэгээд ял эдлүүлэх ажиллагаатай холбоотой асуудал бас Цогтгэрэл гишүүн яриад байсан. Тэрийг нь шалгасан юм уу, үгүй юм уу? Тэрийг шалгаагүй бол шалгаад. Хариулчихъя 82.

М.Чинбат: Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя.

Тэгэхдээ энд бас бид сая хуулийн үзэл баримтлалыг ярьж танилцуулсан бас зөв ойлгож, зөв мэдээллийг бас нийтэд өгөх ёстой л доо бид. Энэ хуулийн ажил үргэлж хуулийн хэсэгтээ ажиллаж байгаа улсууд ч гэсэн өгөх нь дутмаг юм болов уу гэж би зүгээр сая бодож байна. Гишүүдийн хэлж байгаа асуудлыг аваад үзэхэд. Тэгэхээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа анхнаасаа хууль зөрчөөд ингээд явчхаж байгаа юм шиг. Тухайлбал одоо баривчилсан сэжигтний 40 орчим хувийг нь шүүх прокурор сулласан. Сулласан асуудал нь өөрөө энэ тухайн хүнийг сулласан хүнийг гэмт хэрэгт холбогдолгүй гэж суллаж байгаа асуудал биш шүү дээ. Энэ хүн суллагдаад цаашаага таслан сэргийлэх арга хэмжээг нь цагдан хорихгүй ээ. Батлан даалтад өгөх гэдэг нь бусад таслан сэргийлэх арга хэмжээнд хэрэглэгдээд, тухайн эрүүгийн хэрэг дээр шалгагдаад ингээд явж байгаа юм.

Түүнээс биш сулласнаараа энэ хүн гэмт хэрэг үйлдээгүй гэж бас иүүд утгаар нь ойлгож бас болохгүй э. Тийм учраас энэнээс цаашаа үргэлжлээд явж байгаа процесс нь өөрөө хуулиа зөрчөөд ингээд явчих юм уу гэж ингэж яриад байна л даа. Тэгэхээр энэ дээр бол бид бас зөв ойлголтыг нь та бүхэнд өгөх ёстой юм байна. Та бүхэн энэ Их Хурлын танхимд яригдаж байгаа асуудал бас олон нийтэд хүрэх учраас агуулгыг нь бас зөв ойлгож ингэж хэрэглэж нийтэд бас хүртээл болох ёстой гэж би бодож байна.

Мөнх-Эрдэнийн хувьд бол өөрөө сошиал орчинд идэвхтэй байсан иргэн. Гэхдээ өнөөдрийн байдлаар шүүхийн хүчин төгөлдөр тогтоолоор эрх нь ял шийтгэл хүлээгээд эрх нь хязгаарлагдсан хорих байгууллагад ажиллаж байгаа хүн. Тэгэхээр тэнд болсон үйл явдлыг өнөөдөр прокурорын байгууллага байнгын хяналтдаа тавьж ажиллаж байгаа. Дээр нь хүний эрхийн комисс яг энэ мэдээллийн

дагуу сошиал орчинд болсон үйл явдлын дагуу өөрөө очиж шалгаж хөндлөнгийн хөндлөн байгууллага өөрөө очиж.

Г.Занданшатар: Зочид танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Ширнэнбандийн Адьяагийн урилгаар Ховд аймгийн музейн ажилтнууд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд гишүүдийн өмнөөс сайн сайхныг хүсэн ерөөе өө. Ширнэнбандийн Адьяа гишүүн асуулт асууна.

Ш.Адьяа: Өнөөдөр энэ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэж байна. Өчигдөр Хууль зүйн байнгын хороогоор бид хэлэлцсэн. Үзэл баримтлалын хувьд бол энэ хуулийн төслийг хэлэлцэхийг бол дэмжиж байгаа. Гэхдээ энд бас зайлшгүй хэлэлцүүлгийн явцад шийдэх ёстой шийдэл гаргах ёстой асуудал байгаа. Энэ эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэнэ гэдэг бол хүний эрхтэй холбоотой. Хэргийн хувь заяатай холбоотой. Нийгэмд хор учруулсан энэ харилцааг зохицуулахад зориулсан ийм онцгой ач холбогдолтой ийм хууль байдаг.

Өнөөдөр хүний эрхийг хангах талаасаа Монгол Улсын Үндсэн хуулийн зарчмыг биелүүлэх талаасаа олон улсын өмнө Монгол Улсын хүлээх үүрэг хариуцлагын хүрээнд хүний эрхийн тухайд энэ хууль ач холбогдолтой гэвэл ач холбогдолтой. Гэхдээ энд олон зүйлийг бид олон талаас ярьж шийдэх ёстой гэж бодож байгаа. Энэ ойр ойрхон энэ Эрүүгийн хуулиа, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай энэ хуульдаа ингээд л өөрчлөлт оруулаад л байгаа нь ямар үр дагавар авч ирэх вэ л гэж бид тооцох ёстой гэж бодож байгаа. Өнөөдөр ингээд нийгмийн сэтгэл зүй үүнд олон сайн муу зүйл бий болж нийгмийн сэтгэл зүйд тааруулсан зарим асуудлаар бид нар энэ хэрэг мөрдөх шалгах ажиллагаа дээр

хүний эрх гэдэг асуудлын доор бас хандаж болмооргүй байгаа юм. Болмооргүй байгаа юм.

Энд одоо мөрдөх байгууллага, прокурор 2 одоо нэг баахан хүмүүсийг ингээд л бариад л, цагдаад л, хориод л ингээд л нэг л их хууль бус юм хийчихсэн юм шиг энийг минь сэтгэл зүйд явуулаад байгаа нь бас ер нь зөв үү буруу юу? Энд олон талаас бодох ёстой асуудал. Тэгээд одоо ингээд энэ хуулиар мөрдөх байгууллага прокурор 2 бол шүүх эрх мэдэлд энэ хэргийн хувь заяаг бүгдийг нь даатгах ийм нөхцөл байдал үүссэн. Тэгэхээр энэ шүүгч нараа бид нар энэ ажлын бус цагаар яаж ажиллуулах юм. Энэ дээр тодорхой болгож өгье. Орон тоог нь нэмж өгье төсвийг нь шийдэж өгье.

Бусад нөхцөлийг нь энэ хуулиар тодорхой болгож өгье. Тэрнээс биш өнөөдөр дунд нь орхиод л шүүх мэднэ гэдэг. Өнөөдөр мөрдөх байгууллага прокурор 2 чинь энэ хүн хүн алчихлаа гээд заагаад өгсөн тохиолдолд шалгахгүй яах юм. Хойшлуулишгүй арга хэмжээ авах юм уу. Ийм юман дээр бид нар олон талаас нь ярьж хэлж шийдэх ёстой гэж бодож байгаа. Нөгөө талаас энэ гүйцэтгэх ажлыг явуулах хэргүүдийг тодорхой хязгаарлалт тавьсан. Хөнгөн, хүнд ач холбогдолтой, ач холбогдолгүй хэрэг гэж байхгүй ээ. Гүйцэтгэх ажлын шугамаар гүйцэтгэх ажил явуулж байж олон хэрэг зөрчил илэрдэг юм шүү дээ.

25 жилийн дараа ч энэ хэрэг илэрч л байсан. Ийм учраас энэ дээр бас энэ эрүүгийн нөхцөл байдал гэмт хэргийн илрүүлэлт энэ нөхцөл байдлуудаа тодорхой тооцож энэ дээр дүгнэлт хийж байж ингэж шийдэх шаардлагатай байх. Аливаа юмыг сэтгэлийн хөөрлөөр, нийгмийн шүүмжлэлээр шийдээд байвал энэ чинь эрүүгийн хэрэг мөрдөх шалгах гэмт хэргийг илрүүлэх гэдэг тийм амар асуудал биш шүү дээ. Энийг бол энд нэг хэдэн Их Хурлын гишүүд суугаад

судалгааны байгууллага ОУБ-ын дүгнэлт дээр тулгуурлаад тэр хүний эрхийн Олон улсын байгууллагын шаардлага дээр тулгуурлаад Монгол Улсад энэ эрүүгийн хэрэг мөрдөх, шалгах энэ үйл ажиллагааг ийм байдлаар бас явбал өөр муу үр дагавар гарч байхыг ч үгүйсгэхгүй байх гэж бодож байна.

Г.Занданшатар: Үг хэлчихлээ. Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууна.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа.

Би нэг 2, 3 зүйл хэлээд орхиё оо.

Нэгдүгээрт бол би энэ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд энэ ойр ойрхон ийм өөрчлөлтүүд оруулаад байгаа. Энэ нь хууль хяналтын байгууллагууд, шүүх, прокурор, мөрдөх байгууллага. Хорих өөр юу байдаг юм, өмгөөлөгч, өмгөөллийн байгууллага энэ талаасаа ер нь та бүхэн маань юу гэж үздэг юм бэ? Энэ талаар нэг тус тусдаа хариулт өгөх бололцоо байх уу гэж.

Дарга нарын авлигал хулгайн хэрэгт хүлээлгэх ялын бодлогыг чангатгах ийм өөрчлөлт орсон. Энэ зайлишгүй ээ. Өнөөдрийн Монгол Улсын уруудан доройтож байгаа энэ нийгмийн хагарал тэмцэл нийгмийн тэгш бус баян хоосны ялгаа, орлогын тэгш бус байдал, улс орон урагшаа ахиж дэвшдэггүй. Өнөөгийн бүүр ерөөсөө суурь шалтгаан бол энэ 30 жил авлигал цэцэглэсний л хорт үр дагавар гэж. Яг энэ маягаараа өнгөрөх юм бол энэ улс орон удаан оршин тогтнох ямар ч үндэс байхгүй. Тийм учраас нийтээрээ авлигалын эсрэг энэ тэмцлийн энэ хүрээнд тэр хуульд бол өөрчлөлт оруулсан. Энийг бүрэн дүүрэн дэмжиж байгаа. Энэ хүүхдийн гэмт хэрэг, хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй холбоотой хүүхдийн хүчирхийлэлтэй холбоотой бас өөрчлөлт орох нь.

Өнөөдрийн энэ хуулийн төсөл ярьж байна. Тэгэхээр энд талаас нь та бүхэн маань ямархуу зүйлийг хэлэх вэ гэж нэг ийм асуулт байна. Нөгөө нэг юм нь бол одоо энэ шүүхийн гаргасан шийдвэр их эргээж буцах юм. Уймраа хүн гэж ярьдаг шүү дээ тэрэн шиг л Зоригийн алагатай холбоотой нөгөө хэрэг чинь юу боллоо. Бид бүгдээрээ мэдэж байгаа. Дараагаар нь хамгийн сүүлийнх нь бол Махбал гэж аллага хийсэн. Энэ хүнд хүлээлгэсэн тэр хугацаанаас нь өмнө сулласан. Одоо дахиад энийг чинь эргүүлээд хорино гэж ярьж байна шүү дээ. Үгүй ээ ингээд эргээд хургаад байдаг. Түрүүн Даваасүрэн гишүүн хэлсэн. Энэ дарга нарын авлигал хулгайн асуудал нэг мөр шийтгэгчээд л тэгээд л дорхноо л шийдвэр нь өөрчлөгдөөд л, суллаад, суллаад л, тавиад тавиад явчихдаг.

Нөгөөдүүл нь нийгэмд гарч ирээд л жигтэйхэн мундаг сайхан улсууд. Бүүр соён гэгээрүүлэгч, бүүр номлогч нар болчихсон. Энэ социал хэвлэл мэдээллийг харж байх юм бол тэр улсад л ном айлдаж байх юм байна шүү дээ. Яасан ч ичдэггүй юм. Яагаад ийм байдалтай байдаг юм? Ийм болохоор чинь шүүх хуулийн байгууллагад чинь итгэх итгэл үнэндээ алга болоод байна шүү дээ. Ийм зүйлийг би асуух гээд байгаа юм. Одоо бид нар энэ Хөгжлийн банкны асуудлаар ажлын хэсэг гаргаад дараагаар нь Их Хурал Түр хороо байгуулаад ингээд бид нар ажилласан. Тэгээд эцэст нь юу болов? Нэг сайшаалтай нь юу болоод өнгөрсөн бэ гэдгийг ард түмэнд иргэд мэдэх эрхийнх нь хүрээнд сайн тавьж өглөө. Гэтэл бол ямар дүр зураг харагдаж байгаа вэ гэхээр эрх мэдэлтэй хөрөнгөтэй тийм улсууд нь л бол зүгээр сулраад гарчхаж байгаа юм.

Тэгээд хөөрхий нэг ядруухандуу юм уу даа гэмээр улс нь л тэгээд л торонд дээр баригдаад л үлдэж байгаа тийм л дүр зураг харагдаад байгаа юм.

Г.Занданшатар: Батаагийн Батцэрэн 80. Эрүүгийн хэргийн Эрүүгийн танхимын шүүгч.

Б.Батцэрэн: Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя.

Тэгэхээр тодорхой төрлийн хэргүүд түүний дотор бага насны хүүхдийг хүчирхийлэх мөн авлига албан тушаалын хэрэг дээр ялын бодлогыг чангатгах тухай талаар Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах энэ хуулийн төслийг Улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаан хэлэлцсэн. Хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар бас санал өгөх эрхтэй. Энэ эрхийнхээ хүрээнд тэгэхлээр энэ ял төрийн бодлогыг тодорхойлох асуудал бол Улсын Их Хурлын бүрэн эрхэд хамаарах асуудал. Тэгэхлээр яг энэ асуудал дээр Улсын дээд шүүх тусгайлан саналгүй байгаа.

Ер нь 2015 онд Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгыг батлан гаргахдаа тэр өмнөх 2002 оны хуулийн ялын хэрэгжилт үр дүн. Тэгээд энэ бусад улс орнууд түүний дотор энэ эх газрын эрх зүйн тогтолцоотой улс орнуудад бол нийтлэг байдлаар энэ урт удаан хугацаагаар хорих явдлаас татгалзаж энэ ялын хэмжээг бууруулж байгаа.

Мөн ялын зорилго нь хүнийг цээрлүүлэхээс гадна хүмүүжүүлэх нийгэмшүүлэх тэр зорилгыг давхар агуулдаг. Энэ нөхцөл байдлыг харгалзаж 25 жил дээд тал нь ял өгдөг байсныг 20 жил болгож бууруулсан. Цаазаар авах ялаас татгалзаж бүх насаар хорих ялыг Эрүүгийн хуулийн 15 зүйл хэсэг дээр тусгасан байгаа. Ингээд энэ хүрээнд энэ ял оногдуулах асуудал хэрэгжиж байна шүүхээр.

Яг энэ тодорхой төрлийн хэргүүд дээр бол нэмэх асуудал дээр Улсын дээд шүүх тодорхой саналгүй байна. Энэ Хөгжлийн банкны хэрэг болоод энэ бусад

хэргүүд бол давах хяналтын шатны шүүхээр хэлэлцэгдээгүй байгаа. Энэ дээр бас урьдчилж байр суурь илэрхийлэх боломжгүй байна.

Г.Занданшатар:

Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн тодруулна.

Б.Бат-Эрдэнэ: Эрүүгийн хуульд ингээд ойр ойрхон өөрчлөлт орж байгаа нь та бүхний ажилд ямархуу нөлөө үзүүлж байна аа? Ер нь ингэж Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулаад байх нь зөв юм уу? Ямар байна гэдгийг л би хариулт өгөөч ээ л гэж энэ оролцож байгаа ажлын хэсгийн улсуудаас би асуусан.

Дараагийнх нь юм бол өнөөдөр энэ саатуулахтай холбоотой баривчлахтай холбоотой асуудал яригдаж байгаа юм. Тэгээд энэ хорьж цагдаж байгаа. Би энэ тодорхой л юм асуугаад байна л даа. Одоо тэр нөгөө нүүрсний хулгайн асуудалд холбогдож байгаа Ганхуяг бол ингээд 8, 9 сар намайг хориод ерөөсөө 1 ч байцаалт мэдүүлэг аваагүй гэж яриад байгаа шүү дээ. Намайг баталгаатайгаар миний нэг үг хэлэх бололцоог надад олгож өгөөч ээ гээд. Нэг жишээ. Нөгөөдөх нь бол Зоригийн аллагатай холбоотой тэр Чимгээ гэж эмэгтэйг яаж эрүүдэн таамаглаж харгис хэрцгийгээр байгааг бол энэ чинь нийгэмд нөгөө видео юугаар тавигдчихсан шүү дээ.

Г.Занданшатар: Хэн хариулах вэ? Ажлын хэсгээс гэсэн л дээ. Шүүх мөрдөх тодорхой хэрэг ярихгүй байх. Зүгээр яах вэ энэ процесстой холбогдоод Баттөмөрийн Энхбаяр сайд хариулъя.

Б.Энхбаяр: Би ер нь хэрэг ярьдаг биш, хүний эрх ярьдаг сайд байя гэсэн лоозон өөртөө хэлчихсэн байгаа. Урьдчилан шалгагдаж байгаа, мөрдөн шалгалт ажиллагаа хийгдэж байгаа асуудлаар ер нь улс төрч тэр тусмаа Хууль зүйн сайд урьдчилсан байр суурь илэрхийлж явах нь их буруу гэж үздэг.

Тийм учраас би өөрөө үлгэрлэх ёстой. Нөгөө талаар шүүгчийн шүүн таслах ажиллагаа хэрэгжүүлсэнтэй холбоотой тодорхой хэрэг маргааны талаар байр суурийг асуух асуух нь шүүхийн хуулиар хориотой бөгөөд нөлөөлөлд тооцогдоно.

Тийм учраас энийг шүүхийн хуулиар бас хориглочихсон байгаа. Шүүгчээс шийдвэрлэсэн шийдвэрлэх гэж байгаа хэргийн талаар тодорхой хэргийн талаар байр суурь асуух нь өөрөө хуулиар бас хориотой байх?

Г.Занданшатар: Үндсэн хуульд болон Шүүхийн тухай хуульд маргаан таслах ажиллагаанд оролцохгүй гэж байгаа л даа. Тэгэхдээ энэ зүгээр хүний эрхийн талаасаа ч юм уу, процессын талаасаа ийм кэйс байна. 8, 9 сар хүнийг хорьчихоод ганц ч мэдүүлэг авдаггүй тийм кэйс байгаа юм уу гэж мөрдөх байгууллагуудаас асуулаа гэж ойлголоо шүү дээ энэ тэ. Тэр мөрдөх байгууллагууд л ойлгох байх. Прокурор хариулах юм уу? Тийм. Прокурор л мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих үүрэгтэй учраас Максимын Чинбат хариулъя. 82.

М.Чинбат: Бат-Эрдэнэ гишүүний тодруулсан асуултад хариулъя.

Г.Занданшатар: Хүнээс огт мэдүүлэг авахгүй ингээд 8, 9 сар хүрээд байна гэдэг чинь таслан сэргийлэх цагдан хорих агуулгатай зөрчилдөөд байгаа юм уу гэсэн асуулт асуулаа л гэж ойлгох. Хэргийн тухай тухайн тодорхой хэргийн тухай биш тийм кэйсүүд байдаг юм уу?

М.Чинбат: Ер нь тийм өөрөөс нь мэдүүлэг авахгүйгээр удаан хугацаагаар хорьдог гэдэг юм уу тийм кэйс тохиолдол байх ёсгүй ээ, байхгүй ээ. Тодорхойлсон энэ хэрэг дээр бас бид энэ дээр хариулт өгөх боломжгүй. Өөрөө яллагдагч өгөхгүй гэсэн тохиолдолд мэдүүлэг авах бас боломжгүй. Ер нь яах аргагүй зайлиггүй

мэдүүлэг өгөх үү, өгөхгүй юу гэдгийг бол мөрдөн шалгах ажиллагааны явцад асууж байгаа. Асуух тийм тодруулах, санал хүсэлтийг нь авах хуулийн зохицуулалт хэрэгжиж байгаа гэж ойлгож болно оо.

Г.Занданшатар: Дашдондогийн Ганбат гишүүн асуулт асууна.

Д.Ганбат: Өнөөдөр Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуульд өөрчлөлт оруулах талаар ярилцаж байна. Хэлэлцэх эсэхийг шийдэж байна. 2015 онд Эрүүгийн хуулийг шинэчлэн найруулж баталсан. Энэний дараа 2016 онд ганцхан Улсын Их Хурлын дарга алх тогших л үлдээд байсан. Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх хуулийг батлалгүй орхисон. Энэний дараа олонх 47 хувийн өөрчлөлт оруулаад ингээд явсан. Уг хуулиуд маань угаасаа жишиг хуулиа тэр дэлхий нийтийн ийм л юунд орсон.

Өмнө нь бид зөвлөлт маягийн шоронжсон хуулиар ингэж явж байсан. Сая Хууль зүйн сайдтай бол санал нийлж байна. Энэ ч үр дүнгээ өгсөн. Энэ удаан хугацаанд 7, 8 жил хэрэгжээд явж байхад шорон бол тухайн үед нэг 10-аад мянган хүн байдаг байсан одоо хэд вэ? Нэлээн багассан байх. Ер нь хэд байгааг бас хариулчхаарай. Өмнө нь хэд байсан юм? Хэд хэдэн зүйл байна.

Өнөөдөр тэр авлига, албан тушаал, энэ улс орныг ийм байхад үнэтэй хувь нэмэр оруулсан том том дарга нар бол одоо ингээд сайхан эрх мэдлээ хадгалаад энэ хууль хяналтын байгууллагад нөлөөлөөд ингээд явж байна. Тэр хүмүүсийн эргэн тойрных нь ч гэсэн ямар нэгэн хариуцлага хүлээхгүй байна. Тэгээд энэ мөрдөн байцаалтын нууцыг задруулахгүй байх ийм хүмүүс байдаг шүү дээ тэр мөрдөгч нь, хяналт тавьж байгаа прокурор нь.

Энэ хяналтаас яагаад гадуур задраад байдаг юм бэ? Тэрийг нь бол би ингэж ойлгож байгаа. Зориуд дуулианаар

дуулианыг дарах ийм л ажлыг хийж байна. Иргэдийн анхаарлыг өөр зүйлд хандуулахын тулд тэрний нэг нь би энэ Мөнх-Эрдэнийн кэйс гэж үзэж байна. Ер нь очиж харлаа үзлээ яалаа. Бид бүхэн хүний эрх талаар ярьдаг хүний эрхийг дээдэлдэг ийм Хууль зүйн сайд би байна гэж манай Хууль зүйн сайд хэлж байна. Энэ их сайн байна. Өмнөх 3, 4 жилүүдэд миний мэдэж байгаагаар хүний эрхийн асуудал их хүнд болсон. Хэр үгээ хэлдэг, үзэл бодлоо илэрхийлдэг иргэдийн маань энэ шүүх энэ хууль хяналтын байгууллагуудыг бүгдийг нь ашиглаж амыг нь барьдаг болсон.

Хэрвээ тэд нар маань үгээ хэлээд үзэл бодлоо илэрхийлээд эрхээ эдэлж байсан бол өнөөдөр ийм цавчаа нийслэл тэр чигээрээ, автобусгүй өвлийн хүйтэнд байх мөн энэ аймаг, дүүрэг дээр явж байгаа тендерүүд энэ мөнгөний ер нь 30 хувь нь л нэг ажил болдог шүү дээ. Их чанар муутай ажил болдог. Тийм зүйл болохооргүй байх байлаа л даа. Энийг юу гэж үзэж байна вэ? Манай тэр Мөнх-Эрдэнийн яриад байгаагаар би энэ байгууллага дээрээс амьд гарах магадлал тун бага байна гэж өөрийгөө үзэж байна гэж хэлж байна лээ.

Би тэр байдлыг нь хараад ер нь энэ шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллага маань энэ хүний эрхийн талаар ярьдаг дуугардаг хүмүүсийн амыг барихын тулд гүйцэтгэх ажил явуулаад байна уу даа. Энэ шүүх нь тэр авлигачдад албан тушаалын эрхтэй хүмүүст хамгийн бага ял ирдэг юм. Шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллага нь хүн алсан, энэ улс орныг тоносон энэ эрх мэдэлтэй улсуудад магадланд орох 2, 3 бүүр 7 удаагийн боломжийг өгөх гэж оролдох юм. Яагаад ийм байдаг юм бэ? Харин би прокурор л нэг их сүүлийн үед нэг хууль биелүүлэхийн төлөө яваад байна уу л гэж хараад байна. Арай дээр болчихсон юм шиг байгаа юм. Тэгээд энэ шүүгч нарын ачаалал энэ мөрдөн байцаагчийн ачаалал.

Г.Занданшатар: Ачаалал их нэмэгдсэн. Батмөрийн Энхбаяр сайд хариулна.

Б.Энхбаяр: Ганбат гишүүн энэ 2015 оны Эрүүгийн хууль Эрүүгийн процессын хуулийн ажлын хэсгийг бас манлайлж ахалж, батлуулж байсан. Бид бол бас хамтдаа энэ шүүхийн хуулийн ажлын хэсэг ер нь энэ процессын хуулийн олон асуудлууд дээр бас хамт зогсож явж байгаа. Би ер нь Ганбат гишүүнийг хүний эрхийн талд бол өндөр улс төрийн манлайлалтай, мэдрэмжтэй бас тууштай зоригтой гишүүн гэж бас дотроо бас үнэлж явдаг байгаа. Тэгэхдээ энэ авлигын гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийг магадлангаар суллахгүй ээ гэдэг хуулийг байна шүү дээ.

Энэ Мөнх-Эрдэнэд зориулсан гэж манай Ардчилсан намын гишүүд ойлгоод тэгээд л нөгөө би суллагдахгүй болчихлоо гэж ойлгоод л тэгээд нэг улс төр бас хажуугаар нь оруулаад сүүлдээ энэ Энхбаяр бараг нэг хэдэн нөхдүүд яваад зодчихсон байна ч гэж ойлгоод байгаа юм уу? Би ерөөсөө бүр ойлгохоо болиод байгаа.

Энэ Эрүүгийн хуулийн чинь үндсэн зарчим байгаа шүү дээ. Энэ чинь буцаан хэрэглэхгүй. Эрүүгийн хууль чинь батлагдсан өдрөөсөө хойш үйлдэгдсэн хэрэг дээр л үйлчилдэг юм шүү дээ энэ чинь. Одоо энэ хорих ял эдлээд сууж байгаа хүмүүст батлагдаагүй хууль үйлчлэхгүй шүү дээ. Энийгээ ерөөсөө ойлгодоггүй юм болов уу.

Жишээлбэл энэ бага насны хүүхдийг хүчиндэх, бусдыг санаатай алах, авлига, албан тушаалын гэмт хэргээр магадлангаар суллахгүй ээ хорих ялаас өмнө суллахгүй ээ гэдэг хууль хэзээ үйлчлэх вэ гэхээр энэ хууль хүчин төгөлдөр болсноос хойш батлагдаад хүчин төгөлдөр болсноос хойш ял шийтгэгдээд хорих ял шийтгэгдэж байгаа тэр хүмүүс дээр үйлчлэх байхгүй юу. Одоо хорих ял

эдэлж байгаа хүмүүс чинь энэ чинь буцаж үйлчлэхгүй шүү дээ. Батлагдаагүй хууль. Тэгээд энэ зарчмаа ойлгохгүй энэ авлигатай тэмцье гээд байгаа юм байгаа биз дээ.

Ер нь хатуу байя гээд байгаа биз дээ. Авлигачдыг өршөөхгүй уучлахгүй л байя гэж байгаа биз дээ. Энэ дээрээ хатуу байя гэж байгаа шүү дээ. Тэгэнгүүт энэ манай Мөнх-Эрдэнийг суллахгүй гэдэг хууль оруулж ирлээ гээд л ингээд л ойлгочихсон юм уу яасан юм. Ерөөсөө нэг л ийм л юм ер нь байна шүү дээ. Би хэлээд байгаа шүү дээ. Энэ хууль гэдэг юмыг чинь хэн нэгэнд зориулаад л үгүй ээ би жишээлбэл тэр Мөнх-Эрдэнийг чинь авлигын хэргээр ял эдэлж байгаа ч гэж би мэдээгүй байсан. Жишээлбэл.

Тэгээд ингээд энэ нэг бие биеийгээ үл ойлгодог, хардсан, сэрдсэн нэг ийм юмаа больчихмоор байгаа юм. Ганбаа дарга та бас л ухааны цартай хүн шүү дээ. Бас нөхдөдөө бас сайн уламжилж хэлмээр байна. Тэгж ойлгоод байгаа юм байна лээ шүү.

Г.Занданшатар: Дашдондогийн Ганбат гишүүн тодруулж асууя.

Д.Ганбат: Саяын Энхбаяр сайдын хэлэлцээд байгаа ойлгомжтой асуудал. Тэрэн дээр маргалдаад байх юм ерөөсөө алга. Ер нь цаашидаа юмаа нөхцөл байдлаа яаж сайжруулах вэ гэдгээ л бид нар ярьж байна шүү дээ. Зүгээр би кэйсийг нь давтаж байна. Энэ цагдан хорих байгууллага, шүүхийн шийдвэрийн байгууллага тэр гүйцэтгэх ажил явуулж байна уу явуулахгүй байна уу? Зориуд тэгэхийн тулд би тэрийг чинь асууж байна.

Нөгөө 2 дугаарт яг ингээд иргэн хоригдож байхдаа амиа алдсан тохиолдол бий шүү дээ. Би нэг шүүгч нас барсныг мэдэх юм байна. Тэр хариуцлагыг хүлээдэг юм уу, хүлээдэггүй юм уу? Ийм зүйлийг асууя. Одоо тэгээд бас эд нарын

ачаалал бас их маш их өндөр юм шиг байгаа юм.

Нэг хүн дээр хэчнээн хэрэг байдаг юм, хэчнээн хэргийг яадаг юм мөрдөн байцаадаг юм. Тэр бас нэг зохистой түвшинд баймаар байх шиг байгаа юм. Тэгэхгүй бол хэрээс хэтэрсэн юм бас бид нар шаардаад байж болохгүй. Бүр ажиллах хүнгүй ч болох юм шиг байгаа юм. Тэгээд бас нэг шаардлага хангасан шүүхийн танхимтай ч болмоор юм шиг байгаа юм. Тийм танхим ерөөсөө байхгүй шүү дээ стандарт.

Г.Занданшатар: Энхбаяр сайд хариулъя. Баттөмөрийн Энхбаяр сайд.

Б.Энхбаяр: Мэдээж одоо хүний эрхийг бүх түвшинд ялангуяа энэ хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, шүүн таслах ажиллагааны шатанд хангах асуудал их тийм цогц асуудал л даа. Тэгээд энэ бол тасралтгүй хийгдэх ажил. Энэ бидний өнөөдөр ярьж байгаа хууль батлагдахад маргаашийн зарчим яригдах ёстой. Нөгөөдөр дахиад л бид яригдана. Сонор сэрэмжээ ерөөсөө алхам ч хойшлуулж болохгүй ийм л асуудал.

20 жилийн өмнө одоо бөөнөөр нь цагдан хорих байр маань Ганц худаг гэж байхад юу байлаа. Одоо шинэ цагдан хорих байранд болсон бүх шүүхийн шийдвэр аймгийн шийдвэр гүйцэтгэх байгууллагууд энэ цагдан хорих байрны асуудал дээр яг орчин үеийн хүний эрхийн стандартад хангасан ийм байриудтай болсон. Энд бол бас л арваад жилийн хугацаанд л энэ ажлууд улсын төсвийн хүрээнд л бас шийдэгдэж явж байгаа.

Цаашидаа ч ингээд явна. Цаашилах юм бол яг шүүх, шүүн таслах үйл ажиллагаатай холбоотой ер нь шүүхийн хэрэг дээр сүүлийн 10 жилд хөрөнгө оруулалт шийдээгүй байна. Өчигдөр манай Хууль зүйн байнгын хорооноос ярьсан. Энэний тоо их том сонсогдоно оо. Тэгээд энийг нь нэг хэдэн шүүгчид

хуваагаад аваад явах гэж байгаа юм шиг битгий улс төр хийгээрэй.

Энэ шүүхээр хэрэг маргаанаа хянан шийдвэрлэж байгаа авч чадахгүй барьцааны мөнгөө ингээд хохирчихсон маш олон 100 мянган иргэдийн зөрчигдсэн эрхийг сэргээх шударга ёсны үйлчилгээний төлбөр гэж ойлгох ёстой.

Тэрнээс биш нэг шүүгч одоо нэг ямбалаад сайхан өрөөнд суух гээд энэ мөнгө төгрөг яриад байгаа юм байхгүй. Өнөөдөр шүүгчдийн цалин чичсээр байгаад мөрдөгчдийн цалингаас дор байдалд оруулчихсан. Ийм л байдалтай байгаа байхгүй юу. Тийм учраас энэ дээр би бол одоо улс төр хийлгүйгээр бас Их Хурлын.../минут дуусав/.

Г.Занданшатар: 14 цагаас санал хураалт явуулна. Асуулт хариулт дууссаны дараа. 2 гишүүн байна. дэмжсэн дэмжээгүй 3 хүртэлх хүн үг хэлж болно. Ер нь бас Эрдэм-Ундрах Хууль зүйн үндэсний хүрээлэн.

Сэжигтэн яллагдагчийг цагдан хорих баривчлах арга хэмжээний талаар гэсэн ийм бас нэг судалгаа хийж байсан юм байна шүү дээ тэ? Тэрэн дээр зөвлөмжид чинь бас өөр бусад таслан сэргийлэх арга хэмжээнүүдийг авч болох талаар цагдан хорихоос өөр тийм эрх зүйн өөрчлөлт хийх гэсэн юм энэ чинь тусгагдаагүй юм шиг байх юм. 14.9-өөс гадна тэр бусад заалтууд дээр 13 цаг болсон учраас үдээс өмнөх чуулганы нэгдсэн хуралдааныг завсарлуулж байна. 14 цагт энэ 2 гишүүн байхгүй тул хаслаа. Жамбын Батсуурь, Хасуурын Ганхуяг 2 гишүүн. 14 цагт ирээд үг хэлнэ.

ЗАВСАРЛАГА

Г.Занданшатар: Айлтгая Улсын Их Хурлын гишүүдийн өдрийн амгаланг айлтгая.

Улсын Их Хурлын намрын чуулганы 10 дугаар сарын 26-ны өдрийн үдээс хойших нэгдсэн хуралдаан эхэлснийг мэдэгдье ээ. Санал хураалттай учраас гишүүд чуулганы танхимд цуглах хэрэгтэй байна.

Санал хураалт гишүүд чуулганы танхимд цуглая байна уу? Өргөн барихаас өмнө ороод ирвэл гэсэн бодолтой л би байсан л даа. Тэрнээс биш ямар нэг буруу зөрүү ойлголт байхгүй. Бодоорой. Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асууж, хариулт авч дууссан. Дэмжсэн дэмжээгүй үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд байна уу? Дэмжсэн дэмжээгүй үг хэлэх.

Улсын Их Хурлын гишүүд энэ АН-ын бүлгийн гишүүд Ганбат гишүүд дэмжиж үг хэлнэ гээд байсан яасан.

Адъяасүрэн гишүүн ээ ах нь хаачсан юм бэ? Үг хэлнэ гээд байсан. үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд байна уу? Дэмжсэн, дэмжээгүй 3 хүртэл гишүүн үг хэлж болно. Тасаллаа. Цэрэнжамцын Мөнхцэцэг гишүүн үг хэлнэ.

Ц.Мөнхцэцэг: Тэгэхээр Хууль зүй, дотоод хэргийн сайдын оруулж ирж байгаа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд оруулж буй нэмэлт, өөрчлөлтүүд маань хүний эрхийн үүднээс дэмжих ёстой ийм концепц байгаа. Тийм учраас дэмжиж байна. Ер нь хүний халдашгүй чөлөөтэй байх эрх гэдэг бол Үндсэн хууль болон олон улсын хүний эрхийн фактуудаар баталгаажсан ийм эрх байгаа. Тэгвэл энэ сэжигтнийг баривчилна гэдэг үйл явц бол энэ халдашгүй чөлөөтэй байгаа эрхэд халдаж байгаа хэрэг учраас ер нь улс орнууд энэ эрх зүйн үндэслэлийг маш нарийн гаргаж өгдөг.

Тэгэхээр одоо үйлчилж байгаа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31.4, 31.5 дугаар зүйлд энэ

сэжигтнийг ямар тохиолдолд шүүхийн зөвшөөрөлтэй ямар тохиолдолд шүүхийн зөвшөөрөлгүй байрлах тухай үндэслэлийг зааж өгсөн байдаг. Тэгэхдээ манай судлаачид экспертүүдийн үзэж байгаагаар бол тодорхой нөхцөлд энэ Эрүүгийн хууль хянан шийдвэрлэх тухай хуулийн энэ заалтууд бас субъектив байдлаар ашиглагдах тухайн шийдвэр гаргаж байгаа шүүх эрх мэдэлтний хандлага хувийн субъектив үнэлэмжээс хамаардаг учраас ер нь энэ заалтыг бол илүү тодорхой болгож баривчлах энэ үйл ажиллагаанд хүний эрхийг хангах нь зүйтэй гэдэг зөвлөмжийг удаа дараа өгч ирсэн. Мөн Монгол Улсад ажиллаж байгаа олон улсын хүний эрхийн байгууллагууд, олон улсын хүний эрхийн мэргэжилтнүүд яах аргагүй энэ сэжигтнийг баривчлах үйл ажиллагаанд ер нь бас тодорхой асуудал байна гэдгийг хэлж ирсэн байгаа.

Тийм учраас бид нар бол энэ эрүүгийн процессын хууль дахь энэ заалтуудыг оруулах нь зүйтэй. Тэгээд ер нь бол түрүүн сайдын илтгэл болон манай гишүүдийн үгэнд дурдагдсан яг энэ сэжигтнийг баривчлах үйл ажиллагаанд бараг 90 хэдэн хувь нь ерөөсөө шүүхийн зөвшөөрөлгүй баривчилсан байдаг. Тэгээд энэ процесст бол яг хүний эрхийг зөрчих, тухайн сэжигтэн болон яллагдагчийг удаан хугацаанд хорих цагдах ийм процесс давтагдаж ирсэн. Ер нь бол шүүхийн шатдаа бол шүүх хурлууд удаа дараа хойшилдог. Тэр хэмжээгээрээ нөгөө сэжигтэн маань тэнд эрхээ хасуулсан байдлаар маш удаан хугацаа алдаж ирсэн.

Тийм учраас бид нар бол ер нь одоо хүний эрх бол хаана ч хамгаалагдах ёстой. Хэдийгээр сэжигтэн яллагдагч байна уу? Тухайн хүнд олон улсын болон манай Үндсэн хуулийн эрх зүйгээр олгогдсон хүний эрхээ хамгаалах энэ зарчмууд үйлчлэх ёстой.

Тийм учраас бид нар энэ хуулийг бол концепцоо дэмжээд тэгээд хүний

эрхийг бүх шатандаа ялангуяа энэ процессын шатанд буюу хэрэг хянан шийдвэрлэх мөрдөн байцаах шатандаа хамгаалах гэсэн энэ сайдын байр суурь бол үнэхээр чухал алхам болж байна. Тэгэхээр Энхбаяр сайд бол хүний эрхийн дэд хорооны дарга байсан хүний хувьд, хүний эрхийн мэдрэмжтэй хуулиудыг батална гэдгийг бас түрүүн хэлсэн. Ер нь Монгол Улс ардчилсан улсын хувьд бүх хууль тогтоомж бүх үйл ажиллагаанд хүний эрхийг хангах энэ асуудлыг бол одоо байгаа процессын зарим алдаатай гэдэг юм уу, эсвэл цаг хугацааны хувьд хоцрогдсон байгаа энэ хуулиудыг бид нар шинэчлэх шаардлагатай. Түрүүн дурдсан Монгол Ардын нам бол 2021 онд Монгол Улсад үйлчилж байгаа бүх хуулиудад хүний эрхийн анализ хийж тодорхой хуулиудад шинэчлэх зөвлөмжүүдийг өгсөн байгаа.

Тэгэхээр энэ чиглэлээр бас Хууль зүйн яаман дээр ажлын хэсэг гарсан. Ажиллах гэж байгаа нь үнэхээр сайшаалтай байна. Тийм учраас бас бид нар энэ хуулийг дэмжиж байна.

Г.Занданшатар: Нямаагийн Энхболд гишүүн.

Н.Энхболд: Хуулийн төслийг дэмжиж байгаа. Энэ бас олон жил яригдсан заавал шийдэх ёстой асуудлуудыг тусгасан яригдаад шийдэгддэггүй байдаг асуудлуудыг ингээд бас нэлээн зориг гаргаад гэх үү дээ. Сайд барьж аваад боловсруулаад оруулж ирж байгаад би талархаж байна. Түрүүн би 2, 3 зүйл асуусан. Манай хуулийн байгууллагуудынхны өгч байгаа хариултууд эд нар бас жоохон хоорондоо зөрөөтэй нэг нь тийм гэхэд нөгөөдөх нь арай ч тийм ч гэсэн байдалтай зүйлүүд гарч л байна. Жишээ нь тухайлбал тэр гэрчийн мэдүүлгээр нотлох баримт бүрдүүлдэг тухай, өөрөөр нь хэрэг яг шууд хүлээлгэдэггүй ч гэсэн гэрчээр асуугдаж байгаад тэгээд дараа нь гэрчийнхээ үед ярьж байсан зүйлүүдийг нь нотлох

баримтын тийм хэмжээнд авч үзээд байна уу, үгүй юү гэх мэтчилэн асуудлуудаар бас санал бодлын зөрөөтэй юмнууд байдаг юм байна. Энийгээ нэг жигдэл жигдэлж авах хэрэгтэй болов уу гэж бодож байна.

Ер нь сайн ч байсан, муу ч байсан аливаа хууль бол мөрдөгдөж л байх ёстой. Бүгдээрээ ялангуяа энэ шүүх хүртэл явж байгаа үйл явц. Тэр үед мөрдөгдөж байгаа хуулийн хэрэгжилтийг их анхааралтай сайн ажиглаж бүх шатандаа мөрдөн байцаах прокурор шүүхийнхэн маш нухацтай хандаж, яг хуулийн дагуу шийдвэр гаргаж байх нь зүйтэй гэж би бодож байгаа. Тэгж байж л бүгдээрээ хүн болгон хуулийн өмнө эрх тэгш амьдарна.

Нэг том алдартай жишээ байдаг шүү дээ. Америкийн нэртэй хөл бөмбөгийн тоглогч О.Жей Симпсон гэж нөхөр хүн алсан. Хүн алсан нь нотлогддог тийм ээ. Ганцхан нотолж байгаа материалуудыг нь нотолж байгаа зүйлүүдээ хууль зөрчиж олж авсан гэдэг үндэслэлээр хэрэг нь цагаадаад үгүй ээ шийтгэж чадахгүйд хүрээд цагаатгаж байгаа. Алсныг нь бол тогтоочихсон. Ганц хууль зөрчиж нотлох баримт цуглуулсан гээд л тэр хэрэг хаагдчихсан. Тэр нөхөр чөлөөтэй явж байгаа. Тэгэхдээ хэн ч биш болсон л доо хэн ч биш болсон.

Тэгэхээр ийм юмнууд дээр бид нар их анхаарах хэрэгтэй байгаа юм. Тийм учраас би түрүүн яг зөвхөн мэдүүлэг энэ субъектив зүйлүүдээс гадна яг бодитой яг хуулийн дагуу бүрдүүлсэн нотлох баримтуудыг баримталж, тэд нарыг бэлдэж, шүүхэд танилцуулж ажиллаж байх чухлын талаар бодож тэр хэдэн асуултуудыг асуусан юм байгаа юм.

Тэгээд дахиад хэлэхэд энийг дэмжиж байна.

Хэлэлцүүлгийн явцад хэдүүлээ ярих юм байвал тэрийг нь нэмээд засаад

хасаад явах ийм боломж байгаа байх гэж бодож байгаа юм.

Г.Занданшатар: Зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Сайнбуянгийн Амарсайхан, Цэндийн Сандаг-Очир нарын урилгаар Багахангай дүүргийн иргэдийн төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд гишүүдийн нэрийн өмнөөс сайн сайхныг хүсье ээ.

Ганибалын Амартүвшин гишүүн үг хэлнэ.

Дараа нь санал хураалттай.

Гишүүд чуулганы танхимд цуглаарай. Асуулт хариултын цаг дууслаа.

Г.Амартүвшин: Баярлалаа.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулж байгаа энэ төслийг ерөнхийд нь дэмжиж байгаа юм. Хүний эрхтэй холбоотой энэ маш чухал асуудал. Сэжигтэн яллагдагчийг баривчлах ажиллагааг илүү тодорхой болгох, нарийвчлан зохицуулдаг ийм механизмтай болж байгаа нь маш зөв өө. Би хуульч хүн биш ч гэсэн өөрийнхөө бас нэг туршилага гэж хэлэхэд хаашаа ч юм болсон явдлаас ярихад бол ер нь ингээд Хөгжлийн банкны хэрэг дээр бол гэрчээр мэдүүлэг авдаг, эхлээд дуудна, гэрчээр мэдүүлэг авна. Тэгсэнээ гэнэт ямар ч тайлбаргүйгээр яллагдагчаар татдаг, нэгдүгээрт.

Хоёрдугаарт, одоо тэр Хөгжлийн банкны шүүх хурал дээр нээлттэй явсан тэгээд бүгдээрээ л үзсэн л байх л даа. Тэрэн дээр яадаг гэхлээр зарим тэр яллагдагчаар татагдсан хүмүүс нь ярьж л байна лээ шүү дээ. Одоо бид нарыг ингээд 461-д хийнэ гэж айлгаж байгаад ямар нэгэн байдлаар тэр гишүүний нэрийг хэл гэж тулгасан байдал хүртэл илэрсэн байгаа байхгүй юу.

Тэгэхлээр иймэрхүү өөрөөр хэлбэл Мөрдөх алба, энэ цагдан хорих баривчлах хэрэгслийг яг нөгөө хэрэг илрүүлдэг гол нотлох баримтаа цуглуулдаг механизм хэрэгсэл нь болчихоод байна л даа. Болчихоод байсан юм шиг байгаа юм. Тэгэхлээр энэ одоо оруулж ирж байгаа хуулийн төслийн гол утга санаа нь болохоор энийг цэгцэлье ээ. Танилцуулгууд байна л даа. Сүүлийн 3, 4 жил нийт цагдан хоригдсон кэйсүүдийг харахад 95 хувиас дээших нь ямар нэгэн шүүхийн шийдвэргүй хийгдсэн байна гэж. Тэгэхлээр энэ маш зөв.

Хоёрдугаарт энэ эрүүгийн хэрэг ер нь ингээд үүсгээд хэн нэгнийг яллагдагчаар татахад мөн л адил энэ Хөгжлийн банкны хэрэг дээр бол ер нь бусдын мэдүүлэг, зөвхөн бусдын мэдүүлгээр энэ нөхөр ингэсэн байна лээ. Нэг бичлэг үзүүлээд өө энэ 2 чинь ингээд хамт нэвтрүүлэгт орсон байна лээ. Тийм болохоор ингээд хоорондоо хамааралтай юм байна гэсэн иймэрхүү байдлаар бусдын нэг тийм субъектив мэдүүлгийг үндэслэж хэрэг үүсгэдэг энэ явдлыг бас цэгцлэх ёстой. Би бол гишүүдийн асууж байсан асуултыг сонсоод мөн Энхбаяр сайдын хариултыг сонсоход дараагийн шатанд энийг өөрчилж илүү бас нарийвчилж зохицуулах юм байна гэж ойлгосон.

Тийм болохоор энэ одоо өнөөдөр бид нарын хэлэлцэж байгаа, хэлэлцэх эсэхийг нь хэлэлцэж байгаа энэ нэмэлт өөрчлөлт болохоор энэ цагдан хорихтой холбоотой нарийн зохицуулалт.

Хоёр дахь шатных нь болохоор энэ нэг эрүүгийн хэргийн нотлох баримт бусдын мэдүүлгийн талаар бас тусгай зохицуулалт орж ирэх юм байна гэж ойлгож байна. Тийм болохоор миний хувьд энэ хуулийн төслийг дэмжиж байна.

Г.Занданшатар: Гишүүд үг хэлж дууслаа.

Одоо санал хураалт явуулна. Бүлгийн дарга нар гишүүдээ дуудъя.

Дэд дарга нар ирцээ бүрдүүл.

Энэ Хууль зүйн үндэсний хүрээлэн 2022 онд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд үнэлгээ хийхдээ цагдан хорих, таслан шийдвэрлэх арга хэмжээний зохицуулалт гэсэн сэдвээр хийсэн юм байна лээ. Тэгээд тэрний зөвлөмж хэсгүүд дээр заасан заалтуудаас Хөдөлмөрийн хуулийн 55.10-ыг өөрчилнө гэсэн байна лээ шүү дээ. Тэр заалт эд нар чинь дагалдаж орж ирээд зайлиггүй байсан юм уу үгүй юу. Танай тэр зөвлөмж дээр байгаа саналуудаас хэлэлцүүлгийн явцад анхаарвал зүгээр байна. 55.1-ийн цагдан хорих гэсэн таслан сэргийлэх арга хэмжээ авах гэж нэмэх. Хууль бусаар хоригдсон эс үгүй бол цагаатгагдсан этгээд нь цагдан хоригдсон хугацааны хохирлоо гаргуулж авах эрхийг шуурхай эдлүүлэхээр хуульд өөрчлөлт оруулах шаардлагатай гэж.

Хэрвээ хууль бусаар цагдан хоригдсон кэйс үүсэх юм тэрнийгээ нэхдэг болчихвол дараа нь бас энэ чинь нэг ийм хяналтын механизм гэсэн ийм санаа байсан. Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн юун дээр. Суллах чөлөөлөх бас өөр. Таслан сэргийлэх арга хэмжээгээр солих эрх зүйн зохицуулалтыг нарийвчилсан байдлаар Эрүүгийн хуульд хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд тусгах гэж.

Өөрөөр хэлбэл нөгөө гав зүүдэг болчихсон. Бас тэгээд л тэр хүнтэй уулзаж болохгүй энэ тэр гээд л өөр хөтөлбөрийг таслан сэргийлэх зохицуулалтууд байж болох агуулга тэр зөвлөмж дээр бичсэн юм байна лээ. Тэрнийг яах вэ, тэгээд л зөвлөмж дээр тэгээд бичсэн тэрнийгээ анхаарч үзээрэй л гэж байгаа юм.

Ер нь тэгээд бүх юманд л нөгөө тал байгаа учраас би тэр процессыг нь, шударга ёс чинь л яаж яах вэ? Үг хэлээд

дуусчихсан. Энэ чинь ингээд нэг цогц систем учраас цогц байдлаар яахгүй тэр нотлох баримтын цогц байдлын талаар яриад байх шиг байгаа юм. Тэр зөвхөн мэдүүлгийн нотлох баримтаас гадна бид нотлох баримт хоёр нийлж байж цогц баримт болохдоо тэр гэмт хэргийн бүрэлдэхүүний асуудлыг бас эргэж, объектив, субъектив бүрэлдэхүүнийг зөвхөн үйлдлийнх гэж ялгах юмнууд дээрээ бас энэ систем цогцоороо ингэж шийдэхгүй бол ингээд хэсэг хэсгээрээ өөрчлөлтүүд нь сүүлдээ бүх системдээ хүнийг хууль бусаар хориод байвал тэгээд тэр чинь бас эргээд л хохирол нэхэмжлэх шаардлага бас байх нь. Тэрүүнийг заавал шийтгүүлэх гээд байгаа тэр юмыг нь бас хаах өөр механизмаар зохицуулахгүй бол тэр энэ тэрийгээ тэгээд та хэд Хууль зүйн байнгын хороон дээрээ сайн ярина биз дээ. Зүгээр би энэ зөвлөмжийг нь л ярьж байгаа юм. Энэ цаг хүлээх зуур.

Ингээд санал хураалт явуулъя. Мөнхбаатар дарга аа, Одонтуяа дарга та 2 нааш ир дээ. Тусгай хяналтын дэд хороо хуралдаж байгаа юм байна санал хураалтад бэлтгэ.

Байнгын хорооны саналаар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна.

Санал хураалт явуулахад бэлэн үү?

Энэ Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн сая байсан. Сангийн сайд Болдын Жавхлан, Мөнхөөгийн Оюунчимэг 2-ыг дууд. Түүрүүн гүйгээд явж байсан хаачсан юм. Адьшаа гишүүн суудалдаа санал хураалт явуулах гэж байна.

Санал хураалт.

57.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төслүүдийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул уг төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлж байна.

14.22 цагт

Дараагийн асуудалд оръё.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ. Хариуцсан холбогдох Засгийн газрын гишүүн байхгүй байгаа учраас хойшлууллаа. Маргааш өглөө хэлэлцэнэ ээ.

АН-ын бүлгийн дарга бас энэ Газрын тухай хуулийн хэлэлцүүлгийн асуудлыг урагшлуулж өгөөч гэсэн. Завсарлагын хугацаа дууссан учраас хэлэлцье гэсэн санал гарсан. Тийм ажилтай болсон учраас тийм бас саналыг нь харгалзаж байгаа юм.

Аль аль талын саналыг харгалзаад энэ сайд нь ийм ажилтай оролцох боломжгүй байгаа учраас. Нөгөө талаас АН-ын бүлгийн завсарлагын хугацаа дуусаад энэ харин тийм 2 бүлгийн дарга тийшээ явчхаад. Тэгээд би одоо өмнөөс нь тэрийг нь хэлж байна. Тэгээд хэлэлцэх асуудалдаа оръё. 2 бүлгийн дарга ярилцаад энэ асуудлыг хэлэлцье гэдэг саналаа өгчхөөд тэгээд ажилтай гараад явчихсан байгаа.

Ингээд Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлыг үргэлжлүүлэн хэлэлцэнэ ээ.

2023 оны 10 дугаар сарын 20-ны өдөр уг асуудлаар Улсын Их Хурал дахь АН-ын бүлгийн дарга Одонгийн Цогтгэрэл

ажлын 4 хоногийн завсарлага авсан. Завсарлагын хугацаа дууссан байна. Завсарлагын хугацаа дууссантай холбогдуулан үг хэлэх үг хэлэх үү? Бүлгийг орлож байгаа хүн дэд дарга байхгүй юу. Тэгвэл үг хэлэхгүй. Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулсан байгаа. Гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууссан. Санал хураалт явуулна.

Тэр 18.1.10 болон 18.13 байлуу дарга таны яриад байсан. 18.3-т өөрчлөлт оруулах, буцаах ийм зарчмын зөрүүтэй саналаар 2 бүлгийн дарга нар тохиролцсон байна.

Ингээд Байнгын хорооны саналаар Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна.

Гишүүд суудалдаа суугаарай.

Ширнэнбандийн Адъяаа гишүүн суудалдаа суу. Санал хураалт явуулах гээд байна.

Дэмжинэ дэмжинэ. Дэмжээд янзалъя гэж тохирлоо. Ингээд 57.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төслийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тооцон анхны хэлэлцүүлэгт бэлтгэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлнэ.

Өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлууд дууссан тул чуулганы нэгдсэн хуралдааныг хаалаа.

14.26 цагт

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ П.МЯДАГМАА

